

Д.БАТБАЯР

ЦАХИЛЖ ЯВАА ГӨРӨӨС



Д.Батбаяр

Цахилж яваа гөрөөс

www.kicbooks.com

ЦАХИЛЖ ЯВАА ГӨРӨӨС

- Ээжээ баруунтайгаас нэг морьтой хүн айсуй гэсэн үг түүнийг тэр зүг харахаас өмнө хамаг биеий нь зарсхийлгэхэд өргөж байсан чулуугаа Дэжид золтой л алдчихсангүй. Дээрээс нь гэнэт хүчтэй тавьсан чулуунд шахагдсан аарцны шар ус уутаа нэвчин гутал руу нь годхийв. Тэр хөлөө зайлуулсан ч үгүй, аарцан дээрх чулууныхаа хазгайг тэгшилж байлаа. Хэлтгий бол жигд шахагдахгүй, зүсэхэд бутарч ойчоод байх болно гэж бодсондоо ийнхүү тэгшилж байгаа бус ерөөс энэ ажлыг хар нялхаасаа гуч хүртлээ хийж дадсан дадлаараа л хийх бөгөөд ухаан санаанд нь мөн гэдгээс өөр юу ч үл бодогдон өөрийн эрхгүй тэр зүг харвал үнэхээр мөн байсанд сэтгэл нь харанхуйлан хоолой дээр нь ямар нэгэн юм тээглэн шүлс нь залгиж болохгүй болчих шиг болов. Эхийгээ айсуй яваа морьтны зүг харахыг хүлээн зогсож байсан хүү нь: - Аав мөн үү? Ээжээ? гэж асуугаад дахин тэр морьтны зүг хэсэг харж зогссоноо эхийнхээ хариу хэлэхийг ч хүлээхгүй

- Мөн байна, мөн байна гэж хашгиран гэртээ гүйн орлоо. Урьд нь хүүгээ ингээд ороход нь "Хүүе чи галдаа аргал хийгээрэй" гэх юм уу эсвэл "Яах чинь вэ, чи" гэж хойноос нь хашгирдаг байлаа. Энэ нь шинэ махтай үед хоолоо хийхдээ "Өнөө шөнө аав нь ирж магадгүй, ирээд идэг" гээд чанасан дал, хэдэн хавирга, цорой ч юм уу ямар нэгэн бүхэл махны тухай үг бөгөөд хүү эцэгтээ мөнөөхийг өгөх гэж ямагт яарч шон дээр буухад өөдөөс нь бариад гүйх нь халаг болдог, эх ч "Байз гэм чи яасан тавьтиргүй монд вэ" хэмээн загнах өхөөрдөх хослон хоцордог байв. Энэ удаа ч хүү мөн эцэгтээ тавьсан юм руу явж байгаа нь тэр аж. Дэжид хүүгээ гэртээ орохыг мэдээгүй юмуу, тэрийг анзаарах сэхээ байхгүй ч байгаа юм уу юу ч хэлсэнгүй. Эргэн тойрондоо болж байгааг ч мэдрэх завгүй юм шиг нэг ажлаас нөгөөд шилжин хажуугаас харах хүнд бол ажилдаа түүртэн эр нөхрөө ирж байгааг мэдэх янзгүй байх шив дээ гэхээр байх авч Дамбын хэрхэн ирж яваа, хотынхоо хаагуур тойрч хэдэн хормын дараа шон дээр буухыг нэгд нэггүй мэдэрч ойртох тусам нүүр учрахаасаа эмээх мэт аар саархнаар оролдон энд тэнд унасан ойчсоныг өөд татах аядана. Дамбыг эрэл сурал, аймаг сум орохоор хэд гурав хоногоор эзгүй яваад ирэх бараагий нь харангуут царай зүс нь гэрэлтэн нүүр рүүгээ унжсан үсээ хойш илж, үргэлж толгой дээр явах, нар салхинд онгож хээ нь ч мэдэгдэхээ больсон алчуураа засч, яаран сандран гэртээ орж юм хумаа цэгцэлдэг байснаа чухам хэдийнээс больчихсоныг өөрөө ч үл мэднэ.

Дамба гэрийнхээ зүүн урдах дэрсэн доторхи тугал, цаахнах худаг сахисан хоёр адуу сэлтрүү хараа тусган явснаа тогоо барин гэртээ орж яваа Дэжидийг хармагцаа дотор нь палхийн "юу гэх бол" гэсэн бодол дахин орж ирэв. Энэ бодол түүнд урьд өмнө нь олонтаа бодогдсон бөгөөд тэгэх бүрийд ингэх байх, тэгэх байх гэсэн таамаг гарган, тэгэхээр нь ингэнэ, ингэхээр нь тэгнэ гэсэн жин тан хариулт зэхчихсэн хэрнээ гэр нь ойртох тусам дахин дахин бодогдон, мөнөөх жин тан хариулт нь алга болж гагцхүү "юу гэх бол, яах бол" гэдгээс өөр юм ухаан санаанд нь орсонгүй. Унасан морь нь сурсан зангаараа уяанд ойртож ирээд зогсоход тэр сая гэрийнхээ гадна ирснээ мэдрэн, мориноосоо буухаас ч, гэртээ орохоос ч халшран, буцаад явчихмаар ч санагдан "хүү яачихав аа, Эзгүй байгаа юм болов уу" гэж бодов. Зуны дэлгэр цагт хааяа хэд гурав хоногоор айраг архи, найр цэнгэл хөөж яваад ирэхэд нь угтан гүйж ирэх хүүдээ баярлан, хүүгээрээ ул барин гэртээ орж нүүр хагардаг байсан нь нэг бус билээ. Бууж морио уях, дээл хувцсаа засах, гэрээдээ алхах энэ бүхэн нь ер бусын удаан бөгөөд гэр уяа хоёрынхоо хооронд ийм удаан явж байгаагүйгээ өөрөө ч анзаарахаар аажуу алхаж явтал хүү

нь сая гэрээс гарч ирэн томдсондооо гадагшаа майжийчихсан бахиал гутлаа пар пар дуугарган гүйсээр тосон ирэхийг хараад "муу хүү минь гуталгүй болж дээ" хэмээн бодож амжив. Хүү нар салхи үнэртсэн данхар толгойгоо эцэгтээ үнсүүлээд,

- Ааваа, хүрэн үрээ ижилдээ хүрээд ирчихсэн гээд гараас нь хөтлөн гэрийнхээ зүг явангаа,

- Та буруу эрээд л яваад байсан юм уу гэхэд Дамба,

- Тийм гэж хүүгийнхээ амыг дагуулан хариулсан боловч яах гэж тэгж хэлсэн, тэгж хэлэх хэрэгтэй байсан үгүй г ч бодсонгүй. Тэр хоёрын гэрт ороход Дэжид зуухны ам хавьцаа намхан модон сандал дээр сууж байлаа. Дамба явсаар хоймороо гарч завилан суув. Хол ойр юманд явж ирээд ямагт энд суун малгайгаа авч хоймрын авдар дээрх жаазтай зурагны өмнөх өрөөсөн хөлөө жийн хэвтэж байгаа хүрэл гөрөөсний хажууд тавиад өврөө уудлан дурангаа гаргаж "май, миний хүү энийг тэр жаазны араар тавьчих" гээд хүүдээ өгдөг заншилтай аж. Энэ удаа ч гэсэн мөн тэр заншлаараа малгайгаа авч тавьдаг газраа тавиад өврөө уудалтал дуран нь алга байв. "Үгүй энэ чинь би дурангаа арай..." хэмээн бодсоноо гэнэт хаа байгааг нь санасан тул хоосон гараа өврөөсөө гаргахдаа эхнэр рүүгээ зэрвэсхэн харав. Дэжид түүнийг анзаарсан шинжгүй, тогоотой цайгаа сүлж байлаа. Дамба юу ч болоогүй мэт ихэд тайвнаар гаанс хүүдийгээ гарган тамхи нэрэх зуураа:

- Манай хонь хаа яваа юм, ойр хавь ер юм харагдсангүй гээд Дэжид рүү харсан боловч цаадах нь дуугарсангүй. Харин хүү нь,

- Зүүн хойно яваа, өнөөдөр Багаагийн хонины ээлж. Маргааш манайх. Та хар морь бариад өгөөрэй. Гараар ганц ч баригдахгүй байгаа юм гэхэд Дамба,

- Чи унаж чадах юм уу. Хээр буухаар чинь эргэцээд мордуулдаггүй сэн биш билүү?

- Чаднаа хадан дээр гарч байгаад мөрдчихдог юм чинь.

- Аан.

Данханд цай уудлах, тамхи сорох чимээнээс өөр ямар ч анир үл гарах нь гаднаас орж ирж яваа хүнд эзгүй айл юм уу гэж бодогдуулахаар ажээ. Дэжид данхтай цайгаа Дамба руу дөхүүлж орхиод аяганы шургуулганаас том шаазан гаргаж урд нь тавив. Дамба аягыг авч цай хийлээ. Энэ үед орны хөл дэх авдар ухаж байсан хүү, - Ээжээ, аавд тавьсан мах яасан бэ, эрээд олодохгүй юм гэхэд Дэжид эргэнэг дээрээс тавагтай мах авч хүүд өгөхөд тэр машид хичээнгүй хоёр гардан барьсаар явж эцгийнхээ цайны дэргэд тавиад хутга авч өгөв. Дамба махнаас хоёр хавирга авч махыг нь хэрчин хүүдээ өгөөд аягатай цайгаа авч удаан гэгч нь оочлох зуураа тогоо угааж байгаа Дэжидийг харж "Анхиагүй гэдэг нь. Ядаж чи наад үс гэзгээ өөдтэйхэн самначихад яадаг юм" гэх гэснээ "Хүнээр хэлүүлэх ч юү байхав дээ. Гуч хүрчихсэн хүүхэн орон гэр, хувцас хунараа өөд нь татаад явж чадахгүй юү байх вэ. Залхуу залхуу гэхэд дэндүү юм" хэмээн бодож дургүй нь хүрч суув. Чухам урьд өмнө нь ийм байлуу үгүй билүү. Яагаад би өнөөдөр анзаарч харах болов гэсэн бодол түүнд төрсөнгүй. Харин анхиагүй новширч ноорсон байдал нь шон дээр буухад зүрхшээн халирч байсан түүний сэтгэлийг огт тайван хүйтэн болгожээ. Дэжид тогоо авч гадагш гарснаа:

- Цэдэн-ишээ, тугал ус руу явлаа хэмээн дуудахад хүү зулгааж байсан хавиргаа аяганы шургуулга руу хандуулаад гүйн гарав. Дэжид хүүтэйгээ зөрөн орж ирээд түрүүчийн сууж байсан газраа суун зуухны амыг тар хийтэл онгойлгоод аргалын дөрвөлжнөөс хатсан хөх хомоол авч зуухны ам руу чулуудангаа:

- Нэгэнт л чи цаанаа хань бүлтэй болчихсон юм бол чи бид хоёр ингэж яваад яахав, эртхэн хоёр тийшээ болсон дээр гээд гал нь унтарсан зуухан дахь аргалын асах эсэхийг хүлээх мэт зуухны харанхуй ам руу ширтэв. Дамба Дэжидийг ийм үг хэлнэ чинээ огт санасангүй. Хаа нэг ам муруйхдаа ч салах сарних үгийг хэлэн нь бүү хэл өөдөөс нь хараал ч хэлж яваагүй, эзгүй хойгуур нь хонь малаа бүрэн бүтэн адуулаад болоод байдаг хэрнээ юүхэн дээр ч ингэхүү, тэгэх үү хэмээн ямагт түүний амыг харж түүнээс өөр эр хүн орчлон дээр үгүй юм шиг явдаг Дэжид ийм үг хэлнэ гэж хэн санах вэ. Гагцхүү энэ үг "Дэжид мэджээ" гэдгийг харуулж байна гэж Дамба мэдэрч байлаа. Энэ мөч хүртэл зэргэлдээ бригадын Дэлэг өвгөний охин Тогоохүүгээс Дамба салж хагацаж чадахаа байчихаж гэсэн дэл сул яриа Дэжидийн чихэнд хүрээгүй, хүрлээ ч тэднийд байна гэснээс юү хэтрээ аж гэж санаж явснаас биш бүр иймдээ тулахаар лавтай мэдсэн гэж Дамба бодоогүй юм. Тэр хоёрын явдал ч ингэтлээ даамжрах юм гэж хэн хэн нь санасангүй. Тийм дээрээс ч Тогоохүүтэй ханилах нийлэх тухай нэгээхэн ч удаа яриагүй аж. Гэвч Дамба хурал цуглаан, адуу малын эрэл сурлаар гадагш зүглэх бүрдээ Тогоохүү рүү татагдаж, хаанаас ч гэсэн тэднийхээр дайрч, унагы нь татаж өгчихөөд ч болохноо мордьё хэмээн хоргодсоор, нэг мэдэхэд орой болж хонох өнжихөд хүрдэг бөгөөд маргааш нь хонож өнжчихсөндөө бантан харихаасаа зүрхшээн хулгасаар өдрийг авч үдшийг үзэн хоног алгуурласаар хоёр гурав ч хоночихдог болсон учраас Дэжидийн энэ үг Дамбын бодоогүй хэрнээ хүсэн хүлээж явсан ганц үг нь юм шиг айх ч шиг, баярлах ч шиг болж, бас тулгамдсандаа юү хэлэхээ мэдэхгүй дэмий л гаансаа амандаа зуун асаагаагүй тамхиа хий сорж суув. "Юү, чи юү ярьж байгаа юм. Тэгж салж сарнихад тулахаар юү болсон юм" гэсэн үг дуулах гэж Дэжид энэ үгийг хэлсэн юм шиг хариу хүлээн азнаснаа гунигтайхан санаа алдаж,

- Авья л гэснээ аваарай. Бид ... гээд түгдрэн зогссоноо:

- Бид хоёрт энэ их юмны хэрэг юү байх вэ дээ гэхэд Дамба өврөөсөө чүдэнз гарган шархийтэл хавирч тамхиа асаангаа:

- Би юү ч авахгүй гэв. Энэ үг зүрхийг зүсэх шиг болов. Эдүгээг хүртэл Дэжидэд нэгэн бат итгэл оршиж ,тэрхүү итгэл нь түүний сонссон дуулсан болгоны эцэст арай үгүй байх гэсэн эргэлзлийг төрүүлдэг байжээ. Дэжид, Дамбын тухай сонссон дуулсанаа эргэн бодож, бодох бүрийдээ энийг хэлсэн хүн хэн билээ. Үнэн үг хэлэх хүн билүү, үгүй билүү хэмээн эрэгцүүлж, нуруутай хүн сэн гэж бодохтойгоо зэрэг гол нь харлан "Олхиогүй худалч хоосон ховсоргон хүний амнаас дуулсан ч болоосой" хэмээн харуусахдаа Дамбад бус мөнөөх муу ёрын үг тээж авчирсан хүнд уур нь хүрч тийм үг хэлснийх нь төлөө мэндлэхэд нь дуугарахгүй болчих юмсан гэж нэг бодож удаж төдөлгүй ийм муухай юм бодсондоо өөрийгөө зэмлэн "хөөрхий минь надад мууг хийе гэхдээ л хэлэв гэнэ ч, сайн сайхан санасандаа, нэр түвшин яваасай гэхдээ л хэлээ биз. Миний энэ муу санасан тэр хүний үйлст муугаар тусчих вий" ч гэж бас бодно.

Ингэж түүнийг зөвтгөн бодоод ирэхээ түүний хэлснийг үнэмшихэд хүрч Дамбад гомдох

гомдол нь ихсэнэ. Энэ нь Дамба бол миний эр нөхөр. Тийм ч учраас надаас өөр хэн ч түүнийг хайрлах эрхгүй гэж бодохдоо ийнхүү гомдож байгаа бөгөөд харин хэдийнээ хүний болчихсон хүнийг хүнээс харамлаж байна гэж Дэжид өчүүхэн ч бодохгүй байлаа. Тийм бодол Дэжидийн сэтгэлд багтдаг ч үгүй билээ. Үнэн юм биш байгаа хэмээн бодож гол нь харлах бүрийд Дамбатай учирсан анхны учралаа эргэн санадаг байв. Дамба Дэжид хоёр бол бие биесийг удам судраар нь мэдэх нэг дорын хоёр билээ. Дамбынхан бол нутаг усныхандаа хүндлэгдэж нэрд гарчихаагүй, тэднийхэн өөдгүй гэж хэлэгдчихээгүй, амьтан ах дүүгийн аясаар амьдрал ахуйгаа бөөцийлөөд л явдаг улс. Эх үглээ, залхагдуу цагаан цайлган авгай. Эцэг дуу цөөтэй, эргэх дөрвөн цагт адуу мал сураглан шогшиж явдаг өвгөн. Дүү охин нь хүнтэй суугаад Чойр явчихсан бөгөөд зуны цагт ирж эхийнхээ тогоо шанаганы ажлаас элбэлцэж байгаад буцдаг, гуч хүрч яваа хүүхэн бий. Дамбын аав ээж хоёр Дэжидийг бэрээ гэж нэг их сүйд болдоггүй ч бэрдээ ам муугүйн дээр тэнхэл тасрах цагтаа хүү бэр хоёроо барааднаа гэж ярьдаг хоёр аж.

Дэжид хадмуудтайгаа айл саахалт яваа улсыг хараад заримдаа атаархах авч хол хөндий байгаа нь юүхэн хээхэн дээр үглэж яншаад байхгүй амар ч юм шиг санагддаг байлаа. Дэжид эхээс дөрвүүл. Том эгч нь Улаанбаатарт, удаах ах нь малын бэлчээр уулзах газарт, бага эгч нь аймгийн төвд суудаг бөгөөд эх нь отгон охин Дэжидээ бараадан хаяанд нь амь зууж явсаар гурван жилийн өмнө өөд болжээ. Эцэг нь хар нялхад нь нас барж, эгч ах нар нь айл гэр болж ам даанс тусгаарласан болохоор гэр малын ажилд ганц бие хүрэлцэхгүй байна гэдэг нэрийдлээр эх нь Дэжидийг долдугаар ангид орох намар сургуулиас нь гаргасанд тэр сургуульдаа сууна барина гэж зүтгэсэн ч үгүй эхийн аяс даган мал дээр гарч, гэр бараа, идээ цэгээ, нүүдэл суудал гэсээр арван зургаа хүрэхэд нутгийн харцуул нас намба бүрдсэн хүүхэн хэмээн үзэж ярих хөөрөх, тоглох наадахдаа хорь хүрсэн бүсгүйтэй ярьдаг харьцдагийн нэг адил ярьдаг харьцдаг болж ирсэн нь нэгэн бодлын сайхан ч юм шиг, нэгэн бодлын ичмээр ч юм шиг санагдаж явсан тэр үед тэднийхээр бууж мордохдоо саатан тугал ивэлгэх, саах нийлүүлэх зэрэгт санаагаараа тусалдаг, хүний нүд хариулан гарыг нь атгадаг хүн Дамба болжээ. Тэр үед Дамба цэргээс дөнгөж халагдаад ирчихсэн, хорь хүрч яваа Дэжидийг бодвол хүүхэд зангаа аль хэдийн орхисон залуу байв.

Дамбын ийм ойр дотно байгаа нь Дэжидэд аятайхан санагдах авч загнах болов уу, элдэв юм асуувал юугаа хэлнэ хэмээн эхээсээ айх, нутгийн тохитой томоотой хөгшчүүл буугаад мордохдоо зэмлэнгүй хараад ч байх шиг санагдах зэргээс болоод хурдхан яваасай гэж бодно. Нөгөө гэвэл "Цаадах чинь Хорлоотой явж байгаад болчихсон юм..." гэх үеийн бүсгүйчүүдийн үг бас голыг нь гонсойлгоно. Иймэрхүү юмыг олон жил айл саахалт явж үзсэн дуулсан хамаг нууцаа бие биендээ хэлж сурсан найз бүсгүй Дулам нь хүртэл ярина. Нээрэн ч тэдний хэлдгээр хэд хоног ашиглаж байгаад хаячихна гэгч нь болох болов уу гэж санан дараа ирэхээр нь "Чи тэр Хорлоогийндоо очиж тугал бяруугий нь ивэлгэхгүй юү" гэж хэлье хэмээн боловч царайгий нь харахаараа хэлж үл зүрхлэхийн дээр тэгье л дээ гэсэн шиг мордоод явчихвал яана гэж битүүхэн айна. Түүгээр ч барахгүй хэд хоног ирэхгүй болчихоор нь гарч орох нь ихсэн хурга тугалын хойноос мордох авч гэрээсээ өчүүхэн холдон толгодын цаана орохоороо эзгүй хойгуур ирээд явчих юм биш байгаа гэхдээ гэрээдээ эргэн яарч тугал хургаа учиргүй элдэн элдсээр гэрийн бараа харж гаднаа ямар ч морь байхгүйг хармагцаа урам нь хугарч сажлахын ихээр сажлан түүнээсээ болж "яасан удаан явдаг юм. Сажлаад л байх юм. Хүн чинь ардах ажилдаа яардаг байгаа даа. Нэг юм хийхээрээ нөгөөхөө мартчих юм" гэж эхдээ

үглүүлэх авч "За за битгий яншаад бай хийж л байна даг" гэхчлэнгийн уцаарласан хариу хэлдэг болсон тул эх нь тэгэхийгээд дуугүй болдог билээ. Ер нь сүүлийн үед эх охин хоёрын харьцаа их өөрчлөгджээ. Хар нялхаасаа аашилж, загнах үгийн хариу хэлж сураагүй л юмсан. Цаг нь ирж надад загнуулахаа болжээ ч гэж санасан уу, үр хүүхдээ томорч байгааг анзаарахгүй дэмий үг хэлж мулгуутлаа ч гэж боддог болсон уу элдэвт үг дуугарахаа больж, яах вэ, ийх вэ хэмээн асуух болжээ.

Эхийнх нь ингэж өөрийн зоргоор байлган болсон нь Дамбыг ирэхэд чөлөөтэй ярьж хөөрч, инээж хөхрөхөд хүргэсэн бөгөөд эх ч тэдний явдлыг гадарласан мэт Дамбыг ирэхээр араг үүрээд хээр явчих ч юм уу, эсвэл юм хум өөд татах дүр үзүүлэн нэг хэсэг гадаа байж байгаад айлд ороод алга болчихдог байлаа. Дамбыг ирсэн нэг орой ядраад гэдэг нэрээр эртээ орондоо орон цааш харан хэвтжээ. Үнээ саах, сүү хөөрүүлэх мэтийн хамаг ажил Дэжидийн толгой дээр ирсэн хэдий ч энэ бүхнийг Дэжид гадаа бол Дамбатай инээж хөхрөн, гэрт бол хоёул шивнэлдэн байж тээр орой ажлаа дуусч унтах болоход анх удаа Дамбад унтах ор зассангүй. Түүнээс хойш ил цагаандаа гарчээ. Мөнөөх үнэн худал нь мэдэгдэхгүй яриаг магадгүй гэж бодох болгонд анхных нь тэр үдэш дурсагдан, зүрхийг нь шимшрүүлэхэд хоолой нь зангирч нүдний нь аяганд нулимс дүүрэн чавчихад уначихаар мэлтэгнэн ирнэ. Ийм үед Дэжид шүд зуун шүлсээ залгин нүдээ чавчихгүйг хичээдэг байжээ. Зүй нь нэгэнт мэлмэрэн ирсэн юм, цээжээ тэнийтэл уйлчихвал дотор нь онгойх байтал нулимс унагахгүйг ингэтлээ хичээдэг нь цаанаа учиртай аж. Уйлмаар болохтойгоо зэрэг л "яасан гэж усан нүдлэх билээ, өөрийнхөө нүдээр ямар үзсэн биш. Өөрийнх нь амнаас дуулсан биш. Мухар сохор юм сонсчихоод уйлж унжиж яаж болох вэ. Худлаа байвал яах юм" хэмээн бодож харин ч юу юуны туханд хүрэлгүй усан нүдлэх мууг дуудсантай л адил гэж сэжиглэн нэг ч нулимс унагахгүйг бодно. Гэтэл худлаа хэмээн бодох гэж чармайх тусам нь элдвийн юм санагдана.

Заримдаа хөх торгон дээлийг шар дурдан бүсээр хотын хүүхнүүд шиг хөхийг төвийлгөн, биеийг жавхайлган ороож, өсгий өндөр цагаан шаахай өмссөн бурзгар хар үстэй хүүхэн цай аягалан гэрийн хойморт нөмгөн сууж буй Дамбад өгөхөд Дамба инээмсэглэн авч байгаа мэт санагдахад уур нь хүрч, Дамбыг авахын зуургүй аягатай цайгий нь замаас татаад асгачих юмсан гэж ч хүртэл бодчихсон байгаагаа гэнэт мэдрэн энэ бүх бодлоо мууд тооцон сэтгэлээсээ хөөхийг эрмэлзэн, "одоо ерөөсөө элдвийн муу юм бодохгүй. Юу гэж юу ч болоогүй байхад муу юм болох билээ" хэмээн өөрийгөө тайвшруулахыг хичээн алдсан үрээгээ хөтөлчихсөн ирж яваагаар, гэртээ орж ирээд инээмсэглэн сууж байгаагаар бодох бөгөөд ингэж бодох зуураа "манай Дамба чинь ямар сайхан шүдтэй юм дээ" хэмээн сэтгэлдээ үзэж буй дүрээс урьд өмнө нь анзаараагүйгээ анзаарч "эр хүнийг морь, шүд хоёр л чимж явдаг юм байна даа. Пунцагийнхаас ав юу яая дээ, үнэхээр дургүй хүргээд байгаа юм гэж ярьдаг халиун морийг аваасай. Уг нь ав ав эр хүнд сайн мориноос илүү юм хэрэг байдаггүй л юм гэх нь билээ" гэхчээ л авчихна л даа. Ухаандаа миний амыг л харж байгаа хэрэг. Одоо ирэхээр нь марталгүй хэлье байз гэж бодно. Иймэрхүү юм бодохоороо нэг үе тайвширдаг байв. Тэгтэл нэг өдөр олж ирэх ёстой хүрэн үрээ нь өөрөө ижилдээ иржээ.

Энэ явдал Дэжидийн голыг гонсойлгож амьтны хэл амаа билүүдээд байгаа нь ортой байх нь гэсэн сэжиг сэтгэлд нь орогнон, түүний бодох санах идэх уухий нь хүртэл мэддэг болов. Яг энэ үед ах нь иржээ. Ямар хэргээр яваа нь бүү мэд, байдлыг нь ажихад нэг л янзгүй мал бүрэн эсэхийг асууж лавласныхаа дараа дуртай дургүй "Дамба хайчаав?" хэмээн асуужээ. Энэ

асуулт цаанаа нэг юм хадгалаад ч байгаа юм шиг, Дамбыг хаа явааг чи мэдэх үү гэсэн юм шиг сонсогдоход Дэжид "Юү гээ дээ, Ойр зуур мордсон гэлтэй ч биш. Бүрэн бүтэн байгаа малаасаа алдчихсан гэлтэй ч биш, яаядаа" гэж тэрхэн зуур бодсоноо, - Сум орно гээд л явсан хэмээн бялд муутайхан дуугарчихаад "Хэзээ гэвэл яанаа? Ах суман дээрээс ирсэн байвал яана? Хэрэггүй л сум орсон гэлээ. Үнэний нь л хэлдэг байж. Хүрэн үрээ ижилдээ ирчихсэнийг ах ямар мэдэх биш" хэмээн хойноос нь харамсан бодох зуураа хоёрхон усаар авсан шимийн архиа гарган өмнө нь тавив. Ах нь муухай харах шиг болсноо лонхтой архианаас аягалж залгилаад,

- Танайхан чинь яагаад нүүдэггүй улс вэ? Аль язгуурын л энд буусан. Хэдэн мал чинь яаж тогтдог юм гээд их л ширүүн янзтай хялавхийн харахад Дэжид харцнаас нь харц буруулан тонгойв. Ах нь шал өөр юм ярих гээд байгаагаа худлаа дүйвээдүүлэн, тэр ярих хэлэх гэж байгаагаа гаргаж ирэх шалтаг болгон нүүдэл суудлын тухай ярьж байгаа бөгөөд үнэн хэрэгтээ чухам юун тухай ярих гэж буй нь дууных нь өнгө нүднийх нь харцанд ив илхэн байгааг зөнгөөрөө мэдэрсэн Дэжидийн дотор палхийн зүрх нь оволзон цохилж эхлэхэд арай чүү биеэ эзэмдэн,

- Зөөх л санаатай гэж ихэд гэмшингүй дорой дуугарснаа өөрөө ч мэдрэв. - Үхсэн хойноо зөөх? Тэнгийн булан даахгүй хуруун чинээ нялх хүүхэд та хоёр яаж зөөх юм. Яасан арилсан дотортой амьтан вэ? чи. Чиний наад хоёр нүд чинь юү үзэж, хоёр чих чинь юү сонсож байдаг юм. Хүнд чинь нэр нүүр гэж байдаг. Та нар чинь яачихсан цагаандаа гарчихсан улс вэ. Үгүй ядахдаа амьтан ах дүүгээс ичдэг байгаадаа. Хн! "Сум орсон гэнэ шүү. Сум орсон хүн халзан Дэлэнгийн дэвсгэж байдаг юм уу..."

Яахаараа чи ч чи. Яагаад эр нөхөр шүү юмаа татаж авдаггүй юм гэснээ хариу хүлээх мэт дуугүй болов. Дэжид энэ тухай хэлэх вий гэхээс айн яс хавталзан суусан бөгөөд эдгээр үгсийг сонссоноосоо хойш яагаад ч юм мөнөөх айдас нь огт алга болж, одоо юү ч хэлсэн, юү ч ярьсан түүнд ялгаагүй мэт санагджээ. Ах нь архианаасаа дахин аягалж нүдээ тас анин залгилж, дуусгаад ярвайн амаа арчсанаа дотор нь сая онгойсон янзтай санаа алдаад Дэжид рүү зэрвэхэн харснаа өрөвдсөн ч юм уу, аль эсвэл уурласан дүр үзүүлэх гэснээ удаан тэгж чадахгүйгээ мэдсэн ч юм уу дуугаа зөөлрүүлэн,

- Дэлэгийнхээс гарахаа байж гэж дуулдаад байхаа нь зориуд оройхон тэднийхээр буусан юм гээд цааш хэлэх үгнээсээ халгах мэт зогтуссанаа зөрүү харсхийн, Хэвтэж л байна лээ. Эрүүл юм уу, согтуу юм уу хэн мэдэх вэ. Зэвүү хүрээд ганц нэгэн үг хэльеү гэснээ юу юуны туханд хүрээгүй байж за яршиг даа л гэж бодлоо гээд дахин дуугүй болов. Дэжид дуугарсангүй. Эдүгээг хүртэл тэвчиж явсан нулимс нь гарахаар завдсан тул түүнээ арай чамай тогтоов. Ах нь ийнхүү дуугүй сууцгаахынхаа гачланг давах гэсэндээ дэмий л архианаасаа аягалан, хатуу гарсан архи дорхноо толгойд нь гарч байгааг мэдэрсэн нь авч согтохоосоо нэг ч их хулчийсангүй бас дахин нэг аягыг уугаад аягыг тавин лонхтой архиныхаа сүүлчийг шавхан хийгээд дахиж уухгүйг илтгэн хоосон лонхоо явган ширээний ар руу далдлан тавиад,

- Ер нь тэгээд хүү минь бага дээр нь татаж авахгүй бол базаахгүй л юм болох бий вий. Тиймэрхүү явдал газар авахаараа хэнд ч дийлддэггүй л юм даг гэснээ аргадангуй,

- Миний дүү, цаадахыгаа ирэхээр сайн хэл. Юү хийхэв, хэд наслана гэж ингэж явах вэ. Ажаад

байхад эм нь ажилгүй эр нь завхай айл ч айл биш болдог юм шүү гээд үлдсэн архиа ганцхан хөнтөрчихөөд архины хойноос цагаан идээ амсдаг ёсыг бодож тавагтай идээний захаас ааруул хэлтлэн авч амандаа хийгээд дуугүй суугаад байлтай ч биш ухасхийгээд гараад явчихалтай ч биш яах ч учраа олохгүй жаахан сууснаа:

- Гээд эр хүн хойно учраа олчихноо. Харин чи л ам муруйх болгондоо урьд хойчийн юм сөхөөд байв даа. Тэгвэл ч сайнаа үзэхгүй шүү. Нэг л сайн хэлж аваад мартчих хэрэгтэй. За би ч явья даа. Өнөө хэдэн тэмээ бас, гээд морджээ. Ахынх нь эл яриа үнэн байвал яана хэмээн шаналдаг байсан шаналал арай ч үгүй болов уу хэмээн эргэлздэг байсан эргэлзэл, намайг элэг барьж байхдаа яах вэ дээ хэмээн уурсдаг байсан уур энэ бүхний гомдлоор сольсон хэдий ч салж сарних тухай бодоо ч үгүй, тийм үг хэлнэ хэмээн зэхэж байсан бөгөөд гагцхүү нүүр учрахын үед гомдсондоо аргадуулах ч гэсэн юм уу хэлж орхисон нь тэр ажээ.

Дэжид Дамбыг ийм үг хэлнэ чинээ огт санасангүй тул балмагдан дуугүй болсноо өөрөө буруутай байж ийм үг хэлсэнд нь Дэжид улам ч гомдон, гоморхолдоо тэнцэхээр гашуун үг хэлэх гэсэн боловч тийм үг олсонгүй хэр нь "Намайг бас нэг яахаа алдчихсан амьтан гэж бодож байна уу. Үгүй шүү яаж ийгээд амьдрах байлгүй" гэж бодон зэвүү нь хүрч хоолойных нь өнгө хөндий хүйтэн өнгөөр солигдон, - Авалгүйдээ, Тэр бүр шинэ юманд ааван сааван дасаа ч үү, үгүй ч үү. Нэг хэсэгтээ унаж дассан морь, биед хэвшсэн хуучин хувцас чинь хэрэг болно байх шүү гэхэд Дамба Дэжидийн үгийн өнгө, егөөнд шар нь хөдөлсөн янзтай,

- Тэрэнд санаа зоволтгүй гэв. Дэжид ийм уужуу тайван, ийм битүүхэн түншсэн үг хэлчихсэнээ өөрөө ч мэдрэн, Дамбын хорыг маажиж чадсандаа эрэмшин улам ч тайван хэнэггүй царайлан,

- Сайн муу ч гэсэн чамтай хэдэн жил ханилсан юм байна. Юутай явуулахаа өнөөдөртөө мэдэх байлгүй гээд босч орны хөндийгөөс аян жин, хот суурин орохдоо авч явдаг Дамбын булигаар богцийг гаргах зуураа,

- Цаашдаа ч авах юм байвал аваарай гэж хэлээд авдар уудлан урин дулаанд өмсдөг хувцас хунарыг нь гарган Дамба руу шидлэхэд Дамба,

- Авахгүй, авахгүй. Яаж ийгээд болох л байлгүй. Миний гэсэн юм байдаг юм бол хэт нь энэ хүүхдийнх болно биз гээд буцаан чулуудтал Дэжид цочсон юм шиг огцом эргэж харан мөнөөх хөндий хүйтэн дуугаараа,

- Эцгээр дутна уу гэхээс эдээр дутахгүй байлгүй гээд буцааж чулуудсан хувцасыг нь хаман авч богцонд нь хийгээд амыг нь үдэн Дамба руу түлхээд цааш юу хийх яахаа ч мэдэхгүй байх мэт авдрынхаа өмнө хэдэн хором сууснаа авдраа ч таглалгүй босч Дамбын өмнөх данхтай цайг авч зуухан дээр тавилаа. Дамба дуу ч үгүй тамхиа сорон тонгойн сууна. Дэжид эргэнэгийнхээ доороос сонин авч базан зуух руу шургуулан шүдэнз зуран асаахад түрүүнээс хойш уугьж байсан аргал пүнхийн утаа цацаад асаж эхлэв. Хэрэв энэ мөчид хүү нь гаднаас орж ирээгүйсэн бол тэд хэдий болтол чимээгүй суух байсныг хэн мэдэх билээ. Цэдэн- Иш хүү аяны богцоо дэргэдээ тавьчихсан суугаа аав руугаа гайхан харснаа дэргэд нь очин мөрий нь түшин зогсож, - Аав хайчих гэж байгаа юм хэмээн явуулахгүйн өнгө хадгалсан, эрхэлсэн янзтай урвагнахад Дэжид,

- Аав нь аймгийн төв орчихоод ирэх юм байхаа гэв. Хүү улам ч урвагнан, - Аа, аав саяхан яваад ирсэн шүү дээ гэхэд Дамба уртаар санаа алдан,
- Аавд нь ажил байна. Миний хүү ээжийнхээ үгэнд сайн орж байгаарай. Хонио хүний хоньтой нийлүүлэв гээд хүүгийнхээ толгой дээр үнсээд гаансаа түрийлэхэд хүү, - Аав надад тонгорог авчирч өгөөрэй.
- Байдаг л юм бол аав нь аваад л ирнэ гээд босон үүд рүү явахад хүү,
- Та богцоо аваач гээд гүйж очиж богцыг нь дааж ядан үүд рүү чирэхэд Дамба эргэж харан,
- Аа, хэмээн сулхан дуугарснаа хүүгийн гараас богцыг авч гарахад хүү ч даган гарав. Дамба уяа руу даган очсон хүүгээ дахин үнсэе юү гээд хүү рүүгээ эргэх гэснээ "Дахин уулзахгүй болчихож байгаа биш" гэж бодон эмээл дээгүүрээ богцоо хөндлөн хаяад уяан дээрээс морио тайллаа. Эцгийгээ юү юүгүй мордох гэж буйг харсан хүү гэртээ гүйн орж,
- Ээжээ аав мордлоо шүү дээ, сүүгээ өргөөч хэмээн хашгирахад зуухны аман дээр гөлрөн сууж байсан Дэжид юү гэсний нь дуулаагүй ч юм шиг, ойлгохгүй ч байгаа юм шиг түүний зүг мэлрэн харахад хүү,
- Та аймаг явах болгонд сүү өргөдөг шүү дээ. Одоо яагаад өргөхгүй байгаа юм бэ. Аав аймаг явахгүй юм уу гэхэд Дэжид сая учрыг нь ойлгосон мэт босч эргэнэг дээрээс шанага аван сав суулганаасаа сүү хайхад хүү үүдээр шагайн,
- Хурдлаачээ, явчихлаа шүү дээ хэмээн дэвхцэх нь халаг сандчихад Дэжид өглөө хөөрүүлсэн тогтоотой сүүнийхээ өрмийг ч авалгүй захаас нь цоо татан сүү утгаад гарахад Дамба хэдийнээ мордон хөдөлж байлаа. Дэжид Дамбын хойноос шанагатай сүүгээ хам хумхан өргөөд гэртээ орон хоосон шанагаа эргэнэг дээр тавих гээд мөчид тавин унагахад хүү эхийнхээ царай өөд гайхан харснаа ухасхийн шороотой шанагыг авч эх өөдөө сарвайв. Дэжид шанаганыхаа шороог ч арчилгүй эргэнэг дээр тавих зуураа түүний харц өөрийн эрхгүй тогоотой сүүн дээр туслаа. Өрмий нь цоолчихсон тогоотой сүү сэтгэлийг нь улам ч гутраан энэ ертөнц дээр бүтэн юм ер байхгүй болсон мэт санагдав. Дэжид хоолой зангирч байгаагаа аль болохоор мэдэгдэхгүйг хичээн:
- Миний хүү Багаагийндаа очоод данхтай цайгий нь зуухан дээр нь тавиад галыг нь түлж бай. Должин гуай одоо ирэх болж байгаа байх. Ээж нь аргалд яваад ирье гэхэд хүү: - Манайх зөндөө аргалтай шүү дээ.
- Тэнгэрийн муухайд чи бид хоёрт аргал л.... гэснээ үгээ дутуу хэлэн буруу харан эргэнэг дээгүүр юм хайв. Хүү:
- Тэнгэр сайхан л байна шүү дээ гэхэд Дэжид буруу харсан хэвээр:
- Маргааш яахыг чи бид хоёр яаж мэдэх вэ дээ.
- Маргааш ч сайхан байна гэсэн шүү дээ араажав.

- Аан.- Та сонсоогүй юм уу хэмээн хайнга дуугарснаа гэнэт эрхлэнгүй инээмсэглэн: - Ээжээ би тэр махнаас идье, тэгэх үү?

- Тэгээ гэхэд хүү баярлан гүйж очиж тавагтай махнаас авснаа:

- Та идэх үү? гэлээ. Дэжид

- Үгүй гэж дуулдах төдий хариулаад гадаа гарч гэрийн хаяанаас араг авч үүрэн зүүн тийш алхаллаа. Урьд нь гэрийнхээ гаднаас ааргаа үүрч байхдаа хаашаа явбал аргалтай билээ хэмээн бодож явах зүгээ сонгодог байсан бол энэ удаа тэгсэнгүй. Хандсан зүгтээ л явж байгаа нь энэ бөгөөд энэ зүг нь Дамбын явсан зүгийн эсрэг зүг байлаа. Уг нь Дэжид билэг дэмбэрэл бодсонсон бол эцэс нь үл мэдэгдэх нэгэн их хоног хугацаа, зай завсрыг хоёр тийш нь сунган хөвөх мэт хоёр тийшээ явчих гэж юүг хэлэх вэ хэмээн цээрлэн Дамбыг далд орон ортол нь хүлээхийн ерөөл бодон байрнаасаа ч хөдлөхгүй зогссоор байх байсан билээ. Гэтэл одоо билэг дэмбэрэл, ёс ёмбо бодохын сэхээ Дэжидэд байсангүй. Гагцхүү гэрээсээ түргэхэн холдохыг бодон түргэн түргэн алхлах бөгөөд гэрээсээ холдох тусам хоолой нь улам зангирч, нүднийх нь нулимс өөрийн эрхгүй бүрхэн ирж, хоёр хөл нь солбин гуйвлахад Дэжид биеэ эзэмдэхийг бодсон ч үгүй аргаа үүрсэн чигээрээ суун тусаад мэгшин уйлав.

Одоо хэнээс яах гэж нулимсаа нуух юм? Уйлж усан нүдлэхгүй байгаад яах юм? Өдий олон хоног нулимсаа барилаа гээд надад сайн юм юү ирэв? Цөм худлаа. Сайн сайхан, муу муухайг зөгнөнө гэдэг ч худал, уйлчихвал бүх юм муугаар эргэчих юм шиг санаж тэгтлээ юунд тэвчив? Уйлж л байх минь яалаа, тэгсэн бол уйлах нулимс минь бага ч гэсэн хорох ч байсан юм билүү? Усан нүдлэх муу гэдэг, яадаг юм. Гай гэж байдаг бол тэр нь дайрч л байг. Тэртэй тэргүй хэнд ч хэрэггүй үнсэнд хаясан шалз шиг амьтан үхсэн ч яадаг юм. Хэнд хэрэгтэй гэж амьд явах юм? Амьд явж яах юм? Яах юм?... Гэнэт гэдсэнд нь хүүхэд хөдлөх шиг болоход амьсгаагаа аажуу гарган нулимсаа арчин чимээгүйхэн эхэр татан биеэ чагнан "Нээрэн давхар биетэй болчихсон юм гэж үү? Цэдэн Ишийг анх олоход яалаа? Арай санаа дагаагүй байгаа? Хөдлөх болсон гэж үү? Суун тусахдаа эвгүйцүүлчихээгүй байгаа?" хэмээн бодож дахин хөдлөхий нь хүлээн нэлээд суув. Огт юм мэдэгдсэнгүй. Санаа дагасан юм байлгүй дээ. Юү боллоо гэж ганцхан хөдлөв гэж. Хэд хоногийн өмнө бас л хөдлөх шиг болохоор нь бас л нэг хэсэг биеэ чагнасан юү ч л мэдэгдээгүй дэг худлаа л юм байлгүй гэж бодов. Ийнхүү өөр юм бодон нэлээд суучихсандаа садаараад ч тэр үү нэг хэсэг уйлчихсан болоод ч тэр үү дотор нь овоо онгойх шиг болж санаа алдан сааль сүү, үхрийн зэлний түйрэмд зэгэл саарал болсон савхин гутлаа харснаа өглөө босоод үсээ ч тав тухтай самнаагүйгээ санан шанаа руугаа унжсан үсийг хойш илж чихнийхээ араар болгоод алчуураараа толгойгоо тумлайдан боогоод ухасхийн босох гэснээ түрүүчийнхээ суун туссаныг санан саврынхаа ишээр газар тулан болгоомжтой босоноо "Ингээд ч яах юм билээ. Хэрэв хүүхэд олчихсон байлаа гэхэд Дамбаас гэдсэндээ хүүхэдтэй хоцорсон гэж хэн үнэмших юм? Өнөө Дэжид эцэггүй хүүхэд гаргасан гэнэлээ л гэж шуугина шүү дээ" гэсэн бодол орж ирсэн боловч "Шуугивал шуугина л биз. Одоо сайн нэртэй явлаа гээд яах ч юм билээ. Ялгаа ч алга даа" гэсэн бодлоор няцаагдан ерөөс сайн муугийн ялгаа байхгүй юм шиг санагджээ.

Хэдэн мөчийн өмнө Дэжид харж зүрхлэх ч үгүй, харахын сэхээ ч байгаагүй тэр зүг рүү өөрийн эрхгүй харан зогслоо. Дамба аль хэдийн бараа тасарсан бөгөөд тэр зүгт, тэр биш байгаа гэх бараа ч үгүй, тэндээс болов уу гэх салхи ч үгүй ажээ. Дэжид аргал түүхээр гарснаа

сая санах мэт үүрсэн аргаа тэгшлэн засаад цааш явлаа. Хорсол гомдол, уур омог, хүлцлээр дүүрэн байсан сэтгэл нь одоо хов хоосорч, тэрхүү хоосон нь шаналгах мэт үе үе зовууртайгаар санаа алдан хэсэг явсан боловч араг руугаа ганц ч аргал хийлгүй гэрийн зүг гэлдрэхдээ гараараа хоёр нүдээ хавдсан эсэхийг байн байн тэмтэрч явлаа.

Дамба огт эргэж харсангүй. Эргэж харахгүй гэж бодоод ч тэгсэнгүй. Ерөөс хол ойр алив юманд явахдаа гэрээдээ эргэж харж заншаагүйгаар ч үл барам алс явахаар мордсон хэрнээ ийм тийм юмаа мартсан нэрийдлээр замаас буцах, гэрийнхэндээ энэ тэрийг захихаар эргэх зэргийг эрс цээрлэдэг хүн.

Ийнхүү алсын моринд дөрөөлсөн хэрнээ эргэж буцах нь орон гэрт сэтгэл санаа хоргодож байгаа хойно зорьсон хэрэг үйлстэй бүтэхгүй нь мэдээж гэж бат боддог учраас алсхан явахаар завдах бүхэндээ хэд хоногийн урьдаас унах унаа, тохох эмээл, хазаар, чөдөр ногтоо зэхэн, захих хэлэх үгээ аажуу уужуу захин тамхиныхаа хүүдийд тамхи дүүргэн шүдэнзээ дүүрэн, эсэхийг үздэг байлаа. Эртнээс ингэж бэлтгэдэг болохоор барагтай бол юм хүмээ мартана гэж байхгүй, хаа нэг тохиолдлоор яль шальхан зүйл мартлаа ч түүний төлөө хэзээ ч эргэж буцаж байсангүй. Эл учир гэрийн гаднаас мордуут барьж явах зүгийн тэнгэрийн хаяа ширтэн нүдэнд харагдах уул толгодын хаагуур орж яаж явбаас газрын бартаа бага ойр дөт болохыг эн түрүүнд баримжаалан харж аваад мориндоо ташуур өгөн Гэрээс гаралгүй хэд хичнээн ч хоночихов доо. Ганцхан чиг барин алсыг ширтэн явах юутай сайхан. Эр хүний жаргал эзгүй хээр гэдэг их л ортой үг юм даа хэмээн бодож цээж дүүрэн амьсгалан давхидаг байжээ.

Харин энэ удаа бүх юм өөрөөр эргэжээ. Дамба хотынхоо захаас гармагц мориныхоо аясаар зугуухан шогшиж явснаа бяцхан давирч егүүлэхдээ эмээл дээгүүрээ тохож орхичихоод ганзагаараа даруулаагүй богц нь морины явдалд урагш хойш бондогнон явааг ч үл анзаарах бөгөөд хувцас хунары нь гарган өөдөөс нь шидэлж байсан Дэжидийн байдлыг бодохоос зэвүү нь хүрч, өөрөө хамгаас буруутай, хамаг бүхэн өөрөөс нь үүдсэн гэдгийг ч үл бодон уур цухалдалдаа автан "яавчихад ч ер нь яах вэ дээ. Ямар холбоод гагначихсан биш. Салъя суучихья гэж бодоогүй байхад тэгээд байгаа юм бол Тогоохүүтэй суучихад ч ер яах вэ дээ. Ямар ялгаа байна? Их л удаж нэг анхиагүйг нөгөөгөөр солино биз. Ер нь хэнтэй амьдарсан ч төгсдөгөөрөө л төгсөж орхих хорвоо юм чинь" хэмээн бодно. Дамба Дэжидийг хөөнө чинээ огт санаагүй явсан болоод ч тэрүү, юу юуны туханд хүрэлгүй учир жанцангий нь ч ололгүй түс тас шийдсэнд нь улам гомдож, энэхүү уур гомдол нь хаа нэгтэй сэтгэлийн мухарт доромжлогдсон, басамжлагдсан гэдэг санааг бүдэг бадаг төрүүлэх бөгөөд тийм санаагаа бүүр түүрхэн мэдрэх бүр "нэг нэр хоёр хоч. Ер хэлүүлэв юу. Тогоохүүг аваад хаашаа ч юм явчихалтай нь билээ" хэмээн бодсоноо гэнэт "дарханыхаа хэрэгслийг авдаг байж, чөдөр ногт зангидахаас эхлээд хийх юм хаа мундах вэ. Юу юу ч үгүй гар мухар гарснаа санах авч тэрхэн үед дархны хайрцаг бүү хэл тамхиныхаа хүүдийд ч тамхи дүүргээд авчих сэхээ байгаагүйгээ санан гунихрав. Ер ингэхэд би гэдэг хүн яах хүн бэ. Үнэхээр ингээд энэ чигтээ Тогоохүүгийн давхиад очдог хэрэг үү?" Хэмээн бодоход хариу өгч чадахгүй байлаа. Дамба тэднийд өнжиж хонож Тогоохүүтэй ойр дотно явах үедээ түүний инээмсэглэл, үнэртэн гэхэд арай биш нэгэн тансаг үнэр, хүзүүдчихээд шивнэдэг үгнээс нь өөр юу ч мэдэхгүй, мэдье ч гээгүй ажээ. Нэгэн удаа хань бүлтэй хүнд сэтгэлтэй болчихдог би ямар үйлтэй амьтан бэ гээд уйлахад нь Дамба юу ч хэлээгүй юм. Энэ мөчийг хүртэл Тогоохүүтэй суух тухай бүү хэл, би сэтгэлтэй билүү,

үгүй билүү гэдгээ ч бодож яваагүй хэр нь ингээд давхиад очиход Тогоохүү ханилах суух тухайгаа аль хэдийн ярьж хэлцчихсэн юм шиг угтах болно гэдгийг Дамба мэдрэх тусмаа "Ингээд л Тогоохүүтэй суучих гэж үү" хэмээн бодно.

Ийнхүү элдвийг бодон явахад унаж яваа морь нь нэг хэсэг егүүлсэнээ эзнээ огт ташуур өгөхгүй жолоо цулбуур зоргоор явааг мэдрэн шогшиход тохож яваа богц нь улам ч бондогнон хөлийг нь дэлдэж эхлэхэд Дамба сая анзаарч эргэн тойрныг ажвал гэрээс гарсаар нэлээд газар явчихсан тул мориныхоо амыг татан сажлуулав. Мөнөөх богц ч бондогнохгүй болов. Дамбын сэтгэл ч овоо уужирч "Амьдрал гэгч ер нь юу юм? Нартай өдрөө л хүн жаргалд тооцдог байна уу? Хүн ер нь яаж амьдрах ёстой юм бэ. Морины хөлд гишгүүлэх шахан бужигналдах энэ олон оготно шиг намар эртнээс хөөө хурааж, өвөл ичиж, хавар нь дахиад л газар ухан, үүр ноохой барьж амьдрах гэж үү. Аль эсвэл болжмор шиг олсоноо идчихээд л нисч бууж явах хэрэг үү. Хоолоо олж идэхийн тулд л болжмор нисдэг юм бол яах гэж агаарт тогтон тогтон жиргэдэг байна вэ? Тэгэх нь амьд явахынх нь утга учир юм болов уу" хэмээн бодож явтал нүдний нь үзүүрт Тогоохүүгийнхний хот айл цайлалзан харагдахад мориндоо дэм өгөн эргүүлтэл мөнөөх богц нь дахиад л бондогнож эхлэхэд сая түүн рүү харж богц бондогнуулан айлын гадаа буухаасаа ичих шиг санагдан, буугаад ганзагаараа сайн даруулаад очъё гэтэл улс амьтан богц тохоод хаа хүрэх нь вэ гэвэл юү хэлэх вэ. Ойрхон очоод хээр орхичихоод очих, үдшээс өмнө айл саахалтын хүн олоод хэний юм наана цаана гэвэл бас эвгүй. Тэгдэггүй юм гэлээ гэхэд явуулын амьтан олзшаан аваад явчихвал бас ч хайран санагдан ер яах ч учраа олохгүйд хүрэхэд арга чарга олохын оронд "Тэгэхээс тэгэх гэж албаар намайн амьтны шившиг болгох гэж богц тохууллаа" гэж Дэжидэд уур нь хүрч мордуут хүү нь хойноос нь хашгиран чирээд ирэх байсан гэдгийг мэдсээр хэрнээ түүнийг огт санахгүй шон дээр орхичихоод явчихдаг байж. Тэгсэн бол юү гэж ингэж зовж явах вэ хэмээн хий л цухалдсаар яаж ч чадалгүй тэр чигээрээ гадаа нь хүрээд оччихсонд хэнэггүй байдал гаргахаас өөр арга үлдсэнгүй. Дамба мориноосоо буун олмоо султгаад богцоо авч барьсаар гэрий нь гадаа очин хаяанд нь богцоо тавиад оров. Эхтэйгээ хоёул дээл эсгэж суусан Тогоохүү түүнийг хармагцаа царайдаа баяр баясгалан гэрэлтүүлэн инээмсэглэхэд Дамбын дотор ч агшин зуур гийн:

- Үйл бүт хэмээгээд баруун орны урд очиж суув. Тогоохүү:

- Мөр зохь гээд цааш залган хэлэх үгийнхээ шоглонгүй амтанд өөрөө тэсч чадалгүй инээд алдан:

- Мөдхөн мөндөр шиг манцгар цагаан хүүтэй болоорой гээд хөхрөхөд Дамба ч даган хөхөрч:

- Тэр ерөөл бат орших болтугай хэмээгээд "Чи гаргаад өгөөрэй л дээ" гэсэн харцаар харахад түүний харцыг ойлгосон Тогоохүү өвөрт нь гар хийсэн юм шиг царай улайлган тонгойход түүний эх Бумбаа, хийж буй юмнаасаа ч толгой өөд татсан үгүй: - Аальгүй монш вэ. Босч айраг цагаа хийж өгөөч гэв. Тогоохүү ингэж хэлэхийг л хүлээж байсан мэт ухасхийн босч Дамбад айраг хийж өгөөд түүний ар дахь орон дээр суугаад,

- Чи дурангаа мартчихсан байна лээ гэж шивнэхэд Дамба түүн рүү эргэсхийгээд: - Тэр чинь ч харин сайн болж билээ гэхэд Тогоохүү гайхсан нүдээр хариу нэхэн ширтэхэд Дамба тэдний юү ярилцаж яаж буйг огт анхаарахгүй дүр үзүүлэн суугаа Бумбаа хөгшний зүг харснаа дуугаа

намсган:

- Би ч бүрмөсөн хүрээд ирлээ шүү дээ гэв.

Ийм үг дуулна гэж санаагүй явсан Тогоохүү балмагдан хэлэх үгээ олж ядан байснаа гэнэт Дамбын араас зоримог гэгч нь тэврэн хоромхон зуур сэрвээнд нь толгойгоо наалдуулснаа гүйн гарч яах гэж, юу хийх гэж гарснаа ч мэдэхгүй зогсохдоо хаяа түшүүлэн тавьсан богцыг олж харлаа. Аваад ордог юм билүү... Хүний нүд тусахааргүй газар тавьчихдаг юм уу хэмээн тээнэгэлзэн, айл хунарын улс харчихаагүй байгаа гэж эмээн хурдхан далд хийх нь зөв санагдан гэртээ барьж орон ээждээ харагдуулалгүй орон доогуураа хийчихье гэж нэг ухасхийснээ харчих байх гэж болгоомжлон илүү гэртээ оруулан хураалттай бараан дээр тавиад дээрээс нь юмаар бүтээчихээд гэртээ эргэж орон Дамбад,

- Гүүгээ саая гээд баруун хаяанд цахлан дүүжилсэн хөхүүртэй айрагийн доороос хувингаа харжигнуулан авахад эх нь хийж буй үйлээсээ сая толгой өөд татан: - Саамшаагүй байлгүй, саяхан саах чинь юу билээ гэв. Тогоохүү эхийнхээ зүг харсан ч үгүй, хариу хэлсэн ч үгүй үүдрүү зүглэхэд Дамба босч араас нь гарав. Тэр хоёр зэл рүү явж байхдаа юу ч ярьсангүй. Хоёулханаа гүүн зэл рүү хурдхан явах юмсан гэж хүсч байсан Тогоохүү ийнхүү явж байхдаа нэг их юм яримаар, тэгсэн атлаа юу ч ярихаа ч мэдэхгүй, хааяа Дамба руу яриа хөөрөө сэдэх болов уу хэмээн харах боловч цаадах нь дуу шуу ч үгүй гунигтайхан алхаж харагдана. Тогоохүү Дамбыг цээжиндээ тэврэн "Найздаа хамаг зовлонгоо ярьчих. Тэгвэл сэтгэл чинь онгойно" гэмээр санагдах авч энэхүү гэгээн цагаан өдрөөс, айл саахалтын амьтнаас ичин, мөрий нь ч мөрөөрөө шүргэж эс зүрхлэх бөгөөд тэгээд ч Дамба санаан зоргоор тэгүүлэх ч юм уу, үгүй ч юм уу мэдэхгүй тул бас болгоомжилно.

Дамбыг ингээд хүрээд ирнэ чинээ хэзээ ч санаагүй болохоор маш их баярласан хэр нь гэнэтийн энэ баяр баясгалан нь хомсхон бөгөөд төдөлгүй буцан одох ч юм шиг санагдан гуниг төрөөд ч байгаа юм шиг сэтгэл нь нэг л хачин хөнгөн хөвсөргөн байлаа. Дамба Тогоохүүг саамаа юүлэх хувингаа зэлний захад тавих зуур зэлний урд захаас нэгэн унага тайлж эх нь алив энээ тэрээ гэж асуусан ч үгүй шууд л эх рүү нь хөтлөн очиж хөхүүлэв.

Үүнийг харсан Тогоохүүд ямар унаганы эх ямар гүү болохыг нүдэлчихээр олон удаа унага татаагүйсэн гэж бодогдон их л өөриймсөг сайхан санагджээ. Гүү үнэхээр саамширч амжаагүй бөгөөд хоосон хөхий нь хий шувгчин суух Тогоохүүг хараад Дамба инээд алдан:

- Хөх рүү нь алгад гэхэд Тогоохүү инээмсэглэн:

- Нээрэн үү хэмээн гүүний дэлэн рүү цохих гэж гар далайн наадахад Дамба түүний зүг дулаан харцаар ширтэн:

- Саяхан саасан юм уу?

- Тийм.

- Тэгээд яаж байгаа юм гэхэд Тогоохүү хөхрөн:- Зүгээр гээд Дамбын мөрөнд толгойгоо наалдуулан,

- Хоёулаа хонь руу мордох уу гэхэд Дамба "Яах юм залуу хүүхдүүд байгаа биш. Айл саахалтын чинь улс юу гэх юм" гэх гэснээ гомдчих болов уу гэж бодоод юу хэлэхээ мэдэхгүй дэмий л:

- Харин нь? гээд өөдөөс нь харав. Түүний харцанд "Чи л мэд" гэснээс "яах юм" хэмээн хориглосон өнгө төрх илүү байсныг дурлал гэгчийг сэтгэлдээ шингэтэл амсаагүй, урьд өмнө нь ганц нэгэн залуутай нэр холбогдож явсан түүх бий ч тэр нь бараг хүний нүдэнд хүнтэй яаж байгаагаа харуулах л гэж тэгж явснаас чухам юу гэгч хүсэгдэж, ямар гэгчийн юманд өөрийн эрхгүй унадгийг үзээгүй охин нялх сэтгэл нь баяр хөөр, хүсэл тэмүүллээр оволзон инээд алдан харц талимаарах Тогоохүү эс анзаарчээ. Энэ бүхнийг анзаартлаа ч бас өдий. Тэр болтол бүх юм миний хүссэнээр, хэлснээр болно, болж байна хэмээн нэг хэсэгтээ л бодох болно. Тогоохүү юм бодов бололтой хэдэн агшин дуугүй байснаа Дамбын дургүйцлийг зөнгөөрөө мэдрэх мэт, - За больё, больё. Харин би чамд орой сайхан хоол хийж өгье тэгэх үү? Гэхэд Дамба толгой дохив. - Чи ямар хоол идэх вэ? - Ямар ч яах вэ. - Ямар ч хамаагүй юу?

- Ямар ч хамаагүй ээ гэхэд Тогоохүү хүссэн үгээ сонссон мэт таатай инээмсэглэн: - Тэгвэл би чамд сайхан хоол хийж өгнөө гэлээ. Хэтийн өдөр нэг хийсэн хоолоо давтан хийх болоход "Ямар ч хамаагүй" гэсэн үг онхиос мартагдана гэдгийг мэдэх ч үгүй Тогоохүү тэр орой борц нүдэн хоол хийхээр орж гарч сав суулга хангинуулж эхлэхэд эх нь:

- Яачихаав чи чинь, дэв дав үсчээд л. Зөөлхөн хөдөлж болохгүй байна уу. Ямар юмандаа яарч давдигнаад байгаа юм хэмээн загнах аядсан боловч ийнхүү санаагаараа хоол хийж байгаад нь битүү баярлан хөгшнөө аяга халуун хоол идчихээсэй гэж бодсондоо үе үе:

- Аав чинь ирэх болоогүй л юм байх даа хэмээхийн сацуу өөрөө хийж чадахгүй болж байгаа хэрнээ бусдын хийсэн ажил сэтгэлд нь нийцэхгүй болохоор тэсч үл чадан "тэг, ингэ" хэмээн хушуу нэмэрлэдэг заншлаараа энэ өдөр мөн л хушуу нэмэрлэсэн бөгөөд харин охин нь уурлаж, ундууцах ч үгүй инээд алдан хөдлөх явахаараа хүртэл баяр баясгалан илэрхийлэх ажээ. Салхидсан тэмээгээ буцаахаар явсан Дэлэг өвгөн хоол уудлахын өмнөхөн ирэхэд эмгэний санаа амарсан боловч төдөлгүй нэгэн зүйлээс болж охиндоо гоморхох сэтгэл төржээ. Тогоохүү хоолоо уудлан гаргаад аврнаасаа шинэ аяга гарган хамгийн түрүү Дамбад аягалан өгөхийг харсан Бумбаа "Үгүй чи аавдаа урьдаар хийж өгөөч" хэмээн хэлэн алдсанаа арай чүү ам хавчин өнгөрч охин руугаа битүүхэн цэхэн цэхэн хялалзан:

- Цайгаа гал дээрээ тавиач хэмээн ундууцан дуугарав. Айл болж амь зууснаас хойш хоол цайныхаа дээжийг эр нөхөртөө аягалан өгч сурчихсан Бумбаа үзээгүйгээ үзсэн мэт дургүй нь хүрч тэрхүү явдлыг мэдэгдэх гэсэн шиг Дэлэг өвгөн рүү харахад цаадах нь огт тоосон шинжгүй өчигдрийн нэрсэн нэрмэлээс Дамбатай хувааж уун хэд хоногийн урьд мотоциклээр морь хөөж барихыг харснаа ярьсаар суужээ. Бумбаа хөгшин унтан унталаа охинтойгоо ч, хөгшинтэйгээ ч үг дуугарсангүй. Тэр ч түүний энэ байдлыг анзаарсангүй энэ тэрийг хүүрнэлдсээр шөнө дүл болгоод унтацгаав. Гэнэт нойрон дунд нь "Ааваа шээе" гэх дуун дуулдахад Дамба давхийн сэрж дэрээ тэмтэрвэл дэрэн дор нь шүдэнз алга байлаа. Яагаад шүдэнз алга байдаг билээ хэмээн бодсоноо сая хаа байгаагаа ухаарч зүүдэлсэн болохоо мэдэн эргээд хэвтэхээр орны ихэнх зайг эзлэн унтаж байгаа Тогоохүүг цааш түлхвэл Тогоохүү сэрэх унтахын завсарт яраглан хөдөлж хүүхэд адил түүний хүзүүгээр аг тэврэн унтав. Түүний юу гэж зүүдэлсний нь мэдэн, зүүдээ нэхэн үгүйлэх сэтгэлийг нь аргадах мэт халуун биеэрээ төөнөн тэврэх Тогоохүүд тэврүүлэн ийн хэвтэх аятайхан ч юм шиг байснаа удалгүй бие нь

чилж нөгөө тийшээ хармаар санагдавч сэрчих вий гэж бодохдоо хөдөлж ч чадахгүй дэмий л тооноор гялалзах одод ширтэн "Би гэгч хүн энэ оддын дор хэдий хэр насалж юу гэгчийг үздэг бол доо" хэмээн бодож хэвтэв.

Хэд хоносны дараа "Өнөө хоёр маань яаж шүү байгаа бол. Мал ахуй нь бүрэн бүтэн л байдаг байгаа даа" гэсэн бодол Дамбын сэтгэлд эргэлдэн шанагатай сүү барин зогсох Дэжидийн дүр төрх шон гэр хоёрын хооронд гүйж яваа хүүгийн царай нүдэнд нь үзэгдэн "Хөөрхий дээ, мордоод явчихаж байхад сүү өргөөд хоцорч байдаг. Шороо цацаад хөөхийг хэн байг гэхэв. Голцуу тэгж л салдаг даг. Тэгсэн бол амар байхгүй юу. Үгүй ядахдаа харааж загнаж зүхэхгүй... Ядаж муу хүү минь сургуульд орчихсон байсан болоосой" гэхчлэнгийн бодол түүний сэтгэлийг зовоох болов. Энэ байдлыг Тогоохүү гадарласандаа ч тэрүү, ерөөс хайр халамж нь ч тэрүү Дамбыг аль болохоор ая тааваар нь байлгахыг хичээн ийм тийм ажил ундрах бүр "Аав яв, ээж хий" гээд юуг ч түүнд эс хавьтуулах бөгөөд голцуу л хоёулханаа байх арга замыг эрэлхийлэн тийм замыг олмогцоо юу ярих, яах ийхээ өөрөө ч мэдэхгүй хий л Дамбын аяс харан түүнийг царайчлах нь улам ч сэтгэлийг нь хөндүүрлүүлнэ. Ялангуяа эхний өдрүүдэд Дамбад хэцүү байлаа. Сэрээд л айлд байгаагаа мэдрэн биеэ барьж ярих хөдлөхдөө хямгадна. Босонгуут явах гэж буй мэт дээл хувцсаа өмсөж унтан унтталаа бүсээ ч үл тайлна. Хэн ч түүнийг орон гэртээ буй мэт нөмгөн нүцгэн, гэрийн хоймор эзэгнэн суухыг хориглоогүй боловч тэгж үл чадна. Босоод л Тогоохүүгийн орны өмнө сууна.

Түүнээс өөр газар суудаг ч үгүй байлаа. Цай юм уу айраг уусныхаа дараа адуу нь ирээсэй. Хурдхан гүүн зэл рүү явах юмсан гэж бодно. Гүүн зэлэн дээр очихоороо л сая бие нь тавигдах шиг болж гүйж харайн дэл сул гишгэх бөгөөд унага барьсны дараа гүү саахыг хүлээн, гүүн саам болохоор Тогоохүүд унага татаж өгөн, энэ тэрийг ярилцаж хөхрөлдөж тэгснээ гэнэт больцгоон айл саахалтын хүн харчихаагүй байгаа хэмээн гэр өөдөө хяламхийн харцгаана. Тэгээд л гэрт орж ирмэгц тэдний инээд хумигдан хааяа бие биесийн зүг харах авч энэ нь тэдний сэтгэлийн чилээг эс гаргах ажээ. Үд өнгөрөхөөр орой болоосой, хурдхан харанхуй болоосой гэж хүсэцгээнэ. Орой гүү тавьж Дэлэг өвгөнийг адуугаа услахаар явах зуур хөхүүрт саам хийж бүлж болох атал энэ ажлыг Бумбаа хөгшин Дамбыг хүрэхийн завдалгүй шүүрч авч хийх тул Дамба айлд эрт ирсэн хоноц адил дэмий л тамхи нэрэн, Тогоохүүгийн хөөрүүлж суугаа сүүний хөөрч буй эсэхийг битүүхэн харж "Төмрийн хайрцаг дэргэд болоосой. Чөдөр ч болохноо зангидаж суухсан" гэж бодно. Тогоохүүг сүүгээ хөөрүүлж дуусмагц тэд хэвтэцгээн удтал орондоо шивнэлддэг болохоор хамгийн сэтгэл тааваараа байдаг газар Тогоохүүгийн ор байлаа. Сүүлийн өдрүүдэд Дамба тэсч сууж чадахыг бүр болин Дэлэг өвгөний урдуур орон адуунд мордох, тэмээ мал эргүүлэх зэргээр аль болохоор хээр хөдөө явахыг эрмэлзэн ийнхүү хээр хөдөө гарахаар нэг хэсэг л тааваараа унтдаг байлаа. Энэ нь түүнд хамгийн таатай тул бараг өдрийн бүтэн шахуу хээр хөдөө явах болсонд Тогоохүү битүүхэн дургүйцэвч боль барь гэж хорьж эс чадах бөгөөд хий л "Аав явах нь яадаг юм" хэмээн ундууцан Дамбын өөрийсч өгөхгүй байгаагийн шалтгаан нь ээж аав хоёрт нь байгаа мэт тэр хоёртоо битүүхэн уурсавч ил гаргаж эс зүрхлэнэ. Тэднийд Дамбын байгаа талаар эцэг эх хоёр нь өөр өөр бодолтой байна гэдгийг Тогоохүү мэджээ. Илүү гэрт цайгаа буцалгаж байгаад их гэрт орохоор үүдэнд очтол эх нь:

- Сайнаа хат. Ямар олигтой амьтан өч төчнөөн ажил ханилсан хань, үр хүүхдээ хаячихаад ингэж явдаг юм гэх дуулдсанд Тогоохүү зогтусан чих тавибал эцэг нь: - Цаанаа болох

бүтэхгүй болчихоод л ингэж яваа биз.

- Тэгээд ч урьд нь хүнд хань болж байгаагүй хүн...

- За за хүн ер нь ямар ч яваа билээ. Чи бид хоёр ямар юмаа мэддэг юм. Хоорондоо л болж байвал болоо биз.

- Болохоо хат. Очиж очиж...

- Чи ер нь хөгшин хонины насгүй болж байгаагаа мэдэж байна уу үгүй юу. - Алийн болгон нөхөр ханьгүй явуулах гэсэн юм.

- Манай энэнд ч ийм л юм тааралдана даа.

- За юу ч л бол эрүүгээ хамхиад л сууж бай чи зүгээр

- Үр хүүхдээ олигтой хүнтэй...

- Олиггүй хүн гэж хэн чамд хэлээв?

- Ямар олигтойдоо...

- За би мэдэж байна. Харин ингэсхийж байгаад нүүж буугаад чи бид хоёр илүү гэрээ барих нь элзий болох байх шүү. - Юу. Чи чинь галзуурав уу?

- За за дуугаа аяд. Хүүхэд шуухад сонсчихвол хар яршиг гэх сонсогджээ. Энэ ярианаас хойш Тогоохүү, ээжийнх нь дургүйцлийг Дамба мэдчих вий гэдгээс ихэд айн тэдний хооронд аль болох сайн харьцаа бий болгохыг чармайдаг болжээ. Ийнхүү арваад хонож байтал нэг өдөр Дамба:

- Нөгөөдлүүлээ нэг эргэчихээд ирье гэхэд нь Тогоохүү:

- Тэг тэг. Аль эртний л тэгэх байсан юм. Муухай юм болж байгаа юм хэмээн эргэ, барь гэж хэлээгүйдээ их л санаа зовсон, нөгөө гэвэл идээшиж дассан амьдрал руугаа эргэж оччихоороо ирэхгүй болчих юм биш байгаа гэсэн битүүхэн айдас царайных нь өнгө, нүднийх нь харцанд буйг Дамба анзаарч,

"Энэ амьтны буруу гэж юу байх вэ дээ" гэж бодон,

- Хэд хоногоос нэг тийшээ зөөнөө гэв. Түүний үгийн өөриймсөг өнгөнд баярласан Тогоохүү,

- Харин тийм, Аав ч чиний амыг л хараад байх шиг байна лээ,

- За яахав ээ, ирж байгаад больё хэмээгээд мордоход нь "Өнөөдөр ирэх юм байгаа биз дээ" гэсэн үг Тогоохүүгийн аман дээр гарч ирсэн боловч хэлж зүрхэлсэнгүй. Дуугүйхэн харж зогсохдоо өмсч ирсэн хуучин дээл хувцас, тэр ч бүү хэл морио хүртэл унасны нь анзаарч тэр чигээрээ явчих гэж байгаа юм биш байгаа гэсэн айдас дахин төрөхөд өөрийн эрхгүй хоолой

нь зангиран хоцорчээ.

Дамба нэлээд давхисанаа гэнэт хүүдээ өгөх ширхэг ч чихэргүй гарснаа сая санан, ардаа үр хүүхэдтэйгий минь мэдсээр байж хэдэн чихэр боогоод өгчихсөнгүй гэж Тогоохүүд гоморхов. Тэгээд арга буюу ойролцоох агент руу зам муруйхаас өөр аргагүй болж олигтой чихэр байгаа болов уу үгүй болов уу гэж бодсоор давхин очвол ойр хавийнхныхаа хэрэгцээний цай, тамхи, будаа гурил, хувцас хунарыг бригадын төвөөс авчирч илүү гэртээ худалддаг агент Найдан эзгүй боловч түүний эхнэр болох Ханд гэгч тарган бор хүүхэн инээд алдан угтаж,

- Өчигдөрхөн шинэ бараа татсан даа. Юу л авбал ав. Таануусын шилтэй цэнхэр хүртэл бий шүү гээд илүү гэрээ онгойлгон лангуу болгон тавьсан боов чихрийн хайрцагны ард гарч зогсоод:

- За юу авах вэ гэхэд нь Дамба хайрцаг савтай бараа руу нь өнгийн,

- Ямар чихэр байна?

- Ямар л бол ямар. Танд ямар чихэр хэрэгтэй юм бол доо. Одоогийн хүүхнүүд гаатай чихэр их хүлэх болж билээ, гаатай чихэр авна уу хэмээн Хандыг даажигнахад цаагуураа юу гэж егөөдөж буйг нь мэдсэн Дамба бас ч мөчөөгөө өгөхгүйг хичээн, - Тийм үү, тэгвэл үнэтэйхнээс нь

- Уухайс. Өнгөтэй мөнгөтэй хүн ч ингэдэг сэн дээ. Хэдэн хийл авах вэ? - За, нэг хийлийг л хийчих. - Өө, гавьсангүй, өөр юү авах вэ?

- За даа, өөр юү ч авах вэ дээ.

- Торго авахгүй ээ? Сайхан цэнхэр торго байна. Үс зүс тохирсон залуу хүн ч ургахаар торго шүү.

- Саатай торго бол ч хуйгаар нь авмаар байна.

- Саатайгаас дутахгүй ээ. Сайхан ногоон ч байж л байна.

- За даа, болих уу даа гээд Дамба барааг нь хэсэг харж зогссоноо нэгийг санав бололтой,

- Аан тийм, хүүхдийн гутал байна уу? - Бойтог уу?

- Үгүй үгүй. Манай бандид таарахаар.

- Аа би бойтог л асууж байгаа юм байх гэж бодлоо хэмээн доогтой нь аргагүй хэлээд эргэн нэгэн том хайрцаг дотроос хүүхдийн гутал гарган үзэж байснаа нэгийг авч, - Энэ таарах уу гээд Дамбад өгөв. Дамба тэр гутлыг авч улы нь төөлж үзсэнээ, - Хэв хөөрхөнтэй гутал юмсанж, таардаг болов уу?

- Танай банди чинь Доржийн охинтой...

- Тийм тийм долоо хүрч яваа юм.

- Тийм байх учиртай. Таарнаа таарна. Элбэгдвэл зузаахан жийрэглээд өмсгөчихгүй юу. Эрэгтэй хүүхэд морь мал дээр явах юм чинь юу алздаг юм.

- За тийм ч байх даа. Наадуулаа боох юм өгөөрэй. - Цууямбуу авах уу?

- Тэгээ, хөлийн жийрэгнийхийг өгчих гэв.

Дамба эндээс худалдаж авсан бараагаа ганзаглан мордохдоо "Ирсэн нь боллоо. Муу хүүгээ гуталтай болгоотой чинь их юм" хэмээн олзуурхан баярлаж түүнээсээ үүдэн "Ямар үр хүүхэдтэй явж үзсэн биш дээ хөөрхий, яаж санах вэ. Тэгээд ч би нөгөөдүүлээ эргэнэ, чи хэдэн чихэр боогоод өгөөрэй" гэж хэлж сануулсан биш, аргагүй шүү дээ хэмээн бодоход нь цэнхэр дан дээл өмссөн Тогоохүү цай хоол хийн хөдлөх нь түүний нүдэнд үзэгдэнэ. Ерөөс Тогоохүүгийн тухай бодох бүр энэ л байдал бодогддог байлаа. Магадгүй анх Дамбын нүд тусган анзаарч харсан Тогоохүүгийн төрхтэр болоод ч тэр байж мэдэх юм. Чухам яагаад өөр байдал төрх бодогддоггүй юм бол гэж Дамба боддог ч үгүй байв. Харин энэ хооронд түүний анзаарч гайхан биширсэн юм гэвэл Тогоохүүгийн амгалан төрх юм. Сэтгэл гонсгор болчихоод ч юм уу ямар нэгэн яльтай яльгүй юманд сэтгэл сэвтгэхэд юм уу эсвэл бүрхэг өдрийн тэнгэрийн өнгө сэтгэлд нэвчин хүйт унах цагийн зэвэргэн салхи цээжинд хурган сэтгэлийг эзгүйрүүлчихсэн юм шиг өдөр царай барайлган орж ирээд Тогоохүүг харахаараа уужирч нэгэн мэдэхэд айван тайван юунд ч шаналах зовних юмгүй болчихдог байлаа. Үүнээс болоод ч тэр үү, энэ арваад хоног түүний урьд өмнөх бүхий л амьдралтай тэнцэхээр жаргалтай байсан мэт санагдав. Үүгээр л бодоход хүний жаргал зовлон гэгч он цагаа хэмжигддэггүй гагцхүү сэтгэлийн улирлаас болох бөгөөд хүсэх, ханах нь эмзэг учраас яахаараа жаргаж, яахаараа шаналдгийн учир явдлыг Дамба эс мэдэх аж. Тогоохүүгийн тэрхүү амгалан тогтуун төрх буугаад мордох хүний сэтгэлийг ч өег болгодгийг Дамба анзаарчээ.

Ирсэн хүн бүхнийг архиар дайлж хоол хийж сүйд болохгүй байхад ч гэсэн тэднийд буусан хэн боловч тавтай сууж айраг цагаа ууж, инээж хөхөрч байгаад мордоно. Энэ бүхэнд хүний хөлд дарагдаж байна гэж санах ч үгүй, энэ тэр ирлээ гэж тээршээх ч үгүй, ирсэнгүй орсонгүй гэж гоморхох ч үгүй, гүүний зэлнээс дундуур саамтай ирэхдээ яав ийв гүү яагаад юм гарахгүй байна гэдэггүйтэйгээ адилхан амгалан тайван хүн аж. Гэтэл уурлаж уцаарлаад байдаггүй ч хүйтэн цайгийн нь шалавхан амсаад мордмоор айлын эзэгтэй алийг тэр гэхэв. Тийм айлд цай чануул, халуун цай уугаад мордооч гэж байхад нь явмаар санагдаад байдаг юм. Яагаад тэгдэг юм болоо? Гэсэн атлаа зарим айлд хүлээж байгаад цайгийн нь амсаад мордоно. Ер нь тэгээд айлын өнгө ч эзэгтэйгээсээ л болдог доо гэхчлэн бодож явснаа "Саяны цэнхэр торгоноос Тогоохүүд авдаг ч байж уу... Сайхан зохино доо. Үгүй тэгээд одоо авчихаад тэрий чинь яах ч юм билээ. Дэжид горьдох ч юм билүү. Горьдоохгүй гээд хаанаа ч хийх юм. Буцахдаа авна гэхээр бас хэцүү. Ханд хэл амтайг хэлэх үү, буцаад очихоор түлэх байх даа. Түрүүн л авдаг байж нэгмөсөн" гэж бодсоор шон дээрээ буухад гэрээс хэн ч гарч ирсэнгүй. "Цугаараа эзгүй байгаа юм байх даа" хэмээн ийш тийш харвал энд тэнд араг үүрсэн, морь малтай яваа хүн эс харагдав. Ганзаганаасаа боодолтой юмаа авч гэрт орвол хүү нь тоглоомынхоо хайрцган доторхийг хойроо асгачихсан тэрэн дундаа сууж байснаа эцгийгээ хармагц ухасхийн босч очиж үнсүүлээд,

- Ааваа та тонгорог авчирсан уу хэмээн асуухад Дамба тэр нэгэн өдөр явахад нь тонгорог авчраарай гэж байсны нь сая санан:

- Аав нь тонгорог авчраагүй гээд боодолтой юмаа өгөв. Хүү боодолтойг эв хавгүй задлан инээд алдсанаа өөрийн хуучин муу майжгий гутлаа тайлж чулуудан шинэ гутлаа өмсч боссон боловч шинэ гуталдаа баригдан явж ч чадахгүй ичингүйрсэн янзтай гутал руугаа нэг харан, эцэг рүүгээ нэг харан зогсоход Дамба:

- Яав? Хөлий чинь барьж байна уу гэхэд хүү толгой сэгсрэв. - Алив нааш ир.

- Хүү эцэг рүүгээ модон хөлтэй юм шиг хөлөө зөөж тавьсаар очиход Дамба гутлынх нь хоншоорыг гаднаас нь барилж үзсэнээ

- Жаахан томджээ дээ гэхэд хүү яаран:

- Үгүй ээ, би холхиндог өмсчихсөн юм.

- Жийрэгээ яасан? Гэхэд хүү хуучин жийрэгээ авчрахаар явах гэв. Дамба: - За тэрүүгээр яах вэ. Наад цагаан цууямбуугаараа жийрэглэчих. Алив аваад ир, би цуулаад өгье гэв. Хүү эцгийнхээ өгснөөр хөлөө жийрэглэн өмсөөд хойш урагш гутлаа нужигнуулан инээд алдан хэсэг явснаа

- Тайлах уу, ааваа гэв. Дамба хүүгээ энхрийлэн харж,

- Өмс дөө өмс гэв. Хүү инээд алдсан хэвээр гутал руугаа нэг харснаа гэнэт: - Та одоо юманд явахгүй биз дээ гэв. Хүүгээ ийм юм асууна гэж бодоогүй байсан Дамба тулгамдан хэдэн эгшин дуугүй байснаа: - Үгүй, үгүй гэхэд хүү:

- Тэгвэл та тоглоомон майхан хийж өгнө гэснээ хийж өгөөрэй гээд хариу ч сонсолгүй, тавиур руу очиж халуун савгай цай авчирч өмнө нь тавиад дахин тийш очиж авдраа онгичиж гарав. Дамба:

- Хайчсан, ээж нь?

- Хонинд явсаан. Ааваа тай зай авчраагүй юү. Манай араажав дуугарахаа байчихсан. Зай нь дуусчихсан л юм байх даа гэж ээж тэгж байна лээ.

- Аа, миний хүү хониндоо явахгүй яасан юм?

- Гадуур эргүүлдүүлээд байх юм. Яаж тогтдог юм. Идэх юм байхгүй байхад чинь гээд өөрөө явсан. Одоо удахгүй ирэх байхаа. - Нүүнэ барина гэж ярьж байна уу?

- Ярьж байна лээ. Эртээр бригадын дарга ирээд нүүхгүй яасан юм гэсэн. - Аа, ээж нь юү гэсэн?

- Нүүнэ л гэж байна лээ... Өө энэ байна гээд тавагтай бин авчирч өмнө тавиад:

- Дараа нь ээжийг загнасан.

- Юу гэж?

- Мэдэхгүй.

Дамба тавагтай бингийн захаас нэг гараар тасдан авч амсах гэсэн боловч чадсангүй.

Лав тав зургаа хоносон бин ажээ. Үүнийг хараад Дамба Дэжидийг өрөвдөх сэтгэл төрөв. Дамбыг хэд гурван хоногоор эзгүй яваад ирэхэд нь заавал нэг аятайхан идэх юм хийж тавьдаг. Тэрий нь Дамба тэгэх ёстой юм шиг ам хүрвэл хүрээд хүүдээ юм уу өөрт нь эргүүлээд өгчихдөг. Дэжид ч түүний нь аван өөрөө Дамбад тавьсан биш, Дамба өөрт нь авчирсан юм шиг амтархан иддэг байжээ. Одоо бол Дамбыг ирнэ хэмээн хүлээж, юм тавин хатгал нь хадгалана гэдэг зөвхөн хүүгээ хуурч байгаа явдал биш цаанаа ямар нэгэн нууцхан итгэлийг хадгалсан болоод л ингэжээ гэдгийг Дамба мэдрэв. Дэжидийг цаашдаа хэрхэн амьдрах бол, яах бол гэж бодохоос түүний яс үс хавгалзах шиг болдог бөгөөд энэ явдал түүний сэтгэлийн эмзэг газрыг дахин хөндөв. Дамба бинг хоёр гардан барьж байгаад захаас нь таслан авч идвэл хүү: - Сайхан бин байгаа биз. - Сайхан бин байна.

- Аав идээч. Ээж бас танд архи тавьсан. Гал руу цацахад пүнхийж байна лээ гээд орны толгойн хөндий рүү очиход нь Дамба:

- Хүлээ, миний хүү. Ээж нь өөрөө ирээд өгөг гэв. Хүү орон дээр суун гутал руугаа харснаа:

- Ааваа, би Багаагийн дорчихоод ирье гээд гүйн гарч одов. Дамба үүд рүү ширтэн айл руу гүйж яваа хүүгийнхээ хөлийн чимээ тасармагц сая үүднээс хараагаа салган гэр доторхийг тойруулан харав.

Цөм түүний ижил дасал болсон эд хогшил. Хэзээ, яаж хэрхэн хийснийхээ үүх түүхий нь байтугай цаашид хэдэн жилийн эдэлгээтэйгий нь хүртэл бараг мэдэх энэ эд хогшлоо хараад нэг их үнэтэй цайтай юмаа гээчихсэн юм шиг харуусал ч төрөх шиг сэтгэл нь гунигтай болжээ. Дамба Хэзээнээсээ юм гээх дургүй, гэсэн дорвол хүнд зүгээр өгчихсөн дээр гэж үздэг бөгөөд хаа нэг ташуур, чөдөрхөн гээчихвэл өдөржин эрэлд хатаж, олохгүй бол хэдэн хоног сэтгэл гонсгор явдаг хүн юм. Энэ нь өнгөцхөн харахад нэгийг бодогдуулах боловч цаанаа нарийн учиртай ажээ. Төрөлхийн гарын дүйтэй Дамба энэ гэрийн ихэнх эд хогшлыг өөрийн гараар хийе бүтээе гэж хийсэн бөгөөд тэрхүү эд юмс нь хэрхэн яаж хийсэн эдэлж хэрэглэж явахад нь юу тохиолдсон, яасан ийснийх нь ул мөрийг хадгалсан байдаг учраас нэг ёсны түүний амьдралынх нь түүхийн нэгэн хэсэг болдог байв. Тийм учраас тэрхүү эд юмсаа тартагт нь тултал эдлэхийг эрмэлзэнэ. Ялангуяа хийе гэсэн сэтгэлээсээ хийж, хийж байгаадаа урам зориг төгөлдөр хийсэн эд юмсаа амьтай юм шиг үзнэ. Харин хүнд хийж өгсөн юмаа бол тэгж боддог ч үгүй, эргээд энэ миний хийсэн юм гэж таньдаг ч үгүй нь өөрөө эдлээгүйгээс тэр ажээ. Хатавчнаас хоймор хүртэлх эд юмсаа харж суусан Дамбын харц авдар дээрх жаазтай зурагны өмнөх хүртэл гөрөөсөн дээр тогтов.

Энэ хүрэл гөрөөс бол Дэжидийн нандигнадаг ганц юм нь гэхэд хилсдэхгүй. Хэр баргийн юмыг хаях гээгдүүлэхэд юман чинээ санадаггүй мөртөө энэ хүрэл гөрөөсийг амь шигээ

хайрлан, нүүдлээр хамгийн түрүүн дээл хунарт боон далд хийж, шинэ нутагт бууж хармаг юмаа тохижуулсны дараа түүнээ гарган тоос шороогий нь арчин жаазтай зурагныхаа өмнө тавьдаг байлаа. Дамба тэрхүү хүрэл гөрөөсийг харж "Энийг л нэг их хайрладаг юм. Юунд нь тэгдэг юм бол доо" гэж бодон суухдаа тэр хүрэл гөрөөсний сэрүүн хэвтэж байгааг сая анзаарч, "Үгүй энэ чинь яагаад дандаа хөлөө жийгээд унтаж байгаа юм шиг санадаг билээ" гэж тэрхэн зуур гайхан анх удаагаа үзэж байгаа мэт ихэд шимтэн харж урьд өмнө нь анзаарч хараагүйгээ анзаарч, өч төчнөөн жил харсаар хэрнээ чухам аль хөлөө яаж жийсэн нүд чих нь ямар болохыг огт мэддэггүй явснаа мэдээд гутрах шиг санагджээ. Өч төчнөөн жил эдэлж хэрэглэсэн эд малаа гэнэт нэг өдөр их сүрхий ажиглан урьд нь анзаарч хараагүйгээ харах явдал Дамбад тохиолддог байсан бөгөөд тэр бүрд нэг бол хүн урьд өмнө анзаарсан ажигласнаа мартчихдаг байх, нэг бол анхнаасаа миний юм гэж бодохдоо хэзээ ч анзаарч ажиглаж амжина гэж хойш тавин улмаар хоног сар улирах тусам мөнөөхдөө сонь буурч юугий нь ч олж харахаа байдаг байх гэж боддог байжээ.

Гэтэл энэ нь өнөөдөр Дамбын мэдэхгүй, шал ондоо учир шалтгаанаас болдог юм шиг, тэрхүү учир шалтгааныг мэдэхсэн гэснээс болж тэр хүрэл гөрөөснөөс өөр юм тэрхэн үед түүнд бодогдохгүй байх шиг санагдана. Анх энэ хүрэл гөрөөсийг Дамбын өвөг эцэг Дамба Дэжид хоёрыг айл болоход "Манайхан үе удмаараа л хадгалсан эд юм шүү. Хичнээн ч үе удам дамжсан юм, бүү мэд. Элэнц хуланцын л юм байгаа байх. Манай аав намайг анх туурга тусгаарлахад иймэрхүү юм хэлээд өгч байсан юмдаг. Уг нь аавд чинь өгөх учиртай эд. Гээд ялгаа юу байх вэ. Хэзээд л дамжсаар чамд хүрээд очихоос хойш. Тэгээд ч цаадах чинь салан задгай амьтан яачих ч юм билээ. Миний хүү хадгалж яваарай. Байлаа гээд ид шид нь юу байх вэ. Байхгүй гээд үгүйлэгдэх нь юу байх вэ. Гэлээ гэхэд эцэг өвгөд, элэнц хуланцаас уламжлагдаж ирсэн юм болохоор харж явахад аятайхан л байдаг юм" гэж хэлээд өгсөн ажээ. Чухам хаанахын хэн гэгч дархан хэдийд, хэнд зориулж цутгасныг хэн ч эс мэдэх бөлгөө. Одоогоос дөрвөн жилийн өмнө сумын сургуульд хэл уран зохиолын багшаар шинэхэн ирсэн нэг залуу тэдний энийг харчихаад "Ямар чамин хийцтэй эд вэ. Арай энэ чинь эртний булш бунхнаас олдсон зүйл биш биз. Мөн ховор эдээ. Ямар дархан хийсэн юм бэ" хэмээн баахан шалгааж, шалгааж эцэст нь "Энийгээ надад зарчихгүй юү. Би зохих үнэ хөлсий нь өгье" гэж шалснаас нь хойш нээрэн ч уран, нарийн хийцтэй эд юм гэж бодох болсон юм. Урьд хоёр хөлийнхөө нэгийг бохирон нөгөөг жийн тайвнаар хэвтэж байгаагий нь харсан хэний боловч харааг үнэхээр булаан, саваагүй сэтгэлий нь хөдөлгөдөг байлаа. Дамба уртаар санаа алдсанаа, мөнөөх хүрэл гөрөөснөөс харцаа салган, жаазтай зурган дотор байгаа цэрэг формтой өөрийнхөө зураг, хөвөнтэй дээлэн дээр улаан бүч зүүсэн Дэжидийн зураг, Хүүгийнхээ дөнгөж сууж байх үеийн зураг сэлт эд юмсын дээрх өлөн тоосыг гүйлгэн харж сууснаа "Ерөөсөө эднийгээ маргааш нүүлгэе. Өвөлжөөгий нь бараадуулаад буулгачихъя. Гэнэтийн цас шуурга болсон ч хашаа саравчтай юм. Хонио аваачаад хашчихад амар. Өглөө эртхэн босч хэдэн тэмээгээ олоод ирье. Тэр хооронд эд нар юмаа төхөөрч байна биз" хэмээн дотроо шийдэн суудлаа засч өндийн суув. Нүүх тухай бодол нь түүний сэтгэлийг зовоож яваа элдвийн бодлоос ангижруулж, сэтгэлийг нь жигтэйхэн тайвшруулах шиг болсонд Дамба дээлээ тайлж бүс, дуран, түрийвчээ авдар дээрх мөнөөх хүрэл гөрөөсний хажууд тавьдгаараа тавин тамхи татан сууж байтал хүү нь "Ээж ирлээ" хэмээн үүдээр шагайн хашгираад буцаж алга болсноо төдөлгүй эхийн хамт орж ирэв. Бодвол "Аав ирсэн, надад гутал авчирсан" гэдгээ аль хэдийн хэлчихээд одоо зөвхөн өөрийн хэлснийг л батлах гэж орж ирж байгаа нь тэр ажээ. Дамба хэвшсэн заншил ёсоор "Хонь тогтов уу" хэмээн дөнгөж сая гэрт хамт сууж байгаад

гадаа гараад ороод ирэхэд нь "Нохой юунд хуцаж вэ" гэж асууж буй мэт тайван, ёс төдий асуув. Дэжид Дамба руу нэг их сүрхий харснаа:

- Тогтлоо гэж хариу хэлээд зуухныхаа өмнө суулаа. Дэжид Дамбыг ирсэн явдалд гайхсангүй. Харин дээл хувцсаа тайлчихсан, яг л хуучнаараа сууж байгаа нь түүнд сайхан санагджээ. Тэрхэн зуурт Дэжидэд тэр хоёрын хооронд юу ч болоогүй юм шиг, амьдрал нь яг хуучнаараа үргэлжлэн байгаа юм шиг бодогдон, сэтгэл санаа нь цэлмэх шиг болов. Хүү нь эхийгээ дөнгөж суумагц аавынхаа авчирсан чихрийг авчирч,

- Тээр, аав ийм их чихэр авчихсан гэв. Дэжид,

- Аан хэмээн хариу дуугараад цааш нь тавих гэтэл хүү нь,

- Алив надад? Хэмээв. Дэжид инээд алдан,

- Миний хүү идээгүй гэж үү гээд боодлыг задлахад хүү,

- Ганцыг ч идээгүй, тиймээ ааваа? Гэхэд Дамба,

- Нээрэн ч амжаагүй байхаа даа гэв.

- Аа мэдэхгүй, аав хүү хоёр хуйвалдчих шиг л бололтой гээд Дэжид:

- За хэдийг авах юм. Багаа, Должин гуай хоёртоо бас амсуулна шүү дээ гэхэд хүү: - Хоёрыг Багаад, хоёрыг Должин гуайд, хоёрыг надад бас хоёрыг гээд тоолон авгал эх нь:

- Үгүй чи чинь өөртөө хоёрыг авчихсан шүү дээ. Тэгээд юун хоёр вэ гэвэл хүү: - Энэ хоёр чинь өнөөдөр идэх хоёр, энэ хоёр нь маргааш идэх хоёр юм чинь. Тийм байгаа биз дээ гэхэд Дэжид Дамба хоёр хоёул хөхрөв. Дамба,

- Миний хүү ч ийм л сэргэлэн хүн дээ гэхэд Дэжид,

- Хэн мэдэх вэ. Ямар хүн болох юм байгаа юм. Ууж идэхдээ л ухаан нь дэндчих л гээд байх юм. Эртээр бригадын даргыг ирэхээр тавган дээр хэдэн чихэр тавьчихлаа л даа. Тэгсэн чинь нэг харсан мань хүн даргын дэргэд суучихсан "Та тэр янгиртайгаас нь ид, тэр нь зүгээр, гэхихсэн сууж байхгүй юу. Тийм үг хэлсэн хүн юу гэж гар хоосон буцах вэ. Тэгээд л чихэр аваад идчихэж байгаа юм" гэснээс үүдэгдэн бригадын даргын ирсэн, ярьсан хэлсний тухай болон маргааш нүүх тухай яриа болоход хүү "Ура" хашгиран гүйж гарав. Айлынхаа хоёр хөгшинд зар хүргэх гэж яваа нь тэр ажээ. Эх эцэг хоёр нь хорьсон ч үгүй, хойноос нь өхөөрдөн, хайрласан харцаар харсаар хоцров. Дэжид бригадын даргын ярьснаас нэгэн зүйлийг Дамбад хэлсэнгүй. Тэр нь юу гэвэл "Манай бригадаас бүх үзүүлэлтээрээ тэргүүлж яваа суурь бол танай суурь. Малын тарга чинь ч овоо байна. Энэ хэвээрээ онд мэнд орчих юм бол ч наанадаж сумын аварга, за тэгээд цаашлах юм бол аймгийн аварга хүртэхийг хэн байг гэх юм. гэтэл чи энд. Дамба тэнд. Энэ чинь яаж болох вэ дээ. Аман хүзүүн дээр нь гэгч болно шүү дээ. Одоо чинь шагнал урамшил, аливаа юманд гэр бүлийн тогтвор суурьшлыг харгалздаг болчихоод байгаа шүү дээ. Тэр байтугай хүүхдийн сурлага, сахилгыг тооцдог

болчихоод байна. За аварга заварга гэж боддоггүй юм гэхэд бригадынхаа хамт олны нэр сүрийг яагаад боддоггүй улс вэ. Ингэж хэлж байна гэж цаад Дамбадаа хэлээрэй. Ер нь тэгээд сум орны удирдлага дуулчихаас өмнө та хоёр учир явдлаа ол, зохиц" гэж Дэжидийг загнасан байжээ. Энэ тухай Дэжид Дамбад хэлнэ гэж бодсон ч үгүй. Гагцхүү тэдний явдлыг хэн бүхэн дуулж, хэн бүхний хэл ярианы бай болж байна гэж бодохоос ингэж явах гэж дээ хэмээн үе үе бодогдсон авч энэ тухайгаа ч Дамбад дурссангүй. Тиймэрхүү юм ярих зав ч тэдэнд гарсангүй. Тэр хоёрын нүүдэл суудал, буусан мордсон улс амьтны тухай ярьж байх зуур нүүдлийн сургийг Багаа өвгөн өөрийн чихээр сонсье гэсэндээ ч тэрүү ашгүй буйр сэлгэх нь гэж баярласандаа ч тэрүү тэднийд орж ирэв. Багаа бол Дамбыг сургууль цэргээр явж эрдэм номтой болчихсон хүн гэж үзэн түүний үгнээс гарахгүйгээр үл барам "Манай энэ хавиас баатар төрөх ёстой л юм бол Дамба л болно. Ажилтай бол ажилтай, номтой бол номтой" гэж хөгшинтэйгээ ярьж суудаг өвгөн билээ. Дэжид Багаа өвгөнийг орж ирмэгц хоёр усаар авч цааш хийсэн байсан нэрмэл архи гарган Дамба тэр хоёрт өгөөд хонь мал хотлуулах, үнээ малаа саахаар гарчээ. Дамба Багаа хоёр шимийн архи ууцгаан, энэ намрын өвч ногооны сөл, ирэх өвлийн зөнгөөс эхлэн сум орон, тив дэлхийн байдлыг хүүрнэн суух зуур оройнхоо ажлыг амжуулсан Дэжид Должин хоёр орж ирж, хоол унд хийж идэцгээн удтал шуугилдав. Тэдний яриаг эвшээлгэн чагнаж сууснаа Цэдэн Иш хүү суугаагаараа унтчихсан байсныг сая харж "Унтацгаая та минь, орой болчихож" хэмээн хоёр хөгшин ч харихаар, Дэжид ч хүүгээ унтуулахаар босов. Дамба морио чөдөрлөж тавихаар гарчээ. Дэжид хүүгийнхээ орыг засч унтуулчихаад гэнэт яах учраа болохгүй тээнэгэлзэн зогсов. Дамбад ор засч өгөх үү, яах вэ гэсэн асуулт түүнд тулгарчээ. Ор засч өгөх ёстой гэж хичнээн ч бодсон, Дамбад тусад нь ор засч өгч яагаад ч чадахгүйгээ мэдээд Дэжид ор руугаа очин ороо яаруу бачуу засч байхдаа "Орж ирэхэд нь орондоо ороод л хэвтчихсэн байя. Өөрөө тусдаа ор засаад унтдаг юм бол тэр л биз" хэмээн бодож яаран сандран орондоо орсон хойноо айх ч шиг, ичих ч шиг санагдан оволзон дэлсэж байгаа зүрхнийхээ цохилтыг тайвшруулах гэсэн мэт үе үе уртаар амьсгаа аван чимээ чагнан хэвтэв. Ийнхүү нэлээд хэвтсэн боловч Дамбын ирж яваа хөлийн чимээ эс гарсанд ухасхийн босч авдраа уудлан, найр наадам, айл хунарт орчихдоо хэрэглэдэг үнэртэй усаа гарган орондоо цацаад буцаж хэвтэхдээ үнэртэй усны үнэрийг ч мэдэрсэнгүй гагцхүү гадаах чимээнд чих тавин байтал Дамбын хөлийн чимээ гарч ойртох тусам нь хэрэг хийчихсэн мэт эмээн хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөөд шургачихмаар санагдав. Дамба орж ирэн:

- Хонь их хол хэвтэж дээ. Шөнө бэлчихгүй байгаа гэхэд нь Дэжид овоо уужирсан хэр нь:

- Гайгүй байхаа гэж хэлэхдээ өөрийнхөө хоолойг ямар их чичирч байгааг мэдэв. Дамба юм ч хэлсэнгүй орны хөл дээр сууж гутал хувцсаа тайчаад Дэжидийн хажуугаар орж хэвтэн лаагаа унтраав.

Хэдэн хором хэн нь ч хөдөлсөнгүй. Тэгснээ Дамба Дэжид рүү эргэн түүнийг тэврэн авч өөр рүүгээ татахад Дэжид ч гарынх нь аясаар түүнд наалдтал гэнэт хайр энхрийлэлд нь умбан, хамаг гомдлоо тоочин цээжинд нь нэвтэртэл уйлья, хүүхэд олсоноо ч хэлье. Юу юуны туханд хүрэлгүй хөөж туусныхаа түмэн бурууг ч хүлээе гэсэн хүсэл нь унтрав. Одоо түүнийг тэвэрч байгаа гар, үнсч байгаа уруул бол урьд өмнө нь түүнийг тэвэрч байсан эр нөхөрийнх нь гар, урьд өмнө нь түүнийг үнсч байсан эр нөхөрийнх нь уруул биш байлаа. Цөм хүний болжээ. Дамбын тэвэрч байгаа үнсч байгаа бүхэн түүнийг гомдоохгүй гэсэндээ өөрийгөө албадсан

шал хуурамч байдал ч юм шиг огт таних мэдэхгүй хүн түүнийг оролдож байгаа ч юм шиг хачин эвгүй санагдсанд Дэжид Дамбын тэврэлтээс мултран, огцом эргэж буруу харан хэвтээд мэгшин уйлав. Энэ мөчийг хүртэл Дэжидэд хадгалагдаж явсан итгэл найдварынх нь зул бөхжээ. Өөрийнх нь эр нөхөр байсан Дамбаас юу ч үлдээгүй болохыг Дэжид дахин дахин мэдрэх тусмаа мэгшин уйлсаар байлаа. Дамба аргадах гэж таталж чангаасан ч үгүй. Өөрийгөө яаж ч албадаад Дэжидийг тайтгаруулж чадахгүйгээ, яаж ч аяглаад нэгэнт хөрчихсөн сэтгэлээ нууж чадахгүйгээ, тэр ч байтугай бүр бие сэтгэлээр хөндийрчихсөнийгөө мэдрэн "Яах гэж Дэжидийн өвөрт оров оо. Хүүгийнхээ хажуугаар л ороод хэвтчихгүй" хэмээн өөрийгөө зэмлэн хэвтжээ. Шинэ нутагт бууснаасаа хойш Дэжидийн сэтгэл улам ч эл хул ямар нэгэн юмаа гээчихээд цөхрөлтгүй эрэлд хатан явах мэт болов. Дамбыг зөвхөн нүүлгэж буулгачихаад хүний хүн шиг давхиад явчихсанд нь ч бус, ерөөс сэтгэлд нь нэг их юм онгойрч эзгүйрэн, тэрийгээ мэдрэх тусмаа үгүйлж харамсах ажээ. Дамба одоо тэртэй тэргүй хүний хүн болжээ гэдгийг Дэжид ой тойндоо ортол ухаарчээ. Нүүхийн өмнөх өдрийг хүртэл яв гэсэнд л гоморхож явчихаад байгаа юм. Удахгүй эргээд ирнэ. Бүх юм хуучин хэвэндээ орно гэж бодож байсандаа ч тэрүү, хэлж мэдэхгүй далдын нэгэн итгэл түүний сэтгэлийн орон зайг эзэлж байсан юм. Одоо бол Дэжидийн сэтгэл, гэрэл гаргая ч гэхнээ ганц ч шүдэнзгүйгээ мэдрэн харанхуйн дунд суугаа хүний сэтгэлтэй төстэй бөгөөд Дамба эргэхгүй явжээ гэдгийг бие цогцос, сэтгэл санаандаа улам улам бат нот ухаарах тусмаа энэ шинэ нутаг шинэ биш санагдана. Нүүхгүй байж хэзээ ч болохгүй гэдгийг цаанаа мэдэж байгаа хэрнээ хэрэггүй л нүүж гэж бодогдоно. Юу дурсаж санахаа мэдэхгүй хэрнээ харин ч хуучин нутаг нь дурсан санах юмтай мэт, түүний сэтгэл санааг эзгүйрүүлээд байгаа хамаг бүхэн хуучин нутагт нь үлдсэн мэт бодогдоно.

Урьд нь шинэ нутагт буусны дараа хонь мал ч гадаа хэвтэх нь хэвтэж, идээшлэх нь идээшилж, гэр бараа ч тоос шороогүй цэвэр цэмцгэр, хийсэнхоол ч амттай, аргал түлээ түүсэн ч хаяанаасаа ер ийм тиймд сэтгэл хоёрдохгүй амгалан тайван хүсэх үгүйлэх юмгүй хоёр гурав хоног жаргалтай нь аргагүй сайхан байх шиг байдагсан. Одоо тийм ч юм алга. Огт таньж мэдэхгүй хүний нутагт отроор явж байгаад хоног таарч нэг газар буудалчихаад, зангий нь мэдэхгүй газар яаж хононо доо, чоно нохой эргэдэг болов уу, яадаг бол гэж сэтгэл зовнидог шиг нэг л харь санагдана. Уг нь энэ нутагт энэ жил бууж байгаагийнхаа хувьд шинээс биш, намар оройхон болохоор өвөлжөөгөө бараадан жилийн жилд л буудаг, өвс ногоо, чулуу шороогий нь хүртэл андахгүй мэдэх газар билээ. Ойр хавийнх нь таана хөмүүл сугсалзсан хэсэг бусаг ногоон буйр цөм л эднийхний ноднин, уржнангийн буйр бөгөөд харанхуй шөнө явган гүйцсэн ч бүдрэхгүй газар атал яагаад ч юм энд буусан нь дэмий санагдана. Ядахдаа уржнан намаржсан Хүрэн овооны энгэрт ч юм уу, тээр жил тэр нэгэн өдөр Дамбыг тэднийд ирэхэд байсан нутаг болох Хөх дэрсний хондонд ч юм уу, Дэжидийн тавдугаар ангид орох намар нь буусан Улаан дэлд ч юм уу, аль эсвэл нэгэн их элсэрхэг газар нүүгээд буучихсан гэрээ ч бариагүй Дэжидийг наршчихна гээд эх нь авдрын сүүдэрт суун хөл дээрээ элс асган тоглож байсан тэр нутагт буусан бол сэтгэл өег байх байсан ч юм шиг, тэр дундаа ээжийнхээ сэрүүн тунгалаг ахуй цагт нутагладаг байсан нутагт буучихсан бол сая сэтгэл амар байх байсан мэт санагдана. Ер нь сүүлийн үед ээжийнхээ ярьж, хэлж байсан үг, ээждээ уцаарлаж, туниж, зөрүүдэлж байсан бүхэн нь эргэн бодогдож, тэгэхэд муу ээж минь надад гомдсон байх даа гэж хэзээ хэрхэн юү гэж хэлснээ тодоос тод санан, тэр бүрд өөрийн эрхгүй хоолой нь зангирч нулимс унагаадаг байлаа.

Дамба Дэжид хоёрыг айл болсны дараа эх нь дөрвөн ханатай жижиг гэр барин тэднийтэй айл явдаг байсан үе байлаа. Нэг орой "Хөхүүр дүүрчихлээ. Хоосон сав байна уу, сүү юүлье"гээд ээжийндээ орсонд эх нь галын аман дээр суучихсан уйлж суув. "Яав ээжээ, бие зүгээрүү" гэхэд эх нь "Бие яах вэ, хэвтчихгүй л бол хүн эрүүл саруул яваад байна гэж боддог хойно босоо шүү л байна. Хүнд чинь биеэс гадна сэтгэл гэж нэг юм байдаг юм байна шүү, хүү минь. Хүн гэдэг хөгшрөх тусмаа хүнээр бөөцийлүүлэхийг боддог юм байна. хэн нэгтэй бодсон санаснаа дэлгэн суумаар ч л бодогдох юм. Заримдаа мэдээ чимээ өгч чадалгүй үхчихээд өдий төдий болчих вий ч гэж айх юм. Би ер нь манайд хүн битгий орж ирээсэй гэж бодож яваагүй болохоор хүн хар орж ирэхгүй болохоор чинь хэцүү юм байна шүү дээ. Сураагүй болоод л тэр байх даа" гэжээ.

Тэгэхэд нь Дэжид сэтгэлий нь засах олигтойхон ч үг хэлж чадалгүй хий дэмий л дуугүй жаахан сууж байгаад гарахдаа "Зарим нэгтэй адилхан явуулын амьтан дагаад өөр аймаг сум алгасаад алга болчихвол яах нь вэ. Дэргэдээ аваад, өргөж тээгээд явах тусам цаашлах гэж. Яалгах гэсэн юм. Тийм л ганцаардаж уйдаад байдаг юм бол бидэн дээр ороод инээж хөхөрч, ярьж хөөрч байхгүй гэртээ шигдчихээд байх юм чинь" гэж тунирхан бодсон авч дорхноо "Үгүй бас хэр ч байгаа даа. Туурга тусдаа бол тусын дайсан гэгчээр тусдаа орон гэртэй болохоор, гэр орныхоо ажлыг эмхэлсээр зарим өдөр орохгүй ч өнжчих өдөр гардаг л байх. Хаа нэг орлоо ч тав тухтай таван үг ч солих завгүй энэ тэр юм авах өгөх нэрийдлээр ороод бараг босоогоороо шахуу байж байгаад л гардаг байх. Тэгсэн хойно уйдалгүй ч яахав дээ. Гадна дотноос хүн хар ирлээ ч манайд орчихоод л мордоод явчих юм чинь, хэр ээ. Одоо өдөрт зориуд орж сууж байя байз" гэж шийдсэн хэр нь гэртээ ормогцоо энэ тэр юм хийж ингэж тэгсээр мартагнан мөн л бахь байдгаараа зарим өдөр бараа бараагаа харалцаад ч өнгөрөх өдөр байдаг л байлаа. Энэ нь хань бүлтэй өөрийн гэр оронтой, дутагдах гачигдах нь үгүй болохоор жаргалдаа ташууран төрсөн эх, өөрийн гал голомтоо мартан огоорсон байдал харагдах боловч үнэхээр санаж сэрээд, эхийнхээ гэрт орж хоол цайнаас нь хуваалцан тав тухтай сууя ч гэсэн ярих хөөрөх юм олдохгүй. Эх нь л юм ярихгүй бол дуугүй сууна гэсэн үг. Гэтэл тэрэн шиг бэрх юм Дэжидэд үгүй мэт санагдан, гараад явчихьяа гомдох болов уу гэж эмээнэ. Ингээд суугаад байяа тоож юм ярихгүй байна. Би хөгширч хэнд ч хэрэггүй болсон амьтан гээд уйлж унжаад унавал яана гэж бодно. Дамбатай ярьдаг хөөрдөг юмаа ч ярилтай биш бас ч хэцүү юм тулгана. Зүй нь бригадын төвд тэгж ингэж гэнэ, сум нэгдлээс ийм тийм шалгалт ирэх гэнэ, яах вэ ийх вэ гээд сэтгэлий нь аятайхан засчихаад гараад явчихаж болох байтал Дэжид тэгж худлаа аяглаж үл чадах ажээ. Хар нялхаас эхийн дэргэд явсан, тэгээд ч отгон охин нь болохоор эхдээ онгог, эрх дураараа өссөн нь нөлөөлдөг байлаа. Түүний зэрэгцээ энэ тэр ажлаа их л удаан амжуулж, яль шальгүй гар хөлийн үзүүрээр хийчих юманд заавал зав зай хайх тул түүний ажил барагдаж зав гарах нь ч ховор. Тэгээд ч багаасаа эхийн ам харж, ингэ тэг гэснээр нь хөдлөөд сурчихсаныг хэлэх үү, Дамба угаас гадаа гэртгүй хөдөлж энэ тэрийг өөд нь татан, тэрийгээ тэг, энийгээ ингэ гэх болсон нь түүний амыг харан улам ч назгайрах болжээ. Энэ байдлы нь эх нь хараад үл тэвчих учир зарим үед үглэх яншихаас халшран нүднээс нь далд өнжихсөн ч гэж боддог өдөр гардаг байжээ.

Энэ бүхнээ одоо эргэн эргэн санах бүр нулимс нь цийлэгнэн ирж эхийгээ өөд болох цагт ингэж үгүйлэн гашуудаагүйгээ одоо үгүйлэн харамсана. Эх нь амьд сэрүүн байсан бол Дэжид яавч ийм зовлон амсахгүйгээр үл барам Дамбаас саллаа ч сэтгэлд нь хоосон хоцорсон зай бүхнийг бөглөж, орлож чадах юм ганцхан эх нь л юм шиг бодогдоно. Тэр ч бүү хэл эх нь амьд

сэрүүн байсан бол гэдсэндээ хүүхэдтэй хоцорч байгаа нь юу ч биш, бодох санах, зовних уурлах, ичих юу ч биш шиг бодогдоно. Гэтэл ингэж өнгөрсөн улирсныг үгүйлэн дурсан нь маргааш "ях билээ, хэрхэх билээ" хэмээн шаналах шаналал зовнилыг нь улам ч ихэсгэж байгааг Дэжид өөрөө ч мэдэхгүй, мэдлээ ч санах үгүйлэхгүй байж чадахгүй билээ. Ерөөс хүн гэгчийн өнгөрсөн нь сэтгэлийнх нь хөрс болдог бөгөөд үйлийн салхийг үелзэх бүрд хүмүүн мөнөөх хөрснөөсөө зууран, мөнөөх хөрснөөсөө шим тэжээл эрэлхийлдэг ажээ. Нөгөө гэвэл шинэ нутагт буусаар мал тогтуун, элдэвт санаа зовних юм одоохондоо үгүй атал таана хөмүүлийн толгойд шар туяа татчихсан байгааг, нарны илч буураагүй налгар дулаахан байгаа хэрнээ хаа нэгтэйгээс сэвэлзэх салхины үзүүр цаанаа л нэг гэгэлгэн буйг Дэжид мэдрэн өвөл гэгч санааны мухарт бус барааны газарт цэнхэртэх уулсын оройд будран хэзээ хэзээгүй тал руу буух гэж буй мэт бөгөөд "Жар гарсан хоёр хөгшин, хуруун чинээ ганц хүү бид хэд яана даа. Ядаж бие давхар" гэж бодогдон шүүрс алдана. Одоохондоо морь мал унаж гадуур дотуурхи ажлаа амжуулахад саад болохгүй ч хоног цаашлах тутам томорч морь унахад бүүргэнд тулаад явж болохгүй болохоос эхлээд араг үүрч аргал түүх хүртэл саарна. Багцааг бодоход мал ид төллөхтэй давхцаж байгаа нь Дэжидийн янзыг үзэх гэсэн мэт улам ч хясч байх мэт ажээ.

Урьд нь Дэжид ингэж ирэх цагийн зөнг мэдрэх нь бүү хэл, чухам хэдийд яаж намар шувгарч, өвөл залган хавартай золгодгийг эс мэдэх бөгөөд нэгэн мэдэхэд өвөлжөөнд бууж, идшээ хийцгээж бужигналдаж, нэгэн мэдэхэд цагаан сар болчихсон золгоцгоож, нэгэн мэдэхэд айраг цагаа дэлгэрчихсэн наадамд ямар дээл өмсөх билээ болчихсон байдаг байжээ. Хүүхдийн тухай ч мөн ижил. Анхны хүүхдийг олчихсон үгүйдээ эргэлзсээр явгал нь нэг мэдэхэд гарах болчихсон байсан санагдах бөгөөд чухам хэдэн сартайгаасаа хөдөлж хэдэн сартайгаасаа гадуурхи ажил хөдөлмөрөөс хөндийрч гэр зуур эргэлдэх болдгийг мартсан буюу хожим хойно хэрэг болно гэж анзаараагүй өнгөрсөн учир одоо анх удаагаа хүүхэд олсон мэт биеийг чагнан гутарч гуних өдрөө Дамбаас гэдсэндээ хүүхэдтэй хоцорчихож гэж хэн ч бодохгүй. Дэл сул амьтнаас л олчихож гэж ойр хавийн хүүхэн чавганц нар шуугих болно гэж бодохоос дутуу гаргачихмаар санагдан, хэзээ хэн яагаад дутуу гаргачихлаа гэж ярилаа гэдгийг санахыг оролдох авч юу ч үл санана. Хүн амьтнаас асууя гэхээр сургууль соёлоор хамт явсан найз нар малын бэлчээрээр уулзалдчихаар ойргүй, айлын хөгшин ойролцоо нутаглах хүүхэн чавганц нараас асууя гэтэл хэл амнаас нь эмээх тул хий л шаналан, нэг өдрийг өнгөрөөж нөгөө өдрийг үзэхдээ өчигдөрийн бодлоо эргэцүүлэн, юү гэгчийн муухай юм бодов оо, хүүхэд олчихсоноо анх мэдэрч яаж их баярлаж байлаа, эргэлзэл бүхнээ арилган гарцаагүй олжээ гэдгээ өөртөө баталсан хойноо Дамбад хэлнэ гэж нандигнан хадгалж яваагүйсэн биш билүү, ёстой хүүгийн минь заяа гомдох байгаа даа, ямар амьтан үр хүүхдээ дутуу зулбан гараасай гэж боддог байна хэмээн өөрийгөө зэмлэн, өөрийнх нь энэ бузар муухай бодлыг хүн мэдчихээгүй байгаа гэж эмээхэд ч хүрдэг байлаа. Тэр ч байтугай олсон даруйдаа Дамбад хэлчихсэн бол ийм явдал болоо ч уу, үгүй ч үү хэмээн бодогдож, хэлээгүйдээ харуусах бөгөөд суугаад долоон жил болсны хойно анхны хүүхэд гарч түүний долоон насан дээр хоёр дахь хүүхдийг олж байгаа нь ч гэсэн түүнд хачин тохиолдол шиг санагдан долоогийн тоо муу гэдэг үнэн юм биш байгаа гэж бодоход хүргэх боловч үр хүүхэдтэй болж байгаа маань муу юм гэж үү дээ гэж бас эргэлзэл төрнө.

Энэ мэт элдвийн бодлоосоо болоод ч тэрүү ер нь шинэ нутагт бууснаасаа хойш гэртээ байх дургүй болчихсондоо ч тэр үү, аль эсвэл цаашдаа хөл хүндэрч хонь малд явж болохгүй

болчихоор аргагүйн эрхэнд айлын хоёр хөгшин л явах тул одоо би явж болж байгаа дээрээ яваад байя ч гэж бодсон уу бараг өдөр болгон шахуу хонинд явдаг болов. Хоёр хөгшин ч байдлыг гадарласан болохоор онц их гайхсангүй. Сэтгэл санаа нь тогтворгүй болчихсон амьтан, хээр хөдөө алсыг харж явах өөрт нь амар байдаг байлгүй гэж ярилцан дуртай нь аргагүй зөвшөөрдөг байв. Үнэхээр ч гэрт байснаас хээр хөдөө энэ тэрийг харж явах нь Дэжидэд хөнгөн байх шиг байдаг байлаа. Ийнхүү явах зуур түүний урьд өмнө хэзээ ч төрж байгаагүй нэгэн бодол төрсөн бөгөөд тэрхүү бодол нь түүний сэтгэлийг зовоож байгаа бүхнээс аврах цорын ганц арга мэт санагдаж болжээ. Тэр бодол нь энд хэрэггүй буулаа гэдгээс ч хоёр хоногийн өмнө буугаад мордсон нутгийн нэгэн авгайн үг алдуулан Дамба тэр хоёрын явдлын талаар юм сонсох гэж ирсэн юм шиг сонжингуй харсаар суусан харцнаас ч, ер нь цаашдаа бууж мордох иймэрхүү улсын асуухгүй хэрнээ үнэн худлыг үзэх гэж ирсэн юм шиг элдвийг сонирхох байдлаас ч гаргах юм шиг санагдана.

Хоног хугацаа өнгөрч алив бүхний сонь буураад ирэхээр Дамба тэр хоёрын сууж байсныг ч аандаа мартаж бөгөөд тэр болтол амьтны нүднээс хол явах нь дээр гэж бодсон бодолд нь саяхных нь нэг зүүд улам ч түлхэц болжээ. Тэр зүү бол хүрэл гөрөөсний тухай зүүд юм. Хэдийд яагаад амь орчихсоныг бүү мэд толиных нь урд байдаг хүрэл гөрөөс амь орчихсон нэгэн их цэлгэр талын дундуур цааш цахилах бөгөөд Дэжид хойноос нь шилбүүр барьчихсан явган гүйнэ. Дэжидийг гүйх тусам гөрөөс цаашилсаар зээр гөрөөсний сүрэгтэй нийлэн цахилан цахилсаар холдоход цөхөрч туйлдсан Дэжид суун тусч, яагаад ч гүйцэхгүйгээ мэдрэх, их л харуусч байна гээд сэрчихжээ. Зүүдэллээ гэдгээ сэрүүт мэдсэн хэрнээ гэрэл гаргамаар санагдан лаагаа асаавал өнөөх хүрэл гөрөөс нь хөлөө жийн хэвтсэн хэвээр харагдана. "Яагаад би ингэж зүүдлэв. Хүн өдөрт бодож явснаа зүүдэлдэг юм гэсэн. Би энэ тухай ер бодоогүй юмсан. Хачин юм даа" хэмээн бодож тайвшрахыг хичээсэн боловч зүүднээс хоцорсон харамсал хэвээр... Нойр нь хүрсэнгүй. Толгой нь өвдөж байх тул толгойныхоо өвчнийг дарах санаатай эм олж уухаар авдраа уудалсан боловч эм олсонгүй. Хүүхэд бүлээрч, ийм тийм эм хэрэгтэй болоход Дамба авдрнаас л авч өгдөг байсан гэж бодон эрээд олдсонгүй.

Ингэсээр үүр цайлгасан ажээ. Тэр өдрөөс хойно яагаад ч юм эзгүй яваад ирэнгүүт өөрийн эрхгүй мөнөөх хүрэл гөрөөсний зүг хардаг болжээ. Тэр ч байтугай нэгэн удаа далд хийчихье гэж бодсон боловч хүүгийн шалгаах, айлын хоёр хөгшнийг элдэв муу юм саначих болов уу гэж санан больсон нь бий. Энэ зүүд түүний сэтгэлийг улам ч тогтворгүй болгов. Энэ бүхэн хуримтлагдсаар тэрхүү бодлыг биелүүлэхээс өөр аргагүй болгожээ. Энэ бодол бол хүүтэйгээ хоёул говь руу оторт явья гэсэн бодол байлаа. Энэ бодол нь өдөр ирэх тусам болих уу, яах вэ гэж бодогдуулахаасаа "Хэзээ явах вэ" гэж бодогдуулах нь их болов. Нөгөө гэвэл ингэж ойрын отор хийх нь малын таргад ч хэрэгтэйгээс гадна өвөлжөө бууцныхаа ойр орчныг өвлийн хахир хатуу цагт нөөцлөхөд хэрэгтэй бөгөөд хэдийгээр гэдэс гүзээ нь унаа унаж болохгүй боллоо ч тэнгэрийн тогтуунд энэхүү нөөцөлсөн бэлчээртээ хонио явган хариулахад ч болох юм гэж бас боджээ. Өдөр ирэх тутам биежсээр байсан дээрх бодол нь Дэжидийг яаруулах болсон тул нэг өдөр айлынхаа хоёр хөгшинд "Та хоёр гэр орноо сахиад хэдэн үхэртэйгээ үлд. Хүү бид хоёр хонио аваад баруун говь руу орж хэд хоночихоод ирье. Тэмээ тэртэй тэргүй говь руу зүтгээд байгаа юм. Бид хоёр тэндээсээ бараа харья" гэсэнд Дамбын үгнээс хэзээ ч гарч үзээгүй Багаа өвгөн "Намар бүхэн л энэ мэт өвөлжөө бууцаа түшин, дөхөж буучихаад болоод л байдаг байсан юм болох л байлгүй. Энэ жил яагаалхав гэж. За үнэхээр бригад сумаас отор хий барь гэж шахаад ирэх юм бол бид хоёр явна уу гэхээс чамайгий чинь хуруун чинээ

хүүхэдтэй эзгүй говь руу явуулчихаад бид юугаа бодож суух билээ. Тэр ч барахгүй ажил байхаа. Гээд бод л доо. Уг нь өдийд ногоо нь нялхаараа сугсалзаад говь шиг сайхан юм хаа байх вэ. Мал ч бэлчээр соргог сайхан болох тусам шилэн сорчилж гүйгээд таргалж гүйцдэггүй юм. Амьтны нь араншин биз дээ. Хүн ч мөн ялгаагүй элбэг дэлбэг, бэлэн зэлэн байх тусмаа улам цаашлаад байхгүй юмыг үгүйлээд байх юм хойно, мал ч хэр биз дээ" гэжээ.

Дэжид юү ч хэлсэнгүй, хэлэх ч үг олдсонгүй. Урьд нь отор хийж яваагүй болохоор тийм ийм гэх юм байх ч биш. Тэгээд ч өвгөний хэлсэн оргүй худал үг биш тул бас ч эргэлзэв. Нээрэн ч долоон настай хүүхэдтэйгээ хоёулханаа хүн амьтангүй, эзгүй говьд хээр хөдөө хононо гэж бодохоос айдас хүрнэ. Хэдийгээр энэ тал нутагт чоно байхгүй, Дэжид ч өдий хүртлээ чоно үзээгүй боловч хүмүүсийн амнаас аманд дамжин домог мэт хэлэлцэх айдас хүрэм яриа санаанд нь орж элдэв дэмий юм санаж сэдсэндээ өөрийгөө зэмлэжээ. Харин ямар азаар хүүдээ хэлчихсэнгүй вэ. Учир мэдэхгүй юм болоод тэр чинь явья барья гээд шалчихна гэж боджээ. Ер нь сүүлийн үед Дэжид хүүдээ юуг хэлэх вэ, юуг хэлэхгүй байх вэ гэдгээ урьдаас заавал боддог болжээ. Тийм ч учраас тэгж асуувал нь тэгж хэлнэ гэж урьдаас заавал бодох болсон ажээ. Гэвч ихэнхдээ хүү нь Дэжидийн бодоогүй санаагүй юмыг, худлаа ч хэлэхэд хэцүү, үнэнийг ч хэлэхэд хэцүү талаас нь асуудаг байлаа. Өдөр ирэх тусам хүүхэд эцгээ санаж байна гэдгийг, яаж ч худлаа хэлээд үнэнийг далдалж чадахгүй юм гэдгийг Дэжид ойлгох болов. Түүнд хэн ч юу ч яриагүй хэр нь өөрийнхөө зөнгөөр, томчуулаас ондоогоор ухаарах ухаарлаараа үнэнийг мэдэрч, мэдэрсэн тэр цаг мөчөөсөө эхлэн тэр тухай элдвийг асуухыг ч больж, гаднаас харахад огт тоохоо больчихсон мэт болдог ажээ.

Сүүлийн үед чихэр жимс, хоол унднаасаа эцэгтээ тавих гэж зүтгэхээ ч больж, дуу нь цөөрч үе үе нүд нь бодлогошронгүй энэ тэрийг хий гөлрөх болсон нь Дэжидийн сэтгэлийг зовоож аргаа барахдаа амьтан хүнээр "Хүүхэд санаад бэтгэрэх нь. Нэг ирж үзээч" гэж хэлүүлэе. Тэгээд хүрээд ирдэг юм бол уйлж дуулж байгаад ч болсон үр хүүхдээ бодье буцаж сууя гэж гуйдаг юм билүү, урьд өмнөхийг нь огт болоогүй юм шиг мартчихгүй юү. Мартъя л гэвэл ер мартагдашгүй юм хаа байх вэ. Надтай яаж анх учирч байсан хамаг бүгдээ, арваад жилийн амьдрал, үр хүүхдээ мартчихаад явчихаж чадах байхад би чадахгүй ер юү болсон юм. Хүн гэдэг чинь ерөөс сайн сайхан, муу муухайгаа мартчихдаг л амьтан юм чинь. Хаман бүхэн надаас л болсон. Би л ам түргэнтэйдээ хөөсөн. Дамбад огт буруу байхгүй... хамаагүй тэрнээсээ салж хагацаж чаддаггүй юм бол ирж очоод явж л байг л даа. Би л мэдээгүй сонсоогүй юм шиг байя. Тийм улсууд байдаг л юм чинь... Зарим нь тэгж амьдраад болоод л байгаа юм чинь яадаг юм. Ганцхан намайг л бүү орхиг. Ингэж явж чадахгүй нь гээд гуйхад хүн байна даа даанч нэгийг бодно биз. Намайг өрөвдөх биз гэж бодогдон ингэж хэлэхээр Дамба түүнийг аргадна. Магадгүй урьд өмнө тэгж энхрийлж, хайрлаж байгаагүйгээр түүнийг энхрийлэх ч юм билүү гэж бодогдоно. Энэ бүгд зөвхөн түүний бодол биш зайлшгүй болох бүтэх юм шиг бодогдон сэтгэл санаа нь ч тайван амгалан болчих шиг болно. Надад муу юм бий. Өөрийгөө зөнд нь хаясан энэ тэр гээд... Тэр яахав болно. Дамбыг ч дутуу хайрласан юм бий л байх. Хүний хүнийг хайраар татчихаж хүн чадаж байгаа юм, би өөрийнхөө нөхрийг хайраар дутаав гэж үү. Би хүн хайрлаж энхрийлэхэд бусдаас мөч дутуу төрсөн гэж үү ч гэж бодогдох бөгөөд ийнхүү бодоход нь хэнээс ч илүү хайрлаж, энхрийлж, халамжилж хэнээс ч илүү хайр энхрийлэл, халамж хүсч чадах юм шиг санагдана.

Ингэж бодохоор яагаад ч юм заримдаа Тогоохүүгийн очмоор, Тогоохүүг хармаар, юугаараа

Дамбын сэтгэлийг татчихсаны нь мэдмээр санагдана. Одоо болтол түүний мэдэхсэн гэдэг юмны нэг бол Дамба Тогоохүүгийн юунд нь болсон юм бол гэдэг бодол юм. Энэ нь өөрт нь тайлагдахгүй байгаа нэг нууц юм шиг санагдан үе тэнгийн хүүхнүүдээс Тогоохүүгийн тухай мэдэх юмсан. үс, зүс, нүүр царай сайхантай гоё хүүхэн байдаг болов уу. Аль эсвэл ажил төрөл, алдар нэрээрээ гаргууд юм болов уу ч гэж бодно. Заримдаа тэмээ мал эрсэн сурсан болоод тэднийхээр буух юмсан ч гэж хүртэл бодно. Ер нь Дамба одоо нэг ирэх болсон, ирэхэд нь л гуйя. Хэд гурав хоног хараад ирэхгүй бол ир гэж хэл өгье гэж эрс шийдэн, хоёр гурван хоног хонь малд ч явалгүй тувт гэр орноо цэвэрлэн юм хүмээ угаан, боов боорцог чанан, тогоо нэрэн гэр орноо өөд татах болсон нь айлынх нь хоёр хөгшинд аятай таатай санагдан бас ч битүүхэндээ Дэжид юунд ингэтлээ бэлдээв? Ямар зочин ирэх гэж байгаа юм бол гэж бодох болов. Хамаг юмныхаа тоос шороог гүвж, угааж арчин мөнөөх хүрэл гөрөөсөө зүлгэж байхдаа сая гэр орныхоо эдэлж хэрэглэж байгаа эд хогшлоо анзаарч зарим нэг хуучирч өнгө зүс алдсаны нь хэмхчээд түлэхийг нь түлж хаяхыг нь хаячихаад, гэрийнхээ модыг будаж, шинэ авдар сав ч авч тавимаар бодогдов. Нугастай шинэ толь ч аваад тавьчихмаар санагдав.

Сүүлийн үед айлд ороход хамгийн түрүүн толь нь нүдэнд тусан тунгалаг сайхан тольтой айл сайхан санагдах болж, өөрийнхөө хуучирч цайр нь хөдөлчихсөн муу толийг хагалаад хаячихмаар бодогдоно. Хааяа зочин гийчин ирэхэд ч юм уу, сар шинээр дэвсдэг хивсээ хүртэл гүвэн дэвссэнд хүү нь манайд хэн ирэх гэж байгаа юм гэж шалгаасанд Дэжид хэлэх үг олдсонгүйдээ "хэн ирдэг юм. Хэн ч ирэхгүй" гэж худлаа уцаарлан дуугүй болгосон боловч хүү нь гэр орон цэвэр болсонд сэтгэл нь засагдан баяр төрөв үү, аль эсвэл хэн нэгэн хүн ирэх нь. Ямар гэгчийн чихэр жимс авчрах бол. Хотоос ирэх юм бол надад тонгорог авчрах болов уу үгүй болов уу гэж эхийгээ битүүхэн чагнана.

Багаа өвгөнийг сумын төв ороход нь гар нүүрийн саван, радиогийн зай ч захив. Хүүгийнхээ хөл толгойг угааж, хамаг хувцсыг сольж гадагшаа гарахад нь өмсгөдөг шинэ тэрлэг, эцгийн нь авчирч өгсөн гутлыг өмсгөв. Энэ бүхнийг харсан айлын нь хоёр хөгшин, хүү гурав нь яах аргагүй холын зочин ирэх нь гэж бодож, энэ тэндээс ирж яваа хүний бараа, машин тэрэгний дуунд чих тавьцгаах болжээ. Өөрөө ч үс толгойгоо угаан найр наадамд өмсдөг улаан торгон дээлээ өмсөх гэснээ амьтан хүнээс зовоод хуучивтар ногоон торгон дан дээл өмсөж, хөлдөө хагас өсгийтэй цагаан шаахай өмсөн, дахин дахин тогоо нэрж ааруул ээзгий буцалган ер борви бохисхийлгүй хөдлөн, энд тэндээс ийм тийм зочин ирнэ гэхгүй хэрнээ орж гарахдаа алсыг харж байгаа нь яах аргагүй хэн нэгийг хүлээсэн шинжтэй. Тэгтэл сумын төв орсон Багаа хөгшин ирж түүний захисан оо, саван, хүлээн авагчийн зайг авчирч өгөхдөө "Дамбатай дайралдлаа. Цэдэн Ишид өгөөрэй гэж энэ тонгоргийг өгч байна" гээд нэгэн жижигхэн эвхмэл тонгорог өгөв. Энэ үг Дамбыг ирнэ гэж бодож байсан Дэжидийн итгэлийг мохоон "өөрөө авчраад өгчихөж болсонгүй гэж үү дээ" гэж дотроо гомдосхийсэн авч айлын хүн дайралдахаар хэн ч түрүүлээд өгүүлчихээ гэж бодох шүү дээ" гэж зөвтгөн сумаас буцахдаа дайрах нь гэж тааварлав. Цэдэн Иш хүү ч тонгорготой болсондоо баярлан эхийгээ ирлээд аль гэж шалав. Дэжид хүн болсоор хутга ирлэнэ гэгчийг мэдэхгүй тул арга буюу хүүгийнхээ шалаанаас гарахын тулд "билүүгээ тонгорготойгоо бариад Багаа дээрээ оч" гэсэнд хүү ухасхийн орон доороос аавынхаа дархны хайрцгийг татан гаргаж уудалснаа алга гэв. Хайчив л гэж гэсээр очиж уудалвал нээрэн алга байлаа. Билүү байтугай бахь, шор, шөвөг, хуурай, жижиг алх сэлт нь цөм байхгүй байлаа. Дэжидийн хамаг бие сулран самсаа нь сарталзан ирэхэд хоёр гараараа нүүрээ дарав. Хүү яах ч учраа олохгүй бүлтэгнэн байснаа ээж рүүгээ

дөхөн очиж "Ээж битгий уйл л даа" гэж толгойг нь илэх аядахад Дэжид хүүгээ элгэндээ тэвэрч "ээж хүү хоёр гэж нэг хоёр хүн яаж шүү амьдрана даа" гээд учиргүй мэгшин уйлав. Хүүхэд эхийнхээ энгэрт наалдсан хэвээрээ үг ч хэлсэнгүй, хөдөлсөн ч үгүй. Дэжид жаахан уйлчихаад дотор нь онгойсон бололтой уртаар санаа алдан "Миний хүү Багаадаа тонгоргоо аваад оч. Багаад нь билүү байгаа байлгүй" гэв. Хүүхэд дурамжхан гарлаа.

Дэжид элдэв төмрийн өөдөс, сур хадаас сэлт бүхий багажны хайрцаг руу ширтэн гөлөрч "Миний санаж байгаа, энэ хүний байж байгаа... Өөрийн хийсэн өөрийн толгой дээр гэдэг үнэн юм даа. Дөнгөж тусдаа айл болчихоод гэрээсээ хувин сав, халбага сэрээгий нь хэлж нэг аваад хэлэхгүй нэг аваад байдаг сан. Тэгэхэд муу ижий минь над шиг л гол нь харлаж суусан даа. Дамба ч хүний хүн болжээ" гэж гунихран бодож суув. Тэгээд босъё, хүн амьтан ч ороод ирэх вий гээд өндийх гэсэн боловч хамаг бие нь сулран, үе мөчгүй юм шиг болж, босоод яах юм, юу ч хийх юм билээ гэж бодоход нь ямар ч хийх ажил байхгүй юм шиг санагдан нөгөө хэвээр суусаар. Аргагүйн эрхэнд хүүгээ орж ирэхээр мөнөөх дархны хайрцгийг орон доогуураа харжигнатал түлхээд өөрийн мэдрэлгүй юм шиг тэнтэр тунтар гишгэсээр гадаа гарав. Тэнгэр цэлмэг. Наран дөлгөөхнөөр гийгүүлэн хавь ойр орчин тойрон анир чимээгүйд дарагдан Дэжидийн жаргах зовохыг хэн ч анзаарахгүй, хэнд ч хамаагүй мэт санагдахад улам ч ганцаардан энэ бүхнээ хэн нэгэн хүнд ярих юмсан. Хэнд ярих билээ хэмээн бодоход багын найз Дуламаас өөр хүн санаанд нь эс оров. Гэтэл тэднийх бараг өдөржийн газар байдаг тул санах юм биш ажээ.

Дэжид гэрийн хаяанаас араг авч үүрснээ дахиад л хээр гарч усан нүдлэх гэж үү. Усан нүдэлснээрээ сайн болдог бол бишгүй л усан нүдэллээ шүү дээ. .. Тэгээд яах гэж? Солиотой юм шиг ганцаараа хээр тэнэх гэж үү? Энэ муу жаал минь яах юм? Хээр хөдөө уйлж эргүү юм шиг тэнээд байхаар чамаас эрүүл хүүхэд гарна гэж үү? Чиний хүсч мөрөөдөж явдгаар охин ч гарах юм билүү, яаж мэдэх вэ? Энэ тэр юмны наана цааны боддоггүй яачихсан ухаан муутай амьтан бэ. Ямар үхчихсэн биш. Хүүхдийн чинь эцэг амар мэнд л явж байна. Үхчихсэн бол чи яах юм гэж гэнэт бодон уужрах шиг болж гэртээ орон, хүлээн авагчаа залгалаа. Хаанахын ямар нэг хөг аяыг үл мэдэх нэгэн аялгуу уйтгартай ч юм шиг, аятайхан ч юм шиг намуухнаар эгшиглэн хэн нэгний харцаар аргадах аргадалт шиг ч санагдана. Ерөөс сүүлийн үед Дэжид гэртээ байвал хүлээн авагчаа үргэлж нээн сэтгэлд торох дуу хөгжим сонсогдвол анхааран чагнаж, мэддэг дуу, сонссон аялгуугаа дотроо даган нарийн нугалаа хөг аяы нь сэтгэлдээ тогтоон хоцрохыг хичээдэг болжээ. Дамба сумын төвөөс дайрвал дайрах хугацаа өнгөрсөн атал дайрсангүй. Дэжид ч одоо ирэхээсээ өнгөрлөө гэж мэдсэн хэр нь яаж мэдэх вэ гэж битүүхэн харуулдан үүр цүүрээр босч үс гэзгээ самнан гэр орноо цэвэрлэн идээ цагаа буцалган дахин хоёр гурав хоногийн нүүр үзэв. Дамба ирсэнгүй. Энэнд Дэжид гомдсон боловч урьдын адил даанч дээ хэмээн нулимс бөмбөрүүлэн суухыг больжээ.

Харин ингэж бэлдэн айлчин гийчин хүлээсэн мэт байсандаа айлынхаа хоёр хөгшнөөс зовон "Хотод суудаг эгч маань ирнэ гэж дуулдсан. Ажил явдал нь болсонгүй юм байхдаа хэд хоног харлаа, алга" гэж аргагүйн эрхэнд худлаа хэлэхэд Должин хөгшин "Тэгж байгаад ирэх байлгүй. Хавьд ойрд нутаг орондоо ирээгүй хүн чинь. Цай чинь дэвэрч байна уу. За тэр хэлээгүй юу. Тэр чинь ирэх л гээд байгаа нь тэр. Танай эгчийг тэр жил эхийн чинь ажил явдлаар ирэхэд танихгүй хөглөхөө шахсан шүү. Уг нь хар нялхаас нь мэдэх юм болохоор эрхбиш төс байналээ. Тэгэхдээ л мөн будилсан шүү. Хотод бол ч танихгүй нь билээ. Би ер хот

орохоороо хүн танихаа больчихдог юм. Цугаараа л адилхан дүрлийсан хар нүдтэй цагаан хүүхнүүд... Гар хуруу, уруул ам, яриа хөөрөө, үгүй чухам алхаа гишгээ нь хүртэл цөм адилхан. Яахаараа ч тийм адилхан болцгоочихдог юм, хэн мэдэх вэ. Үгүй тэдний тэр жижигхэн хөөрхөн хөлтэйгий нь яанаа" гэхчлэн ярьсанд Дэжидэд эгч минь хүрээд ирдэгсэн бол ямар сайн вэ. Нээрэн хүрээд ирэх юм биш байгаа даа гэсэн горьдох сэтгэл төрж ямар азаар хамаг юмаа цэвэрлэж амживаа хэмээн баярлажээ. Энэ ярианаас хойш төдий л удаагүй байтал нэгэн орой тэднийхний хот айлыг чиглэн баахан морьтон ирсэн нь Хашаатын хоолойд хадлан хадахаар яваа бригадын хадланчид байв. Ирэхэд нь гадаа угтан зогсож байсанд ч юм уу, өвгөн настай болохоор нь хүндэлсэн ч юм уу Багаа өвгөнийд орцгоов. Хүү нь хэн хэн ирээд юү хийж байгааг хэдийнээ гүйж орж мэдчихээд ээждээ ирж дуулгав. Тэд юугаараа эс ч нэг хэсэг нь тэдний орж ирнэ гэдгийг Дэжид мэдэж байсан хэр нь огт сандарч тэвдсэнгүй. Түүний бүх юм бэлэн. Ер энэ хэдэн хадланчид бүү хэл бригадаараа ороод гарсан ч аятай тавтай цайлаад гаргачих юм шиг бодон, цугаараа ороод гараасай ямар байгааг минь Дамбын чихэнд дуулгачих амьтан байгаасай гэж хүсэх тусам нь хясан тэгэхээс тэгэх гэж удаад байх шиг санагдав. Түүний хүссэнээр тэдэнтэй яваа сургаалийн хэдэн хүүхдээс бусад нь цөм орж ирэн үе тэнгийнхэн нь харцуул:

- За Дэжидийг хадланд аваад явна гэцгээхэд Дэжид,
- Уухай, тэгмээр байна уу гээд инээмсэглэв.
- Бригадын дарга ч бидний дуртай хүнээ дайрч аваад яваарай гэсэн шүү. - Дуртай хүн чинь би байгаа биз.
- Ийм хүүхнийг аваад мордоход дургүйцэх ч юү байхав дээ.
- Эзнээ голохгүй бол сайхан л дур санж. - Ха Ха Ха.
- Чи Дэжидийг үгээр л лав давахгүй юм байна. Май өгсөн архий нь давдаг юм уу үгүй юм уу. Түүрүүч нь сургаар нь шахуу айлд уначихаад байна. - Хэн тэр вэ?37
- Жигжид л байхгүй юү. - Ямар, манай муу Жигжид үү?
- Тэгэлгүй яахав, танай муу Жигжид.
- Та хоёр чинь нэг анги, энэ тэр гэдэг биз дээ.
- Хэлээд яахав.
- Яасан догшин эд вэ.
- Догшин байна уу, чихдүүлэх үү?
- Ха Ха Ха
- Бас байдаггүй ээ.

- Охь байна шүү таминь. Наад Дэжид чинь биднийг цугаарангий маань дөнгөх нь.

- Дөнгөдөгөө ч дөнгүүлчихлээ л дээ, дөрвөн хөлтэй гардаг юм уу, хоёр хөлтэй гардаг юм уу л гэхээс.

- Болохгүй бол хононо доо.

- Хойморт санаад хотын захад унтчихгүй бол тэгээрэй л дээ.

- Ха Ха Ха

- Бас байдаггүй ээ.

- За гайгүй ээ. Чи тэгж л бай.

- За таминь мордоцгооё. Одоо боллоо.

- Чамлах юү байх вэ. Наадахаа балгачихаад морд. Өдий олон харцуулд ганц данх юм юү болдог юм.

- Хараач таминь. Одоо биднийг хөөргөж алах нь. Мордоцгооё, мордоцгооё хэмээн шуугилдан гарч, төдөлгүй харанхуйн дунд дөрөө хангиналдан дүнгэр дангар ярилцсаар холдоцгооход мөнөөх эл хул анир чимээгүй эргэн ирсэн боловч ойрын үед ингэж олонтой шуугилдаж, үгээр мэтгэлцэж, инээж хөхрөөгүйгээ хөхөрч шуугилдсан болохоор сэтгэл санаа нь нэг л уужуу баяр хөгжилтэй болж эдэн шиг ингээд олуулаа инээж хөхөрч шуугилдаж явах юмсан гэж бодов.

Хүү нь ч гэсэн тэр ах тэгж инээж, энэ ах уухдаа ингэсэн тэгсэн хэмээн өөрийн харсан ажигласныг эхдээ ярьж хоёул шоолохы нь шоолон, элэглэхий нь элэглэн хөхрөлдөж юм хумаа цэгцлэн байтал гаднаас Жигжид орж ирэв. Унтсандаа нүд нь хавдаж, царай нь хөрзийжээ. Жигжид Дэжид хоёр сургуульд нэг ангид сурч байсан хоёр. Харин Жигжид Дэжидийг сургуулиас гарахад үлдэн долоогоо төгсөөд мал малласан ажээ. Жигжид цэргээс ирээд нутгийн нэг хүүхэнтэй суун дөрвөн хүүхэдтэй айл болжээ. Дэжид Жигжидийг Багаа хөгшнийд согтоод ойччихсон гэдгий нь сая санан тэндээсээ мордоод явчихалгүй орж ирсэнд нь баярлан архи дарс гарган дайлахад Жигжид дотор муу гээд архи уусангүй, бантан хийлгэв. Энэ зуур тэр хоёр гэр орон нутаг бэлчээр аахар шаахар юм ярьсаар Дамба Дэжид хоёрын явдлын тухай ярианд шилжин Дэжид яагаад ч юм Жигжидэд санасан бодсоноо ний нуугүй яримаар санагдан анх яаж дуулсан, яаж хөөсөн, яаж дархныхаа багаж хэрэгслийг аваад явчихсан зэргийг нэгд нэггүй тоочин хүүхэдтэй хоцорсоноо хүртэл ярьжээ. Жигжид ч Тогоохүүгийн тухай мэдэх бүхнээ ярьж шөнө хугаслаад Дэжид хүүхдээ авч өвөртлөн хүүгийнхээ орон дээр ор засч өглөө. Орондоо орцгоосон хойноо ч Дэжид Дамбын хэрхэн хүлээсэн, ирвэл юу хэлэх байснаа хүртэл ярьсан бөгөөд Дэжидийн хувьд шөнөжин яриад суучихсан ч чадмаар санагдсан болов ч Жигжидийн нойр нь хүрсэн юм уу, сүүлдээ хаа нэг ааг гэхээс өөр юм ярихгүй болсонд Дэжид дуугүй болов. Энэ ярианд Дэжидийн сэтгэл хөдөлж нойр нь хулжин эргэж хөрвөн сэрвэлзэн байснаа таг унтжээ. Нэг сэрвэл хажууд нь хүн хэвтчихсэн мөрнөөс нь татаад байгаа юм шиг санагдахад дотор нь зарсхийн цочин өндийвөл Жигжид хэдийн өвөрт нь орчихсон хажууд нь хэвтэж байлаа. Тэрхэн хооронд яах ч

учраа олоогүй Дэжид,

- Чи чинь одоо яаж байгаа юм, яв. Орон дээрээ очиж унт гэхэд Жигжид, - Чи бид хоёрыг хэн мэддэг юм дээ хэмээн хоолой чичигнүүлэн амьсгал давхцуулан шивнэв. Тэрхэн мөчид Дэжидийн толгой руу "Тэртэй тэргүй би Дамбад хэрэггүй юм чинь яасан ч яадаг юм. Одоо би хэнд гэж үнэнч явах юм бэ? Гэсэн бодол орж ирэхэд Жигжидийг түлхэж байсан гар нь өөрийн эрхгүй суларч, ийнхүү гар хөл нь сулрах тусам, Харин ч энэ явдал Дамбын чихэнд хүрээсэй. Намайг хүн тоож татдаг юм байна гэдгийг мэдэг, гэж бодсон хэр нь "чи чинь яаж байгаа юм бэ? яаж болдог юм бэ? Хэмээн уруул өмөлзүүлэн өгүүлсээр байлаа. Яачихаваа би чинь? Юу хийчихэвээ гэсэн гутралыг нь Жигжидийн хурхирах чимээ улам ч ихэсгэж улам ч ой гутам санагдсан Дэжид өндийн түүний мөрнөөс татан "Хөөш босооч" хэмээн дуудав. Жигжид сэрсэн боловч түүний үгийг огт тоосон шинжгүй буруу харан унтахаар завдахад нь Дэжидийн уур улам хүрч,

- Чи миний зовлонгоор тоглож ханаагүй юу гээд хар хүчээрээ түлхсэнд санаандгүй байсан Жигжид орны урд пидхийн ойчив. Дэжид ч ухасхийн босч дээлээ ханцуйлан лаагаа асаалаа. Жигжид босч гуйвсаар ор руугаа явав. Дэжид өч төчнөөн муу муухайгаар харааж, доромжилмоор санагдсан боловч уур гоморхолдоо багтран ганц ч үг хэлж чадсангүй. Жигжид орондоо орон цааш харан хэвтээд өгөв. Дэжид орон дээрээ суун чимээгүйхэн уйллаа. Нөхөр ханьгүйн зовлон ингээд л ирдэг юм байна. Хэрвээ Дамбыг байсан бол юу гэж ингэх вэ. Хэн зүрхлэх юм? Ийм явдал боллоо гэхэд маргааш нь уйлж унжиж байгаад л ярина шүү дээ. Маргааш би хэнд ярих юм? Хэн намайг өмөөрөх юм? Хэн? Өмөөрөх хүнгүй ч байлаа гэсэн хэн дуртай нь намайг эдэлж байх ёстой юм уу? Хэн дайралдсанд нь доромжлуулж явах юм гэж? Цаашдаа дандаа ингэж доромжлуулж байх уу? Доромжлуулчихаад зүгээр байх ёстой юм уу гэж бодохоос уур нь хүрэн шийдмэг гэгч босч Жигжидийн дэргэд очин хучлагы нь хуу татан:

- Яв чи. Зайл. Одоохон миний нүднээс далд ор. Чи юу гэж бодоов? Дуртай цагтаа ирээд ноолж байх хүнтэй боллоо гэж бодож байна уу. Тэгэх байлгүй. Хагсаж үхсэн ч чамтай унтахгүй мэдэв үү. Яасан бузар амьтан бэ гэж уурлах, уйлах хослон хашгичин Жигжид хар цагаан дуугүй хувцас хунараа хам хум өмсөөд гарч одов. Дэжид уурлан уйлж загнасанд дотор нь овоо онгойжээ. Хүү нь тайвнаар хөнжлөө тийччихсэн унтана. Жигжид төдөлгүй мордон аажуухан алхуулсаар чимээ тасрав. Дэжидэд гэнэт мөнөөх арав гаруй хоногийн өмнө орхигдсон бодол нь эргэн орж ирэв. "Заавал явна. Ингэж согтуу хөлчүү амьтанд дарлуулж байсанд орвол эзгүй говьд хэд хоног ч атугай санаа амар явж байсан минь дээр" гэж боджээ.

Дөнгөж нүүлгэж буулгачихаад мордсонд нь Дэжид дурамжхан хоцров гэдгийг Дамба мэдсэн боловч явахаас өөр арга түүнд байсангүй. Удахгүй нүүнэ гэж Тогоохүүд хэлсэн нь бодогдон хонуут өнжүүд алга болчихтой зэрэг ер юу бодож байгаа бол, Дэжид рүүгээ эргэчихсэн юм болов уу гэж санаа нь зовж байгаа байх даа гэж бодохоос улам ч яарчээ. Нөгөө гэвэл нүүхийн урьд шөнийн явдлаас болоод тэр үү, Дэжидийг харахаас өрөвдөх сэтгэл төрөн, ийм амьтны чинь орхичихоод цаашдаа яаж амьдар гэх юм, надаас өөр хэн энэнд хань болох юм. Юу ч болдог болсон дэргэд нь явж байгаад насыг барья, энэний л сэтгэл түвшин явбал би яах вэ гэсэн бодол төрөн, энэхүү бодлоо эрэгцүүлэн бодохоор удах тусмаа энэ бодол нь тамиржин, энэн дээр Дэжид уйлаад гуйчих юм бол үнэхээр тийм явдалд хүргэчих юм шиг санагдсанд

гэнэт энэ бодлоосоо айх, элдвийн өрөвчхөн сэтгэл төрөхөөс өмнө явчихья гэж боджээ. Дамбыг мордоход Дэжид юу ч хэлсэнгүй. Дамба ч нүүр өөд нь зүрхлэн хэрж чадсангүй. Хүү нь гэрийн хаяа налан хойноос нь харсаар хоцорчээ. Энэ удаа түрүүчийн богц тохоод мордож байснаас нь илүү хэцүү байлаа. Одоо л эхнэр хүүхдээ бүлтэгнүүлэн орхиж байгаа юм шиг бодогдон үг ч хэлээгүй, нулимс ч унагаахгүй хэрнээ хүү эхнэр хоёр нь дээл хувцасных нь хормой, мориных нь дэл сүүлнээс чаргууцалдан зууралдаж эргээд очдог ч юм билүү гэхээр Тогоохүү араар нь сундлан, нүцгэн гараараа морий нь гуядан буй мэт санагдахад хагацах нь ч зовлон, учрах нь ч зовлон аль аль нь шаналал мэт бодогдон баахан гэлдэрчээ. Түүнийг очиход Тогоохүү санаанд оромгүй баярлан угтсанд ирэхгүй тэндээ үлдчихсэн бол энэ бүсгүй яаж зовж, шаналж, тарчлах байсан бол гэж бодохоос Тогоохүүгийн зовлонгийн дэргэд Дэжидийнх юу ч биш юм шиг Дамбад санагджээ. Тэр шөнө Тогоохүү "Чи лав үнэмшихгүй байх. Би чамайг ямар их санасан гээ. Ганцхан хоноход ингэтлээ санах гэж баймгүй юм даа гэж бодсон хэр нь болоогүй. Санан гэдэг олон цөөн хонохоос шалтгаалдаггүй байхаа. Өглөө сэрчихээд л өнөө шөнө дахиад ирэхгүй бол яана даа гэж бодохоос цай ч уух дургүй хүрч байсан. Хэрвээ чамайг өнөө шөнө ирээгүй бол би яах байсан болоо, аягүй бол ичихгүй хүрээд очих байсан болов уу. Намайг нэг л хачин байсан болохоор тэгсэн үү, ээж ч гэсэн зөөлөрч гарч ороод л намайг ийм тийм юм хий ч гэхгүй байсан" гэхчлэн эзгүйд нь юу бодсон санаснаа ярьсан хэр нь урьд шөнө Дэжидтэй унтсан уу, хүүгээ өвөртөлж унтсан уу гэдгийг асуух гэснээ Дэжидтэй унтсан гэвэл яанагэхээс асууж зүрхлэхгүй байгаа нь түүний нүд, уруул, хөдлөх хөдөлгөөнд нь ил байсанд Дамба хаа унтсан, юу болсон, ямаршүү юм бодож яарснаа бүгдийг нэгд нэггүй ярьжээ. Дамба үүнийг зөвхөн Тогоохүүгийн сэтгэлийг засах гэсэндээ ярьсангүй. Ер нь л ярмаар санагдсандаа ярьсан бөгөөд ярьсан хойноо өөрөө ч гайхахад хүрэв. Урьд өмнө нь энэ мэт аар саар явдлыг ярих нь бүү хэл юу бодож санаж явдгаа ч Дэжидэд ярьж яваагүй, Дэжид ч түүнд энэ мэтийг ярьдаггүй байсан юм уу, эсвэл ярьсан ч анзаардаггүй байсан юм уу санаанд нь үлдсэн юм үгүй байв. Ер нь Дамба санасан бодсоноо хүнд ингэтлээ дэлгэж явсан нь ховор. Харин Тогоохүүд л хамаг юмаа ярихсан, энэ тэрийг зөвлөхсөн гэж боддог болжээ. Зөвлөхөөс ч аргагүй үе гардаг байлаа.

Урьд нь нүүх суух, арилжаа наймаа алив бүхнийг толгой мэдэн шийдэж явахдаа энэ юу гэх бол, тэр юу гэх бол гэж нэгээхэн ч бодож явсангүй. Гэтэл одоо юухныг ч ганцаар шийдэхээсээ эргэлзэн ингэчихээр хоёр хөгшний сэтгэл санаанд таардаг болов уу, үгүй болов уу. Тогоохүү юу гэх бол гэсэн бодол төрөн яахав, ийхэв хэмээн Дэлэг өвгөнөөс асуух боловч цаадах нь Дамбын ажил хөдөлмөрт няхуур сүрхийг нь анзаарч "Харин яамаар юм дээ" гэж өөдөөс нь асууна. Ийм үед Дамба Тогоохүүтэй зөвлөө асууя гэлтэй ч биш бодсоноороо шийдэн ингэж шийдсэнийхээ дараа энэ маань зөв болов уу, буруу болов уу гэхээсээ тэдний сэтгэлд нийцээ болов уу яагаа бол гэж зовнин, энэ бүх өөрийнхөө төлөө бус ямагт бусдын төлөө, бусдад хийж байгаа ажил мэт сэтгэлээс нь нэг л хөндий санагдан, аливт хүний ам харж явах амаргүй юм даа ч гэж заримдаа бодох авч тэр өөрсдөө шийдчихэж чадахгүйдээ ч бус Дамбад өөриймсөг хандаж байгаадаа, Дамбыг хүндэтгэсэндээ тэгж байна гэдгийг ухаарч түүний нь ухаарах тусмаа буруу зөрүү шийдчихгүй юмсан гэж мэрийн, сэтгэлд нь юм хийчихгүй юмсан гэж боддог байлаа. Энэ бодлоосоо үүдэн тэдний сэтгэлд нийцсэн эсэхий нь мэдэх гэж Тогоохүүгээс битүүхэн тамдах, энэ тэр мэдэхгүйгээ асуух, яах вэ, ийх вэ гэж болжээ. Тогоохүү ч Дамбын энэ байдалд дуртайгаар үл барам ялангуяа Дэжидийн тухай бодсон санаснаа ний нуугүй ярьсанд нь баярлан өөрөө ч тэр тухай юу бодож санаж явдгаа ярихсан хэлэхсэн гэх авч тэр тухай Дамба хөндөж ярьдаггүй байсан болохоор хий л дотроо

бодож явдаг байсан нь эл яриагаар задарч "Чамайг би давхиж очоод аваад ирээгүй ч гэсэн яагаад ч юм Дэжидийн өмнө би буруутай юм шиг санадаг. Эхний үед Дэжид гэнэт давхиад ирвэл яана гэж бодохоос хүний юм хулгайлчихсан хүн шиг айдас хүрэн тэр зүгээс морьтой хүний бараа харагдахтай зэрэг дотор зарсхийгээд явчихдаг байсан. Хүн ер нь айснаас л элдвийн муу юм боддог байх. Чамайг ч гэсэн буцаад явчих вий гэж айдаг. Буцаад явчихвал хойноос нь очоод эргүүлээд аваад ирэх эрх байхгүй шүү дээ гэж бодохоос миний гол харладаг юм. Тэр мэрнээсээ ч болдог юм уу, би чамайг малд явуулах ч дургүй. Эзгүй хээр ганцаар яваа хүн юу эс бодох вэ, элдэв юм санаанд нь орохыг хэн байг гэх вэ гэж бодогдоод хамт байгаад байвал сэтгэл амар санагддаг. Царай зүсээ харалцаад суугаа юм чинь яалаа гэж элдвийн юм бодох вэ. Би л чадахгүй. Хүний дэргэд байж байгаад тэр хүний тухай ч юм уу, аль эсвэл ямар нэгэн юм бодоод түүнээ хэлэхгүй байя гэхэд болохгүй. Тэр хүн царайг минь хараад л юу бодож байгааг минь мэдчих юм шиг санагддаг. Дамаан чамаас бол би бодлоо нууж чаддаггүй юм байна лээ. Чи дорхноо л мэдчих шиг болдог. Заримдаа би тэднийгээ эргэчихээд ир гэж хэлье гэж санасан хэр нь ирэхгүй болчих юм биш байгаа гэж бодогдоод хэлж зүрхэлдэггүй юм. Буруу гэж мэдсээр хэрнээ би чамайг очоод байгаасай гэж боддоггүй ээ. Яагаад ч юм би Дэжидийг надаас бүхий л талаараа илүү байх гэж санадаг. Тийм болохоороо л айдаг байх" гээд гэнэт дуугүй болон Дамбыг мэлийтэл ширтдэг байв. - Яав гэж Дамбыг асуухаар Тогоохүү:

- Их ярих дэмий байна. Би дэндүү чалчаа, тийм биз? - Зүгээр.

- Үгүй зүгээр биш. Сүүлдээ ярих юмгүй болчихвол яана.

- Ярих юмгүй болох гэж яаж байх вэ дээ.

- Гэлээ ч гэсэн бага ярих нь л дээр. Тогоруу хоорондоо бараг дуугардаггүй. Тийм болоод л насаараа хамт явдаг байх.

- Ярьдаг байлгүй. Нэг нь зогсчихсон, нөгөө нь тойроод л тонголзоод л далавчаа дэрвэлзүүлээд л чухам юу гэгч болж байгаа юм бэ, бүү мэд, жигтэйхэн л юм болдог шүү дээ. Тэгэхдээ бидэнд дуулдахааргүй шивнэлддэг ч юм билүү, хүн ямар ойртуулах биш. Тэгээд ч ярьснаас биш ярьдаггүйгээс, ярихаа больчихсоноос л хамаг хэрэг үүддэг байх шүү.

- Би ч ярихгүй байж чадахгүй л дээ. Гэхдээ би заримдаа тэгж боддог юм. - Ярьсан нь л дээр.

- Чамд сонирхолгүй санагдвал яах вэ? - Өөр юм ярь гэхгүй юу.

- Яриад ч залхуутай байвал яах вэ?

- Дуугүй бай гэхгүй юу.

- Чи тэгж хэлэх үү?

- Хэлнэ.

- Хэлээрэй, за юу?

- За.

- Ер нь миний хийсэн хэлсэн ямар нэгэн юм сэтгэлд чинь хүрэхгүй бол чи заавал хэлж байгаарай.

- За.

- Би ч бас чамд хэлж байна гээд Тогоохүү түр азнаснаа,

- Би чамаас нэг юм асуух уу гэв. Дамба түүн рүү харснаа,

- Тэг, тэг гэв. Тогоохүү түүний харцнаас дальдран түүний цээжинд нүүрээ наан: - Больё, яах юм, тэртэй тэргүй мэдэх юм чинь гээд дуугүй болов. Дамба юү вэ, хэл барь ч гэж шавдуулсангүй. Толгойг нь энхрийгээр илнэ. Энэ нь чи Дэжидэд хайртай байсан уу гэнэн асуулт болохыг Дамба Тогоохүүг <Дэжид!> гээд дуудчихсан юм байжээ. Энэ асуултанд өөрөө ч юү гэж хариулахаа үл мэднэ. Цэргээс дөнгөж халагдаж ирээд байхад нь Дамбад нутгийн бүсгүйчүүлийн дотроос Дэжид сайхан харагдаагүй гэж үү. Үеийнхээ залуусыг <Хорлоо чамд их л сайн юм билээ.Хороотой суучихаач Сайхан хүүхэн шүү дээ.> гэхий нь ч тоолгүй Дэжид рүү тэмүүлсээр байгаад суучихаагүй гэж үү. Эцэг эхээс орон гэр, мал хөрөнгө тусгаарлан хийх бүтээх, санах хүсэх, баярлах цэнгэх цөм өөрсдийн дур хүслээр болж ирсэн айл гэрийн анхны амьдрал жаргалтай байгаагүй гэж үү. Цаанаа хүлээсэн хүнтэй юм биш байгаа. Намайг тоохгүй юм биш байгаа гэж түүнийг түгшүүлж явсан хэнз ногоо шиг нялх залуу байсан бүсгүй Дэжид биш гэж үү хэмээн бодоход "хайргүй байсан" гэж Дамба хэлж чадахгүй санагдана. Гэтэл одоо яагаад... энэ болов? Тэр анхны хайр хайчив? Ерөөс хайр сэтгэл гэгч он цагтай цуг оддог юмсанж уу. Сэтгэл хувирна гэгч нь энэ үү? Дэжид анх учирч, Дэжидийг хайрлаж байсан тэр хайр энэ мөн гэж үү? Гэж бодохоор яагаад өөр тус тусдаа онд ондоо санагдана вэ гэдэгтээ ч хариу бас үл олох тул энэ мэт юм битгий асуугаасай гэж бодов.

Үнэн чанартаа энэ асуултын цаана Тогоохүүгийн асуухсан гэж бодож явдаг "Надад хайртай юү" гэсэн асуулт байгаа гэдгийг Дамба гадарлаж байлаа. Гэвч Тогоохүү асуусангүй. Шинэ нутагт буумагц Дэлэг өвгөн илүү гэрийнхээ юмыг гадаа хураан дотор нь хоёр хөгшин ор дэвсгэр, авдар сав, зуух яндан тавин нэг ёсондоо хоёр хөгшин, Дамба Тогоохүү хоёроос туурга тусгаарлажээ. Энэ нь Дамба Тогоохүү хоёрт юүхнийг ч орондоо орцгоосон хойноо шивнэлдэх гэхгүй, хэзээ дуртай цагтаа ярьж хөөрч инээж хөхрөхөд таатай болсон боловч Тогоохүү мөнөөхөө дахин асуусан ч үгүй өнгөрчээ. Нүүдлээр тархи толгойноосоо хурц наранд шарагдаад ч тэр үү Бумбаа хөгшний хууч хөдлөн хэвтсэн тул Дамба эм авахаар сум нэгдлийн төв орохдоо Багаа өвгөнтэй дайралдан тэндээс хүүдээ тонгорог худалдан авч өгчилгөөд яаран эргэж ирвэл гурав хоногийн дараа хадланд яв гэсэн зар бригадын төвөөс ирсэн байлаа. Хуучин бригадаасаа Тогоохүүгийн бригадад шилжээгүй тул явахаас өөр аргагүй болж хоол унд, хадуур хуурай бэлтгэхээс эхлээд ойр зуурын ажил дороосоо ундран, чөдөр ногт зангидан суух зав гарсангүйд хэрэггүй л дархныхаа багажийг авчирлаа. Ядаж хэлээгүй аваад ирсэн хэмээн сэтгэл зовних боловч яах ч арга Дамбад олдсонгүй. Зүй нь өглөө давхиж оччихоод учир явдлаа ярин сэтгэлийнх нь сэвийг арилгачихаад орой давхиад ирж болмоор бодогдовч дөнгөж саяхан эргэж ирчихээд бас дахиад явна гэхээр Тогоохүүгийн сэтгэлд юм хийчих болов уу гэж бодно. Тэгээд ч олон хоногоор эзгүй явах гэж байгаа болохоор Тогоохүү аль болохоор хамт байхсан гээд байгаагаас гадна хадланд явах хүмүүсийн нэрс дотор Хорлоогийн нэр

байгаа явдал битүүхэн хардах сэтгэх Тогоохүүд төрж байна гэдгийг Дамба мэджээ. Уг нь Хорлоо Дамбыг хүлээгээд хүнтэй суудаггүй юм гэнэлээ гэсэн дэл сул яриа тарчихсанаас биш Дамба Хорлоотой сэтгэл ярьж явсан нь үгүй ажээ. Энийг л Дамба Тогоохүүд ярьсан байжээ. Хорлоо Дамбад сайн гэдэг нь үнэн билээ. Бүр дунд сургуульд байхаасаа Дамбад сайн байсан бөгөөд цэрэгт байхад нь эгэл жирийн хэрнээ хүсэн хүлээдгээ битүүхэн цухалзуулсан захиа бичдэг байжээ. Дамба хоёр гурван захиа авсны эцэст ажил сурлага, нутгийн цэргүүд хэн хаана байгаа зэргийг товч тоочсон хариу өгдөг байлаа. Хорлоо түүний байдлыг мэддэг хэр нь сэтгэлээ татаж авч чадсангүй. Цэргээс ирсэн хойно ч гэсэн түүнийг битүүхэн харуулдан, уулзаж учрахыг эрэлхийлэх болсон учир Дамба түүнээс битүүхэн зугтаан дайралдахгүйг хичээн, заримдаа ч надад найдаж хүлээж суухын хэрэггүй гэдгээ ний нуугүй хэлмээр санагдавч Хорлоогийн хайр гуйсан харц, бусадтай зүгээр ярьж хөөрч байснаа Дамбатай уулзахаараа царай нь час улайн үгээ олж хэлж чадахгүй ээрэн арчаагүй бүрэг дорой болчихдогийг нь бодохоос өрөвдөн нүүр өөд нь эгцлэн харахаас ч халширдаг байжээ. Тэгээд ч удалгүй Дэжидтэй суун, энэ бүхнийг мартагнасан хэр нь одоо хүртэл хүнтэй суугаагүй яваагийг нь дуулах бүр буруутан нь өөрөө юм шиг санагдан зовсон цагт нь тус болж явах юмсан даа хөөрхий гэж бодох боловч түүний тусыг Хорлоо ч бусад хүмүүс ч буруугаар ухаж мэдэх тул яаж ч чадахгүй гагцхүү хол явахыг эрмэлздэг байв. Дамбын энэ байдлыг мэдэх зарим залуус "Дүүрчихсэн эр юм даа, хэд хоног ашиглаж байгаад хаячихгүй" гэдэг байлаа. Ийм үг сонсохоороо Дамба дотроо Хорлоог өмөөрч, тэдэнд ундууцан цухалдахдаа "тэгээд байвал бүр суучихалтай нь билээ" гэж хүртэл бодох боловч яагаад ч суухгүй гэдгээ мэдрэн тэрхүү бодлынхоо ямар өнгөц, хуурамч болохыг зөвхөн тэр шалдир балдир залуусын үгийн өшөө төдий бодол болохыг ухаарна. Заримдаа ч Хорлоод уур нь хүрдэг байлаа. Ялангуяа Дэжид рүү тэмүүлж явах үедээ Хорлоогийн тухай элдэв юм дуулчих вий гэж бодохоос сэтгэл түгшин, Дэжидийн найз хүүхэн Дулам дайралдан "Хорлоо Дэжид хоёрыг мөргөлдүүлчихэв дээ" гэж их л ёозгүй хэлэхэд нь иш үндэсгүйг ярьж буй тэр хүүхэнд бус "Би Дамбатай явдаг" энэ тэр гэж амьтанд зарлаад явдаг юм уу хаашаа юм гэж Хорлоод уур нь хүрч давхиж очоод уур омго дарагдтал хэрэлдмээр бодогдож байжээ. Харин Дэжид Хорлоогийн явдлын үнэн мөнийг ойлгосон ч юм уу, тоосонгүй ч юм уу тэр тухай юу ч болсонгүй өнгөрсөнд Дамба ч төдөлгүй Хорлоог мартжээ. Тэр цагаас хойш Дамба Хорлоогийн өөртөө сайныг мартсан мэт дайралдсан үедээ мэнд ус мэдэн, хэнтэй ч ярьдаг хөөрдгөөрөө хэд гурван үг солин, Хорлоогийн харц, үг яриаг ч анзаарахаа больсоор өдийг хүрсэн бөгөөд энэ удаа Тогоохүү эртний явдлын үүх түүхийг мэддэг хүний өнгөөр Хорлоогийн нэр байна лээ гээд түүн хүү жоготой харсан нь энэ бүгдийг Дамбад эргэн санахад хүргэж тэр бүгдийг Тогоохүүд ярья гэж бодсон боловч ярих далим гарсангүй байсаар Дамба хадланд морджээ.

"Нөгөөдөр бид хоёр хонио туугаад говь явна. Тэнгэр тогтуун байвал хэд хонохыг бодно. Та хоёр үнээ малаа саагаад зав зай гарвал ганц хоёр шуудай таана түүнэ биз" гэсэн Дэжидийн шийдэмгий үгийг дуулаад Багаа өвгөн жаахан дуугүй сууснаа "Малаа бодвол буруу нь юү байхав. Болохгүй нь ч юү байхав. Гэлээ гэхэд ... үгүй тэгээд санаанд чинь багтаж байгаагаас хойш бид хоёр юү хэлэхэв. Ойр зуур болох бүтэхээр нь таана хөмүүл гоочлон, өвөлжөө бууцаа додомдосхийгээд л байж байхаас. Юмыг яаж мэдэхэв, хэрэг болж юуны магад, миний муу халийбрийг аваад яваарай" гэснээс ондоо юм хэлсэнгүй. Тэгээд явах өдөр нь эртлэн босч юм хумнаас нь төхөөрөлцөн тэмээгийг нь хомнолцож тогоо шанага, майхан сэлтийг нь ачилцаж өгөхөөр хөгшинтэйгээ хоёул иржээ. Айлын хоёр хөгшний энэ байдалд Дэжид нэг талаараа баярлан нөгөө талаар авч явах юман дотор нь боодолтой яваа хүрэл гөрөөсийг анзаарчих вий

гэхээс яс нь хавгалзан хурдхан ачаалаад хөдлөхийн түүс болсон боловч тэд огт анзаарсангүй хоцорчээ. Оторт гарсан эхний хоёр өдөр Дэжидийн сэтгэл ойрын мөд байгаагүй гоц гойд шинэ сэргэг баясал дүүрэн байлаа. Хэн хүний шийдсэнийг бус хэрхэх, яахаа өөрөө шийдсэний урам, санасан бодсон нь хэний ч дургүйцэлтэй тулгаралгүй хүссэнчлэн бүтсэний баяр, цаашид ч энэ хот айлын ажил үйлс гагцхүү түүний хүсэл зоригийн хэрэг бөгөөд Дэжидийн ярьсан, хэлснээс зөрөх хүн үгүйг мэдрэн ахин дахин захирахын хүслэн, амьдралын учир утга бүхний гогцоог атгачихсан мэт санагдахын омог энэ бүхэн түүний сэтгэлийг урьд урьдынхаас өөр, илүү баян тансаг болгон, улмаар энэ хязгаар хярхаггүй хөх тэнгэр, эл хул их говь сая живаа хорхой шавьжны дэргэд өдрийн од шиг цөөхөн хүмүүс хичнээн насална гэж бие биедээ хар буруу санаж, бие биеэ муучилж явах юм даа гэж бодон "Өөрт нь жаргалтай л бол болоо" хэмээн Дамбыг цагаатгаж, "хөөрхийг харанхуй шөнө харааж зүхэн юунд ч хөөв дөө" хэмээн Жигжидийг өршөөх сэтгэл төрөн энэхүү сэтгэлээс нь бас өөр сэтгэл ундрэн, өдий наслахдаа ер хэнийг гомдоож л явснаас ач болсон нь үгүй мэт санагдана. Ялангуяа Нацаг гэгч хазгар залууг хүүхэд ахуй цагтаа насан турш нь мартахааргүй гомдоосон мэт санагдан, тэр цагийн явдлыг өчигдрийнх лугаа ижил тов тод санав. Тэгэхэд тэд зургадугаар ангийн сурагчид байжээ. Нацаг Дэжидийн зэргэлдээ ангид сурдаг, завсарлагаа бүхнээр хаа нэг газраас ширтэж байдаг, түүний нь ч үеийнх нь охид анзаарчихсан, холбож шоолдог, тэрэнд нь ангийнхаа тоонд сайн юм уу, биеийн тамирт тэргүүн хөвгүүдтэй нэр холбогдохсон гэж хүсч явдаг Дэжид дургүйцэн Нацагийг үзэн ядаж ичиж зугатаадаг байжээ.

Нэг өдөр Дэжидийг ганцаараа явж байтал гэнэт урдаас нь замы нь отон зогсож байсан Нацаг гарч ирсэнд Дэжид давхийн цочиж, тэр уурандаа ч тэрүү Нацагийн өгсөн бичгийг авч ураад нүүр өөд нь цацчихаад гүйгээд явчихжээ. Түүнээс хойш Нацаг ч Дэжидийг энд тэнд амдах, завсарлагаа бүхнээр ширтэх нь үгүй болж, голцуу хаа нэг мухрын цонхон дээр цааш харан зогсох юм уу, Дэжидийн явдаг замаас холуур улам ч хазгар болчихсон юм шиг хазганан яваа нь харагддаг байлаа. Дэжид ч өөрийн хийснийг зөвтгэйд тооцон Нацагтай холбож шоологдох ичгэвтэр юмнаас ангижирсандаа санаа нь амран төдөлгүй Нацаг хаагуур юу хийж явдаг, сүүлдээ юу болсныг мэдсэнгүй. Нэг үгээр хэлэхэд Дэжид орчлон дээр тийм хүн байгаа эсэхийг ч мартжээ. Гэтэл гэв гэнэт эзгүй говьд өөдөөс нь дөрөв нугалсан бичиг сарвайж байгаа Нацаг, нүдний нь өмнө цас шиг бутарч байгаа цаасны өөдсүүд түүнийг дагуулан ширтсээр хэрхэн газар унахы нь харан зогсох Нацагийн харц санаанд нь урган, цас малгайлан хаялах бүрт анхны хайрын зурвасаа уруулсан тэр өдөр нь гашуунаар дурсагддаг байх даа гэж бодохоос хүний үрийг хэрхэн гомдоосондоо одоо мэдрэн, эхнэр хүүхэдгүй явдаг бол гуйж байгаад ч болсон хань ижил нь болж хазгар доголлонгий нь марттал жаргаах юмсан гэж бодсоноо түүнээсээ даамжран тэгвэл хүн юу гэх бол, мэдээжийн хэрэг Нацагийг өрөвдөөд суучихаж гэхгүй "Шалдаа бууж л гэнэ". Үгүй яадаг юм тэгэх тусам нь суучихаад хоорондоо атаархмаар сайн байх юмсан. Тэгвэл Дамба яах бол гэсэн бодолдоо хариу үл олох бөгөөд цаашдаа хэн нэгэн хүнтэй сууж, түүнээ Дамбаас илүү сайн болчих тийм цаг ирвэл яана гэж бодохоос айх ч шиг ичих ч шиг санагдан бушуухан өөр зүйл бодохыг тэр дундаа Дамбын тухай аль болохоор бодохгүйг хичээн, хүнд хэлэх нь бүү хэл, өөрөө ч ичихээр хүсэгдэж байгаа нууц хүсэл энхрийллээ дарж ядахдаа гэдсэндээ тээж яваа хүүхдээ хурдхан гараасай, цээжээ тэнийтэл үнсэж энхрийлэх юмсан. "Одоо ч бид хоёр нэг охинтой бол болоо" гэж нэгэн цагт хэлж байсан Дамбын үгний хариу болж охин төрөөсэй. Тэгээд бас хясаатай юм шиг Тогоохүүгээс хүүхэд гарахгүй байгаад байгаасай. Тэгвэл Дамба яах бол" гэж дахиад л бодно. Ер нь Дамбын тухай аливаа бодол яван явсаар "Дамба одоо Тогоохүүг тэврээд хэвтэж байгаа

шүү дээ" гэдэгт хүрч гол нь харлан хоолой нь зангирдаг байлаа. Харин бараг бүх эрчүүл хадланд явж байгаа болохоор Дамба ч мөн зайлшгүй хадланд яваад эзгүй байгаа гэдэгт санаа нь амарсан юм уу, эсвэл ерөөс сүүлийн энэ өдрүүдэд түүний сэтгэл санаа өөрчлөгдөөд тэр үү. Дамбаас салаад өч төчнөөн жил болчихсон юм шиг Дамбад гомдож байсан гомдол уур, цөм үгүй болж, болбол яаж ийгээд тус болж явах юмсан, хүүгий нь үе үе уулзуулж байх юмсан гэж бодох болж, "Энэ гөрөөсийг би яахин авчирав аа. Эзгүй хойгуур ирээд авбал авна л биз", Дамба мэдчихвэл муухай л юм болж байгаа юм гэхчлэн уужуу саруул юм бодогдоно. Хүү нь ч гэсэн эхний хоёр өдөр, гүйж харайж, инээж хөхөрч энэ тэр амьтан ургамал сонирхон, шүд амаа хөхөрч харлаглаа хармаг идэн маргааш л отроос буцчих гэж байгаа юм шиг хоёулаа олон хононо шүү хэмээнэ. Сүүлийн үед дуу нь цөөрч, энэ тэр юм гөлрөн, олигтой тоглож наадах ч үгүй болжсав л хийвэл тоглоом наадам, гүрвүүл хөөцөлдөн, бүрэнхий болмогц хоол ч идэлгүй унтчихдаг болжээ. Энэ байдал Дэжидийн сэтгэлийг улам ч амар тайван болгож, алсын уул дэргэдэх бут сондуул, өвс ногоо, алаг эрээн чулууг харахад танигдашгүй нууцыг хадгалан анир чимээгүй хөдөлгөөнгүй байх авч дуугүй ширтээд байхаар тэрхүү нууцанд нь нэвтэрч, ухаарч байх мэт хачин сэтгэл төрөх бөгөөд чухам юу билээ хэмээхэд эргээд хэлж чадамгүй байх ажээ.

Ерөөс оторт гарсан тэр өдөр Дэжид урьд өмнө үзээгүй, дуулаагүй нэгэн шинэ ертөнцийн хаалгаар орсон мэт харагдах сонсогдох юмны өнгө дуу ч өөр, бодогдох санагдах юмны учир шалтаг ч өөр, давагдашгүй бэрх, тайлагдашгүй нууц гэж үгүй бөгөөд харин энэхүү өөр ертөнцийн хаалга зөвхөн түүнд ганцааранд нь нээгдсэн мэт санагдан, юм бүхэн сонин, сайхан гайхамшигтай мэт байснаа төдөлгүй тэрхүү ертөнц нь гачлантай эл хул тэвчиж үл барам уйтгартай болж ирэв. Гурав, дөрөв дэх хоногоос хүү нь ч гэсэн энэ тэрнийг сонирхохоо болино, үүргэлж морин дээрээсээ уначих гэж айлгах юм уу эсвэл ам цангалаа гэдэс өлслөө гэж буюу заримдаа харъя ээжээ, аягүй бол аав ирчихээд хүлээгээд байгаа гэдэг болов. Өөрөө ч хэрэггүй наашаа гарлаа, элдэв амьтны хэрэгт дурлах дэл сул эрчүүлийн гоочлох гэх энэнээс л дор байв гэж бодох авч Багаа өвгөнтэй зөрөн, зөрөн отор хийнэ энэ тэр гэж явчихаад арав хонолгүй ямар нүүрээрээ буцах билээ хэмээн буцашгүй юманд орсондоо өөрийгөө зэмлэн, юутай ч арав хоноё энэ хооронд тэнгэр муухайрдаг аз байдаг юм уу, үгүй юм уу гэж үйл ч үгүй, салхи ч үгүй, өнгө ч үгүй тэнгэрийг ширтэн, дургүй цагтаа дусал ч хургүй энэ хов хоосон тэнгэрийн эрхшээл дор яах гэж яваа билээ хэмээхүй бодол нь мухардан эргэн тойрны анир чимээгүй, хөдөлгөөнгүй, нозоорсон халуунд амьд яваагаа ч мартахад хүрэх аж. Хүлээн авагчийн зай ч дорхноо муудан, дуулдахын төдий шивнэж байснаа таг болоход өдөр хоног ч хөдөлгөөнгүй болсон мэт бөгөөд ер нь энэ ертөнцөд юу хөдөлж юу урагш давшиж буйг Дэжид мэдэхийг больжээ.

Дөрөв дэх хоногийн өглөө эрт хонио бэлчээчихээд ачаалах гэтэл хүү нь нойрмоглоод боссонгүйд Дэжид ганцаараа майхнаа буулган ачих гэж оролдсон боловч тэмээ нь босч давхиад ачуулахгүй болохоор тэмээгээ сөглөж байлгах санаатай хүүгээ дахин дахин дуудсаар арай гэж сэрээсэн хэр нь хүү нь өндийж суучихаад хөдөлсөнгүй. Дэжид "Яав миний хүү, бие нь өвдсөн үү" гэхэд хүү дуугарсангүй.

- Миний хүүгийн гэдэс нь өвдөөд байна уу?

- Толгой нь өвдөөд байна уу...

- Яасан? Аа? За ээждээ хэлчих. Ээж хүү хоёр оройтчихвол дараачийн худаг хүрч малаа усалж чадахгүй шүү дээ. Тэнгэр ч бүрхэг байна. - Харина. Аавдаа очно.

- Харинаа, харина. Ингэж явж байгаад одоо зургаахан хоночихоод л хоёулаа харьчихна. Одоо аав чинь байх ч үгүй, хадланд явчихсан.

- Худлаа. Аав хадланд яваагүй.

- Явсан. Харин чи бид хоёрыг очсоны маргааш л хүрээд ирэх бий вий. Одоо хоёулаа эртхэн хөдөлбө. Майхан тогоо шанагаа ачна. Худаг дээрээс онгоц ховоогоо авчирна. Ээж хүү хоёрт их ажил бий, ингэж сууж болохгүй за? За бос. - Үгүй би харина. Аавдаа очно.

- Аав чинь байхгүй, хадланд явчихсан гээд байхад чинь зөрүүдлээд суугаад байх юм, тэгж байж чи алганы амт үзэвээ.

- Үгүй худлаа. Шал худлаа. Та дандаа худлаа хэлдэг. Би явахгүй. Би аавдаа очно. Гэхэд нь Дэжидийн уур гэнэт дүрхийн,

- Тэг тэг. Одоо ингээд гүйгээд яв. Чиний тэр хаяад явсан эцэг чинь авдаг юм бол хамаа байсан уу. Би яахав тэртэй тэргүй ганцаараа хүн. Тэгж яваад л үхнэ биз гэж хэлээд Дэжид хүүгийн дэргэдээс босч хомтой тэмээ рүүгээ очин, бурантагнаас нь амьсгаа чөлөөгүй дугтчин байж хэвтүүлээд урьд хоёр хөлий нь богочин шилээр даруулан хүлчихээд ачаагаа ачиж эхлэв.

Хүү тэр суусан янзаараа хааяа нүднийхээ булангаар эх рүүгээ харан хэсэг сууснаа эхийгээ онгоцоо ачихаар тэмээгээ хөтлөн худаг руу явахад сая босч хойноос нь очин, онгоцны нэг талаас өргөлцөв. Дэжид ч нүүр өгөхгүй гэсэн бололтой түүнийг онгоц өргөлцөж дэм болж байна ч гэж тоосон янзгүй байлаа. Ачаалж дуусмагц хүү хоёр морь руугаа гүйн очиж эхийнхээ морийг хөтөлж авчирч өгөөд, өөрөө мориндоо мордон бараа нь тасрах шахсан хонь руугаа давхижээ. Энэ өдөр Цэдэн Иш хүү энэ тэр рүү гүйж харайн, алив ажил бүхнээ Дэжидийг хэлэхээс өмнө санаагаараа хийн гэмшсэн янзтай ч юм шиг үе үе эх рүүгээ хялавхийн харах авч Дэжид түүний нь хараа ч үгүй юм уу анзаараагүй байдал гаргана. Тэнгэр бүрхэн, бороо ч орох янзтай болсонд Дэжид эртхэн бууж майхнаа шааж, төвхнөхийг бодов. Тэднийг буувуу үгүй юу салхи шороо босч бороо шивэрч эхэллээ. Хоёул салхи бороон дундуур майхнаа босгон, морь малаа чөдөрлөн хонио хотлуулчихаад Дэжид гал түлж тогоон дээрээ цай үйв. Өдрийнхөө явдалд ядарч галын илчинд дулаацсандаа хүү нь унтаад өгчээ. Дэжид цайгаа хам хум болгож уудлаад ороо засан хүүгээ унтуулж, хажуугаар нь бүхлээрээ хэвтэв.

Бороо шижигнэн салхи майхны бааданг хөвхөлзүүлэн нүүрэн дээр нь үе үе усан манан сэрүү татуулан буух авч Дэжид түүнийг огт үл анзааран гагцхүү энэ бороо нозоорол, ганцаардал бүхнээс нь ангижруулж буйг ямар нэгэн далд баярын зөн сэтгэлд нь татан буйг амтархан мэдэрч хэвтэхдээ уурын мунхагт хэлэх хэлэхгүй үг хүүдээ хэлж сэтгэлий нь сэвтээчихлээ гэж өөрийгөө зэмлэн, чухамхүү яаж гэмээ цагаатгаж, хүүгийнхээ сэтгэлийг засдаг юм билээ хэмээн бодоход түүнд хүүгээ аваачаад ч болсон Дамбатай уулзуулахаас өөр арга үгүй мэт санагдана. Үнэхээр тэгээд очдог юм гэхэд юугаа өмсөж яаж уулзах хэрхэн угтах нь одоо үл тааварлагдах авч юутай ч амар хялбар бардам сайхан зүйл биш нь мэдээж бөгөөд адгийн наад

зах нь гэдсэн дэх хүүхдээ хэрхэн нуух билээ гэдэгтэй хүртэл тулгарах ажээ. Гэвч яагаад ч юм Дэжидэд энэ бүхнийг хэрхэн давах билээ хэмээн айх түгших юм огт үл бодогдоно. Сүүлийн үед айдас гэгч Дэжидээс холдсон мэт бөгөөд Дэжид Дамба хоёрын тухай жиг жуг яриа, тэр ч бүү хэл хөл хүндтэйгээсээ ч айх ичих нь үгүй болсон мэт ажээ. Хэрэв энэ бүхэн үнэхээр айх түгших зүйл биш бол орчлонд айх юм давшгүй хэцүү бэрх гэгч Дэжидэд үгүй болж үхэл гэгч ч аймшигтай биш санагдан, ер яагаад ингэдэг билээ хэмээн гайхан, энэ бүхэн цаг зуурын бодол бизээ гэж бодоход хүргэнэ. Дэжид ийнхүү хэвтсээр хэдий хэр болсноо ч мэдсэнгүй хонь ямаа майлалдах чимээнээр гүйн гарвал харанхуй болж бороо улам ширүүсч байлаа. Хонь нь уруудан майхнаас холдох янзтай харагдсан буцаж орон дээлэн дээгүүрээ цув давхарлаж өмсөөд шилбүүр барин хониныхоо урд гарч тогтоох гэсэн боловч ширүүн бороонд цохигдсон олон хонь хоёр талаар нь дайрч арай гэж нэг талы нь тогтооход нөгөө тал нь тэр хооронд уруудан түрүүчийн газраасаа цаашлачихаад ганц Дэжидэд огт хүчрэгдэхгүй алхам алхамаар майхнаасаа холдож эхлэхэд ганцаархнаа унтаад хоцорсон хүүгээ сэрчихээд айж уйлж байгаа болов уу гэж бодохоос майхан руугаа хурдхан очмоор санагдах авч эргэх дөрвөн цагт хойноос нь дагаж үс зүс, удам судраар нь таних, ижил дасал болсон нэгдэл нийгмийн энэ олон малыг зоргонд нь хаячих зүрх түүнд байсангүй. Дэмий л үе үе майхан руу харан харан холдсоор удалгүй майхан нь ч харагдахгүй болов. Одоо түүний сэтгэл шулуудан үхсэн ч сэхсэн ч хониноосоо салалгүй явж, хаа хүрч юу болохыг үзэх л үлджээ. Ер яах гэж наашаа гараваа? Эз нь татна гэгч болж дээ. Эсвэл би ерөөс энэ эзгүй говьд үхэх үйлтэй амьтан юм уу. Үхнэ гэдэг тохиолдлоос л хойш тэр тохиолдол нь энэ байхыг хэн байг гэх юм? Намайг ингээд үхчихлээ гэхэд хэнч мэдэхгүй шүү дээ, мэдлээ гээд яах юм, их л удаж Дамба ирж... Даанч дээ. Дамба минь би чамд ямар гэм хийгээв? Яалаа гэж намайг ийм зовлонд унагаж байгаа юм. Чамайг сэтгэлээ хувиргаагүй бол Жигжид мэт нь намайг оролдож зүрхлэнэ гэж үү... Энэ эзгүй говьд энэ усан бороон дунд үр хүүхдээ ганцааранг нь хаячихаад хаана, яаж үхэхээ мэдэхгүй явах гэж үү... Муу жаал маань юу болж байгаа бол... Айж үнхэлцэг нь хагарчих гэж байгаа болов уу ... Яах гэж наашаа гарав...

Бороо гэнэт ширүүн эхэлсэн шигээ мөн гэнэтхэн зогсов. Дэжид хониндоо туугдах шахуу явснаа бодвол хонио тогтоон, хаа ирснээ багцаалах санаатай ийш тийш хичнээн хараад газрын баримжаа мэдэж чадсангүй. Бороо зогсчихоор улам ч харанхуй болсон мэт санагдана. Одоо яах вэ. Хонио майхан руугаа туухуу? Хаа гэж туух вэ. Тэгээд ч энэ нүх шиг харанхуйд хонь явна гэж үү... Хонио орхичхоод майхан руугаа явах уу... Хаа гэж явах вэ? Энэ бороо дахиад орохыг хэн байг гэхэв. Аягүй бол хонь ч үгүй майхан ч үгүй юм болно. Хоньтойгоо хоноод л өглөө учраа хайя хэмээн бодож хонио шаагьтал нь хурааж хэвтүүлээд өөрөө хонин дундаа ороод суув. Олон малын илч даарах ч үгүй хажуудаа мал байгаа болохоор ханисан айх үгүй янзтай болж ирэхэд дотор нь ч одоо уужирч хэн хүнд гомдох, майханд хоцорсон хүүгийнхээ хойноос сэтгэл түгших нь гайгүй болов. Богинохон зуурын энэ ширүүн бороонд хонио тасдаад алдчихалгүй бүрэн бүтэн гарсандаа ч тэр үү, сандарч тэвдэх бүхэн ард хоцорсон болоод ч тэрүү, нэг их үйлс бүтээчихсэн мэт урам орж бороо дахиад орсон ч ер алзахгүй санагдана. Урьд өмнө хийх нь бүү хэл хийвэл би давах болов уу, үгүй болов уу ч гэж санаж яваагүйгээ хийхээр үл барам нэг их зүдрэлгүй, хамаг хүчээ шавхчихалгүй бүтээн, цаанаа бас бие сэтгэлийн тэнхээ хуримтлагдан хоцорч байгаагаа мэдрэн, одоо ер нь хүнтэй сууж хүүхдүүддээ хойт эцгийн царай харуулаад ч яах юм, нэгэнт л хэний ч царай харалгүй айл гэрээ аваад яваад байж чадахаас хойш. Харин тээж яваа хүүхдээ гаргах үеэр л хүн бүлгүй хэд хоног бажгадах болов уу. Түүнээс цааш ер юу л байв гэж. Эрүүл саруул л явбал болоо гэж

бодон, иймэрхүү юм бодож байгаадаа өөрийгөө гайхах ч шиг, урьд өмнө нь бодогдож санагдаж байгаагүй энэ шинэ бодол нь түүнийг улам ухаан суулгаж байгаа ч юм шиг санагдуулна. Амьдрал яг хуучнаараа байсан бол хүний нөмөр нөөлгөнд хий гэснийг хийчихээд л өөрөө бие даан хийж чадах эсэхээ ч мэдэлгүй тэжээвэр хурга адил хүний гар харсаар насыг барах байсан байх даа. Гэтэл хэний ч дор орохгүй хэнийг ч царайчлахгүй амьдрах тэнхээ надад өөрт минь байжээ гэсэн омог бардам бодол бас төрнө. Зөвхөн маргааш юу хийх яахаа бус, отрын дараа юу хийх яахаа хүртэл тодорхой мэдэж байх шиг бодогдоно. Юуны өмнө хүүгээ эцэгтэй нь уулзуулчихаад сум нэгдлийн төв орж гурван хавтастай толь авна. Ямар дээл өмсч явдаг юм билээ гэж бодоход түүнд өөрийнх нь хуучин дээлний өнгө хийц гологдоод өөр аятайхан дээл хийж өмсөхсөн гэж бодсоор хэсэг зуур зүүрмэглээд сэрвэл үүр цайж байв. Дэжид босч газрын баримжааг харан майхнаасаа нэлээд холдсоноо мэдэж хонио босгон туусаар майхныхаа ойролцоо очиж хонио орхиод хүрч очвол хүү нь сэрээ ч үгүй тайван унтаж байлаа.

Дэжид цайгаа чаначихаад хүүгээ дуудан шөнө юү болсон яасан ийснээ ярин хоёул цайгаа ууцгаав. Борооны дараах өглөөний чийг ханхалсан цэнгэг агаар, газар дэлхийн өнгө зассан байдалд сэтгэл нь сэргэн буцах эргэх тухай хүү нь дурсахгүй байсанд Дэжид иймэрхүү байвал ганц хоёр ч болсон хоног энэ хавьдаа байя хэмээн дотроо шийдэж байтал хүү нь "морьтой хүн айсуй" хэмээн хар гүйхээрээ орж ирж эхдээ хэлчихээд гүйн гарав. Дэжид ч хойноос нь гарч харвал гэрийнх нь байгаа зүгээс бараан морьтой хүн айсуй харагдлаа. Хүү тэр зүг нүд салгалгүй хэсэг харж байснаа "Аав байна, аав ирж явна" гэж хоолой зангируулан хашгираад тэрхүү морьтонг тосон гүйв. Нээрэн ч мөн юм шиг Дэжидэд санагдан хүний хань гэдэг үү... бороо шороонд зутарч яваа байх, хүг минь ч санаж сүйд болж байгаа байх даа гээд ирж байна шүү дээ. Хэр ч байгаа даа. Сэтгэл нь эргэчихсэн ч гэсэн элэг нь хайчихав гэж бодон баярлах ч шиг яах гэж наашаа гарсан юм гэж загнах болов уу гэж айх шиг, юунаас ч юм Жигжидийн явдлыг дуулчихсан болов уу ч гэж ичих шиг болон майхандаа буцаж орон ор дэрээ янзлан, дэвсгэрээ гүвж хойроо дэвсээд буцаж гарвал айлынх нь Багаа өвгөн ирж явах бөгөөд хэн болохыг нь таниад урамгүйхэн зогсох хүүгээ өрөвдсөндөө хоосон горьдож урам хугарсандаа Дэжид золтой л уйлчихсангүй. Багаа өвгөн дөхөн ирж буун харайгаад :

- Үгүй та хоёр минь энэ бороо, шороонд тохитой юу. Яасан ч сүрхий ширүүн бороо вэ. Зарим улс ч хонь малаа тасдаад алдчихсан, эрж сураад л давхилдаж байх шиг байна.

- Бид хоёр ч урьд шөнө нойргүй л хонолоо. Гэгээ тусав уу үгүй юү наашаа гарч байгаа нь энэ. Хонь мал бүрэн үү? Сүрхий хоёр юмаа та хоёр. Хн. Одоо яах вэ, буцах уу, эсвэл бид хоёр хүрээд ирэх үү, бид ч тэнд байж чадашгүй хүү минь гэхчлэн үгийн солиогүй дээр дээрээс нь угсруулан ярихад хүү - ямар гоё вэ? Буцья, буцья" хэмээн баярлан дэвхрэв. Дэжид хүүгээ харж инээмсэглэсэнээ "Буцья даа, буцья" гэлээ.

Хадланчид ч гэсэн борооний маргааш гэр малаа эргэнэ гэгцгээн тал тал тийшээ одоцгоосонд Дамба шууд давхиад харьчихдаг юм билүү, яадаг юм билээ хэмээн эргэлзэн байснаа юутай ч Тогоохүүтэй уулзаж учир явдлаа ярья гэж шийдэн хүрч ирсэн боловч Тогоохүүгийн баярласан сэтгэлийг хараад яаж ч чадсангүй. Өөрөө ч Тогоохүүтэй нүүр учрахаараа бодсон шийдсэнээ няцаахад хүрдгээ бас мэдэрчээ. Ер яах ч учраа олохгүй дэмий л дотроо шаналж байлаа. Түүнийг хадлангаас юү бодож ирсэн, юү хэлэх гээд хэл нь эвлэж өгөхгүй байгааг Тогоохүү огт

үл анзаарах бөгөөд гагцхүү энэ хооронд юу юу болсон, юу бодсоноо ярих гэж яарна. Тэр хоёр унтатлаа ярьсан хэр нь Тогоохүү "Харанхуй болохоор би чамаас нэг юм асууна" гэснээрээ орондоо орсон хойно түүнийг хүүхэд мэт хүзүүдэн байж "Чи ямар хүүхэд гараасай гэж боддог вэ" хэмээн шивнээд Дамбыг учиргүй үнссэнээ "Чи яав? яагаад дуугүй байна вэ?" гэв.

Дамба юу хэлэх, яахаа ч мэдэхгүй таг дуугүй мэлрэх тэрхэн зуураа орчлон яасан хяслантай вэ хэмээн өөртөө шүүрс алдан шууд давхиад харьчихья гэсэндээ л явчихдаг байж гэж харамсан бодов. Үнэндээ гэхэд хадлан дээр өнгөрүүлсэн тэр хэд хоног шиг сэтгэлий нь тарчлаасан өдөр хоногийг Дамба урьд өмнө үзсэнгүй. Тиймэрхүү юмтай учирна гэдгээ ч төсөөлсөнгүй. Түүнийг бодох төсөөлөх зав зайг Тогоохүүгийн хайр энхрийлэл өгөөгүй байжээ. Ирэх замдаа гэрээр нь орсон хадланчдын егөө, наргиан, битүү үгс, миний явдал та нарт ямар хамаатай юм гэх бодлыг Дамбад төрүүлсэнгүй. Харин ч зовох, шаналахынх нь үндэс болжээ. Ялангуяа Жигжидийн хэлсэн үг Хандын ярьсан хоёр түүнийг улам ч зовоов. Яагаад Жигжид Дэжидийг ингэтлээ муулах болов. Яагаад Ханд Дэжидтэйгэйгээ эргэж суу гэж ятгана вэ. Яахаараа түүний хувийн амьдрал, бригадын даргад хамаатай байна вэ гэсэн бодол шаналгаж, Жигжид мэтийн дэл сул амьтан Дэжидийн гоочлуулж яваагийн хамаг буруутан өөрөө гэдгийг ухаарч, Дэжидийг магтах Хандын үгийн үнэнийг мэдрэх тусам Дэжидтэй эргэж суухаас өөр замгүй санагдан хадлангаас шууд харьчихдаг ч юм уу гэж бодон байсан нь тэр байжээ. Гэтэл Тогоохүүгийн энэ асуулт түүнийг яаж ч боломгүй зовлонд өнөөдөр эс ч хэзээ нэг цагт унагах юм шиг санагджээ. "Чи дургүй байгаа юм уу? чи бид хоёр үр хүүхэдтэй болох дэмий гэж үү" гэсэн дараачийн асуулт түүнийг "Яалаа гэж. Үр хүүхэдтэй болох шиг сайхан юм хаа байх вэ" гэдэг үгийг арай чамай хэлүүлэв. Энэ үгэнд нь Тогоохүү цаанаа үр хүүхэдтэй болохоороо огт тоохгүй байна хэмээн гомдож учиргүй уйлсанд Дамба "Хүүхдээр яах юм энэ тэр гэж би хэлээгүй шүү дээ. Чи юундаа уйлж унжаад байгаа юм. Угийн үг яриа удаантайгий минь эс мэдэх биш" гэхэд Тогоохүү "Нээрэн ч тийм юм болов уу" хэмээн дорхноо тайтгарч "Чи хүү гараасай гэж боддог уу, охин гараасай гэж боддог уу" гэсэнд Дамба "Охин" гэв. Энэ нь Тогоохүүд хүүтэй болохоороо л тэр гэсэн бодол төрж "Чамд ч тийм нь тийм л байх. Би бол чамтай адилхан хүү гаргах юмсан л гэж боддог" гээд санаа алдсанд үгийнх нь өнгийг мэдэрсэн Дамба дахиад эвгүй үг хэлчихсэнээ булах санаатай "Би бол чамайг дуурайсан охин гараасай л гэж боддог юм. Дараа дараачих нь л хүү байна биз" гэсэнд Тогоохүүгийн сэтгэл сэргэн "Тийм олон гараасай гэж чи боддог уу?" "Тэгэлгүй яахав", "Нээрэн үү, нээрэн, нээрэн". "Цөөхүүлээ өссөн болоод ч тэр үү би өнөр өтгөн олуулаа явах сан гэж боддог" "Хэрвээ би хүүхэд олохгүй бол чи яах вэ?" "Яадаг юм, олохгүй бол олохгүй л байна биз", "Гэхдээ л мэдээж чи жаргаж чадахгүй шүү дээ" гэхчлэн үүр цайтал ярьцгаажээ. Маргааш нь тэр хоёр энэ тухай ярьсан ч үгүй. Энэ ярианаас болж сэтгэл эвдэрсэн ч байдал үгүй, хэн хэн нь сэтгэл өег, амгалан жаргалтай байцгаалаа. Дамба ч нөгөө хоёроо эргэх барих талаар үг цухуйлгасангүй. Тэгтэл нөгөөдөр нь тэднийхнийг чиглэн хоёр морьтон ирсэн нь Дэжид, Цэдэн- Иш хоёр байлаа. Хоймроо нөмгөн суун бороонд норж, сунасан чөдрийн хөх янзалж байсан Дамба тэр хоёрыг ирлээ гэх чимээнээр өөрөө хүрээд ирэх зориг зүрх Дэжидэд бий билүү, үгүй билүү, худлаа байлгүй гэж тээнэгэлзэн, гарч харснаа үнэхээр ирж яваагийн нь хараад яаран орж ирж юм хумаа хумин "Яах гэж яваа бол? Юу гэх бол?" гэхээс айх ч шиг санагдан, Тогоохүү рүү харвал мөн яах ч учраа олж ядан зогсож байлаа. Ирж буй хүн хэн болохыг хэдийнээ мэдсэн Бумбаа "Чи бид хоёр ч иймэрхүү л ажил хийж явна даа" гэж ширэв татаад гэртээ оржээ. Тогоохүү Дэжидийг угтахаар гарч төдөлгүй гадаа мэнд ус мэдэлцэх дуулдсанаа баадантай юмбарьсан Дэжид, араас нь хүү нь орж ирэв. Дамба яах учраа олохгүй

зогсож байтал Дэжид гэрийн зүүн тал руу гарч цомбойн суугаад: - Бороо шороонд тохитой л байцгаана уу хэмээн санаанд оромгүй тайвнаар өгүүлсэнд Дамба сая суун:

- Тохитой, тохитой. Та нар тохитой юу хэмээснээ хүү рүүгээ гар сунган:

- Алив миний хүү наар ир гэв. Цэдэн Иш гэрэвшсэн янзтай Дэжид рүү наалдан суусаар байсанд Дэжид:

- Хүүе, аавдаа үнсүүлээч гэлээ. Хүү дурамжхан босч очиж үнсүүлсэн болоод буцаж ирж эхдээ наалдан суулаа. Энэ завсар Тогоохүү цай аягалж идээ будаа тавин, Дэжидийг битүүхэн ажиглаж байлаа. Дэжид аягатай цайгаа оочлох зуураа: - Танай энэд чинь бага ороо юү дээ гэхэд Дамба:

- Энэ хавиар зах нь шүргэсэн юм шиг байна лээ. Би ч хадлан бордоо гэж яваад өчигдөр л ирлээ.

- Аман усанд хадаж байгаа гэл үү. Хэр юм? - Унац муутай л юм, гээд яахав дээ.

- Бид хоёр бас хонио авч говь руу хэд хоног отор хийгээд өчигдөр л ирлээ. Энэ хүүхэд наашаа явах гээд санаад ч байгаа юм шиг болохоор нь өнөөдөр дагуулаад гараад ирж байгаа юм.

- Отор оо? Хоёулхнаа юу?

- Тэгэлгүй яахав. Өөр хэнтэй явах вэ дээ. - Нөгөө хоёр хөгшин яасан?

- Үхэр малаа хараад үлдэхгүй юу гэснээ Дэжид хоол хийхээр борц гарган түмпэн сав угааж байгаа Тогоохүү рүү хандан:

- Бид хоёрт хоол хош хийх гэж байгаа бол хэрэггүй шүү. Бид хоёр бас гэдэргээ яарч яваа хоёроо гэхэд Тогоохүү сая зориглон ам нээж:

- Хийлгүй яахав. Яаж хоосон гардаг юм.

- Зүгээр зүгээр. Энэ хүүхдийг л эцгийнх нь барааг харуулчихья. Та нартай би ч нэг уулзья гэж яваа юм гээд түр азнахад Тогоохүүгийн ч, Дамбын ч дотор палхийн одоо юү гэх бол хэмээцгээн царайд нь түгшүүр илэрцгээсэн боловч Дэжид огт үл анзааран мөнөөх тайван хэрсүү хэвээр үгээ цааш залган:

- Нэгэнт бидний явдал ийм болсон хойно, бид нэг нэгнийдээ орж гарч, мэндтэй устай, тустай дэмтэй явцгаах нь дээр гэхэд сая сэтгэл уужирсан Дамба:

- Тэгэлгүй яахав, тэгэлгүй яахав. Маргааш нөгөөдрөөс та нарыг эргэе барья л гэж байтал харин хүрээд ирцгээлээ гэхэд Дэжид, Дамбын энэ үгийг сонсоогүй мэт өөрийн үгийг үргэлжлүүлэн:

- Айл гэр болж яваа улс та нарт юүхэн ч хэрэг болох л байлгүй, Хэрэгтэйгээ хэлээд аваарай. Анхнаасаа би өгнө ч гэж хэлсэн шүү дээ гээд барьж орж ирсэн баадантай юмаа задлан

дотроос нь цутгамал хүрэл гөрөөс гарган:

- Дамбын өвөг эцгээс үе дамжин ирсэн эд юм гэнэ лээ. Энийг би танайд байх учиртай юм гэж зориуд авчирч өгч байгаа юм гээд хойморынх нь авдар дээр аваачиж тавиад баадангаа эвхэн өвөртлөөд:

- За явах уу, миний хүү гэсэнд хүү гагцхүү тэр үгийг хүлээж байсан мэт ухасхийн босов. Тогоохүү:

- Хүүе алив чихэр гээд авдарнаасаа ууттай чихэр гарган Цэдэн Ишид өгөн: - Ирж байгаарай гээд инээмсэглэв.

Хүү Тогоохүүгийн өгсөн чихрийг хам хум өвөртлөөд гарахаар завдан буй эхийнхээ араас ум хумгүй яаран гарчээ. Дэжид хүүгийн хамт тэндээс мордон гэрийн зүг явахдаа хийе гэснээ хийчихлээ гэж баярласан ч үгүй. Сэтгэл санаа нь уйтгар гунигтай биш ч хэрнээ хов хоосон ч юм шиг санагдав. Хүү нь өврөө ухан нэгэн цаастай чихэр гарган харснаа буцааж хийн дахин өврөө уудлан өөр нэгэн чихэр гаргаж эх рүүгээ сарвайн: - Ээж ийм чихэр идэх үү гэв. Дэжид - Үгүй миний хүү өөрөө ид. - Үгүй надад бий ээжээ.

- За сүүлд больё доо гэхэд Цэдэн Иш мөнөөх чихрээ задлан амандаа хийснээ, - Эднийх манай гөрөөсийг тэр том толиныхоо өмнө тавих болов уу яах бол? - Мэдэхгүй л дээ хүү минь яах юм бол доо.

1982 он

СЭТГЭЛИЙН ТЭНХЭЭ

Хамгийн түрүүнд түүнд амьд гарчээ гэсэн бодол орж ирлээ. Гэвч хөдөлсөнгүй. Амьд байгаагаа бие цогцсоороо бүрэн гүйцэд мэдэртлээ хэдэн агшин болов. Дараа нь ямар нэгэн сэржигнэх бүдэг бадаг чимээ сонсогдон, улмаар нүүрс шороо үнэртэж эхлэхэд амьд гэсэн мөнөөх бодол цусаар нь гүйж бүх биеий нь тойроод эргэж ирсэн мэт дахин бодогдов. Эргэлзээгүй ажээ. Нүдээ нээв. Таг харанхуй. Хэрэв тэр нэгэн бүдэг бадаг чимээ сонсогдоогүй, тоос шороо үнэртээгүй сэн бол амьд байгаадаа эргэлзэхээр харанхуй ажээ. Нүдээ хичнээн ч чавчлан харсан таг харанхуй хэвээр бөгөөд гагцхүү мөнөөх сэржигнэх чимээ л сонсогдоно. Ямар нэгэн ан цаваар өөрийнх нь дээрээс гоожиж байгаа шорооны чимээ болохыг танимагцаа өндийх гээд чадсангүй. Бүх бие нь баглаатай мэт ажээ. Нуранганд дарагдчихжээ гэсэн бодол төрөн биеэ зайчуулан хөдлөх гэсэн боловч чадсангүй. Нэгэн бодлын ямар нэгэн том юмны дор дарагдчихсан ч юм шиг, нэгэн бодлын ам хамар, гэдэс дотор толгой тархин дотор нь хүртэл шороо чихээтэй бөгөөд түүнээ дааж босч чадахгүй байгаа мэт санагдана. Гагцхүү түрүүлгээ харан нүүрээрээ газар шаан хэвтэж байгаагаа л мэдэж байлаа. Толгойгоо л юуны өмнө ил гаргах хэрэгтэй гэж бодон хүчлэн өдийлгөтөл толгой нь ил гарах шиг болсон боловч шавар шороо юм уу ямар нэгэн хүнд том юм толгой дээрээс нь дараад байгаа мэт санагдахаар нь толгойгоо сэгсэрч үзээд сая өнөөх хүнд том юм нь шавар шороо ч биш өөрийнх нь өмссөн дуулга болохыг мэдэн нэг хэсэг ухаан алдсан байна. Одоо ч гэсэн ухаан санаа бүрэн гүйцэд ороогүй там тум, бүүр түүрхэн байгаа юм байна гэдгээ ухаарчээ. Нүүрээ нойтон газар наан түр хэвтсэнээ дахин толгойгоо өндийлгөв.

Өмссөн дуулгаа гэж мэдсэн болоод ч тэр үү толгой нь түрүүчийнхээсээ арай хөнгөн болчихсон юм шиг санагдав. Ухаан санаа нь тодрон гар, хөлөө хаа ямар шуу байгааг сая л мэдэв. Толгой цээж нь ил бөгөөд зөвхөн бүсэлхийнээс дооших бие нь дарагджээ. Цээжээ өндийлгөн хоёр гар дээрээ тохойлдон хэвтээд урдах газраа тэмтрэн үзвэл хурууны нь үзүүрт дэл сул нүүрс, бэхэлгээний багананаас өөр юу ч дайралдсангүй. Бодоход түүний толгойн тус тэрхэн хэсэг газар хөндий хоосон зай байгаа аж. Нэгэнт цээж сул чөлөөтэй тул хоёр гараараа газар тулаад зүтгэхэд тал биеэ нуранган дороос сугалж аван тэрхэн хэсэг хөндий зайд орчиход дээрээс гоожих шороо чулуунд дарагдах аюулгүй болох юм гэдгийг мэдрэн урагш зүтгэсэн боловч бөгсөн биеэ өчүүхэн ч хөдөлгөж чадсангүй. Бэхэлгээний багананаас татаад зүтгэхээр гараа явуулсанд гарынх нь зөвхөн хурууны үзүүр л багананд хүрч байлаа. Ядаж гэрэлтэй сэн болоосой хэмээн бодож хагарсан юм уу, аль эсвэл мултарч унасан хоёрын аль нэг нь болсон гэдгийг мэдсээр хэрнээ дуулганыхаа гэрлийг тэмтрэн үзэв. Хагарчээ. Амьсгаагаа даран түр амсхийвэл мөнөөх гоожиж байгаа шорооны чимээ дахин сонсогдож эхэллээ.

Энэ чимээ түүнд биеэ хурдан сугалж авахгүй бол цаашлах тусам шороо ихсэн гарахын аргагүй гав болон улмаар бүхий биеийг нь хучин авна гэдгийг дохиолж байлаа. Үүнийг тэр сонсохоор ч үл барам арьс махаараа мэдэрч байлаа. Ямар нэгэн зөөлөн хөлтэй амьтан ар нуруугий нь даган цээжэнд нь зугуухан мөлхөж байх шиг санагдана. Тэр өндийн дахиад л хамаг хүчээ шавхан хоёр гараараа газар самардан, гарынх нь хурууны үзүүр хүрч, хурууных нь өндгөнд модны гөлгөр зөөлөн гадарга мэдэгдээд байгаа мөнөөх багана руу сарвалзан зүтгэв. Энэ багананд гар нь барьцтайхан хүрдэгсэн бол биеэ нуранган дороос сугалаад авчихаж чадмаар санагдана. Эцсийн эцэст гарах ганцхан зам энэ аж. Гэтэл яаж ч сарвайн зүтгээд

зүтгээд баганаас барьж авч чадсангүй. Хүний бие ганцхан төө сунагдсан бол түүний гар багананд барьцтай хүрэх байлаа. Гараа дэрлэн түр амсхийв. Гоожиж байгаа шорооны чимээ бүдэг бадаг сонсогдсоор л байлаа.

Даралт зайлдгаа зайлчихсан баймаар юм. Их нурж том нүх гарсан болоод шороо нь гоожоод тогтохгүй байгаа юм байх даа гэсэн бодол нь анх яалаа юү боллоо, яагаад би энэ тас харанхуй нуранганд дараастай хэвтэж байдаг билээ гэдгээ эргэж санахад хүрэн гэнэт өөрийн эрхгүй, "Түвшин, Намхай" гэж уулгалан дуудлаа. Хариу дуулдсангүй. Түүний дотор зарсхийн нуруу руу нь хүйт даан, үхчихсэн юм биш байгаа гэсэн бодлоо хөөж ядан Түвшин, Намхай гэж хоолой зангируулан бахиртал хаа нэгтэйгээс "Би энд байна. наашаа. Наашаа таминь" гэх дуу ойрхон хэрнээ бөглүү далд сонсогдов. Түүний дууны өнгө баясангүй болон "Чи хэн бэ" гэвэл Намхай байна. Намхай байна. Наашаа таминь. Наашаа таминь гэж тасалданга зовиуртай дуугарав. Аврахынхныг гэж саначихлаа гэж тэр бодон "Тэсч үз. Намхай минь" гэснээ "Түвшин хаа байна?" гэж нэмэн асуулаа. "Би Намхай байнаа. Наашаа... Наашаа..." гэж үглэхийг үзвэл ухаан санаа нь бүрэн гүйцэд биш бололтой.. Тэр дуугүй болов. "Түвшин үхчихэж" гэсэн бодол зурсхийн орж ирж сэтгэлийг нь харамслаар дүүргэн нүдэнд нь нулимс цийлэгнэн ирэв. "Миний буруу. Яагаад би нурах нь гэдгийг хэдэн мөчийн өмнө анзаарсангүй вэ. Овсгоотойхон хөдөлсөн бол аварчих байсан шүү дээ" хэмээн өөрийгөө зэмлэн мөнөөх дээрээс гоожих шорооны чимээг ч мартан байтал "Мастер аа. Дэмбэрэл гуай" гэх дуудав. "Өө Намхай намайг дуугаар минь таньсан юм байна шүү дээ. Аврахынхан гэж андуураагүй байх нь" гэж Дэмбэрэл бодоод "Аан" гэж чимээ өгвөл "Мастераа, мастераа" гэх нь Намхайн дуу арай ч биш шиг, арай ч ондоо газраас дуулдах шиг санагдсанд Дэмбэрэл,

- Чи хэн бэ? Түвшин үү? Хэмээн сандран асуув.

- Намхай, Намхай байна гэх Намхайн дуутай давхардан :

- Тийм ээ гэх Түвшингийн дуу дуулдлаа.

- Аа ашгүй гэж.

- Юү гэнээ мастераа? Би энд байна шүү дарагдчихаад байна? Юү гэнээ мастераа?

- Чи тэгээд түрүүн дуудаад байхад яагаад дуугараагүй юм. Би дуугарсан шүү дээ.

- Та хоёрын яриад байгааг мэдээд байгаа хэрнээ дуугарч болохгүй байсан юм. Одоо ч хэл ам нэг л хачин...

- Та нар буруу яваад байнаа. Дуу чинь ойртохгүй байна гэх нь Намхайн дуу мөн бөгөөд одоо хүртэл ухаан санаа нь бүрэн гүйцэд ороогүй юм уу аль эсвэл тэр хоёрын дууг аврахынхан гэж андуураад байгаа юм уу гэдгийг Дэмбэрэл ялгаж чадахгүй байлаа. Түвшин? Гэж Дэмбэрэл дуудлаа. Аа? Юү?

- Түвшин чи дуугүй байгаарай. Би Намхайтай яриатхъя.

- За.

Юү ч дуулдахгүй....

- Намхай ? Юү?

- Би Дэмбэрэл байнаа. Түвшин чи бид гурав нуралтанд дарагдчихжээ. Ойлгож байна уу чи?

- Мэдэж л байна. Тэгээд аврахынхан чинь хаа байгаа юм?

- Ирнээ. Чи яаж байна?

- Хөл дарагдчихсаан.

- Агаар ямар байна?

- Агаар ч яахав.

- Бухимдаад яахав дээ.

Намхай дуугарсангүй. Дэмбэрэл хариу хүлээн түр азнаснаа:

- Түвшин?

- Аа?

- Чи яаж байна?

- Зүгээр?

- Яаж вэ?

- Хөнжлөө толгой дээгүүрээ нөмөрчихсөн л юм шиг байна гэх дуулдлаа. Юун ч уужуухан юм билээ хэмээн Дэмбэрэл бодож жуумалзсанаа: Агаар ямар байна?

- Болж байнаа. Том чулуу шаврынх нь завсраар агаар орж ирээд байна. Та яаж вэ? Зүгээрээ. Бөгс жаахан дарагдсан бололтой гээд сая өөрийнхөө байдлыг санан анзаарвал шороо цээж рүү нь мэдэгдэхүйц ахисан байлаа. Дэмбэрэл эрүүгээрээ газар тулан хоёр гараа нуруу руугаа явуулан гар хүрэх газрын шороог хоёр тийш нь буулгалаа.

Одоо ингэж л цээжээ булуулахгүйг хичээхээс өөр арга түүнд байсангүй. Мастераа? Гэх Намхайн дуу ажээ.

- Юү гэв? Намхай?

Аврахынхан бидэн дээр аль хэр удаж ирэх бол? Дэмбэрэл тэр даруй хариулчихаж чадсангүй. Нуралтанд дарагдсан хүний амь аварна гэдэг Намхайн бодож байгаа шиг тийм амархан ажил биш гэдгийг Дэмбэрэл яс махаараа мэдэх билээ. Түүний нүдэнд даргынх нь "Өөр ямар арга хэмжээ авах билээ" гэж бодлогоширсон нүд, ерөнхий инженерийнх нь "Энэнээсондоо түргэн

хүрэх арга байхгүй" гэсэн шийдмэг харц, нөхдийнх нь гэнэтийн түгшүүрт цочин мэлэрсэн царай харагдах шиг болов. Нурултын байдлыг багцаалахад нэлээн том бололтой. Ядаж бид шөнийн ээлж шүү дээ.

- Тэгвэл удах нь ээ.

- Удалгүйдээ. Тэгтэл тэр хоёрын яриан дундуур Түвшин орж,

- Намхай? Гэж дуудав.

- Юү?

- Чи юунд яараа вэ? Болзоотой юү?

- Ядаж байхад битгий марзагнаад бай.

- Чи яаж байна?

- Хавчуулагдаад үхэх гэж байна.

- Тэснээ хөө.

-Чи яаж байна?

- Унтмаар байна, нойр хүрч байна.

- Хн.

Тэр хоёрыг чимээгүй болмогц Дэмбэрэл мөнөөх гоожиж байгаа шорооныхоо чимээг чагнахаар анирдвал юү ч дуулдсангүй. Чихэндээ итгэж ядан цээжээ өндийлгөн байж чагнав. Ер чимээ алга. Дээрээс шороо гоожих нь зогсчээ. Дэмбэрэл аюул бүхий ард гарсан мэт уртаар санаа алдан, хатуу газар самардсаар юманд хүргэж болохгүй болтлоо хөндүүр болсон хурууныхаа өндөгний чимчигнэн өвдөж байгааг сая мэдэрч, энэ их нуранган дороос яаж ч зүтгээд бөгсөн биеэ сугалж авч чадахгүйгээ, яаж ч сарвайгаад бэхэлгээний багананд хүрч барьж чадахгүйгээ мэдсээр байж юунд хуруу хумсаа хугачин хугачин зүтгэв ээ.

Ер нь хүн гэдэг бүтэхгүй юм руугаа зүтгэн хамаг хүч, цаг хоёроо дэмий барсны эцэст цөхөрсөндөө сая болох бүтэхгүйг ухаардаг амьтан юм санж уу хэмээн бодоод,

- Түвшин гэж тайвнаар дуудлаа.

- Аа?

- Яаж байна?

- Хэвэндээ.

- Агаар?

- Амьсгалж болоод л байна.

- Тэгвэл чи наадахынхаа дороос сугарч гарах гэж тамираа битгий бараарай. За. Над шиг эрдийлж босохоор ч үгүй бололтой. Уг нь жааханд өндийж, шигшиж доогуураа шороо хийсэн байгаад ил гарчихья гэж санасан юм. Барах хоол биш бололтой.

- Битгий хөдөл. Аль болохоор хүчээ гамна. Дэмий уухилаад байх юм бол наад агаар чинь ч хүрэхгүй болно.

- Одоо хөдлөхгүй ээ.

Дэмбэрэл ямар нэгэн хариу хэлэх гэсэн боловч хэлэх үг түүнд олдсонгүй. Юу ч хэлэх юм билээ. Хамаг хүчээ дэмий шавхчихсан хойно нь хүчээ гамна гэж мянга захиад яах юм. Боломжтой байхад нь хэлж чадаагүйгээс хойш, энэ бол ёстой илүү зан. Хүн бүдрэнгүүтээ наана чинь гэж арынхаа хүнд хэлж амждаг сан бол юү гэж арынх нь хүн түүний бүдэрсэнд бүдрэх вэ дээ. Бүдэрдэг юм гэлээ гэхэд түүний бүдэрснээс өөр юманд бүдэрнэ шүү дээ. Хүн гэдэг хэрэг нь өнгөрсөн хойно сургах дуртай амьтан юм даа. Өөрөө жар хүрсэн хойноо залуу зандан насаа дэмий битгий өнгөрүүл гэж дөч хүрч яваа хүүдээ захиж сургахтай адил юм их болох юм даа. Бид гурвын энд ингээд хэн, хэзээ ирж аврах нь вэ гээд хэвтэж байгаа маань ч гэсэн энэний л үлгэж болж байгаа нь тэр. Өч төчнөөн нуралтаас зайлж гарч байсан хэрнээ нурахын өмнө ямар шинж тэмдэг мэдэгддэг, нуралтаас яаж зайлж гардгийг нэг удаа ч гэсэн эдэнд хэлж өгсөн бол ийм хэрэг болоо ч үү үгүй ч үү хэмээн эрэгцүүлэн бодож хэвтсээр нэг хэсэг унтжээ.

Сэрвэл бөгсөн бие нь мэдээ алдан бадайрч ууц нуруугаа янгинан өвдөхөөр сэрсэн бололтой. Одоо л нохойтох нь дээ гэж Дэмбэрэл бодон цээжээ өндийлгөн цогнойж тэгснээ больж газар элэглэн тэрийн хэвтэж, тэгснээ дахиад өндийн цогнойж, дахиад хэвтэх мэтээр хөлсөө чийхэртэл хөдлөв. Овоо ч болох шиг. Юутай ч нэг онь өвдөх нь мартагджээ. Хаа юун дээр ч билээ өвчний ихэнх нь хүний сэтгэлээс үүддэг бөгөөд тэнд энд өвдөж байна гэж бодмогц тэр газар нь өвчний төв бий болдог. Энэ мэтээр огт өвчингүй газраа хүртэл өвчний төв бий болгон эрүүл газраа өвчлүүлдэг тохиолдол байдаг тухай нэг эрдэмтэн бичсэн байсныг уншсанаа тод саналаа. Тэгэхээр би ууц нуруундаа өвчний төв бий болгож болохгүй байх нь байна шүү гэж бодсоноо үнэн ч юм уу, худлаа ч юмуу тоглоом тохуу шиг юманд хүүхэд шиг итгэж суух ч гэж дээ. Тэртэй тэргүй ийм байгаа ууц нуруу чилж өвдөх ч ёстой. Өвдөж ч байгаа юм чинь хэмээн түрүүчийнхээ бодлыг үгүйсгэв. Гэтэл садаарч байсан түрүүчийн бодлоо үгүйсгэсэндээ ч тэрүү, ер өвдөж байгаа юм чинь гэж бодсондоо ч тэр үү ууц нуруу нь дахиад л тэсэхийн аргагүй чилж шахирч эхлэв.

Болдогсон бол түр зуур ч атугай дээшээ хараад хэвтэх сэн. Үгүй ядахдаа, хажуу тийшээ харан хөлөө атираад хэвтэх сэн.. Ингэж тал биеэрээ тамд унаснаас битүү даруулчихсан бол ч бас арай дээр байх байсан болов уу. Ядаж гэдэргээ хараад дарагдчихсан бол юү гэж ууц нуруу чилэх вэ. Үгүй ээ аль болохоор садааруулах хэрэгтэй. Түүнээс эрхэм юм байхгүй. Тэгэхээр л өнөө эрдэмтний бичсэн үнэн байх нь Бидэнтэй адил биш. Эрдэмтэн хүн гэдэг өч төчнөөн удаа туршиж, шинжиж байж гэмээн тийм юм бичсэн байж таарна. Инээх ёсгүй үед инээд

хүрэхэд ээжийнхээ царайг саначихаар инээхээ больдог гэж ардын үг ч энэнтэй холбоотой. Ийм байгаа ууц нуруу өвдөх ёстой гэснээс л хамаг хэрэг үүдэж байгаа хэрэг. Өвдөж байгаагаа мартаж, аль болохоор садааруулах хэрэгтэй гэж өөртөө хэлж сэтгэлээ чангалахыг оролдов. Гэвч санасны зоргоор ууц нурууных нь шархиран өвдөж байгаа мартагдахгүй байлаа. Мартаж ёстой гэж л бодсоноос яаж мартахаа Дэмбэрэл мэдэхгүй байв. Ерөөсөө түүний гол алдаа ч энэ юм шиг санагдана. Өч төчнөөн жил ээлжийн мастер хийхдээ анзаараагүй явсан алдаагаа одоо л ухаарч буй мэт бодогдоно. Дамаан сүүлийн жилүүдэд "Төлөвлөгөө биелүүлэх хэрэгтэй" "Бэхэлгээг сайн хийх хэрэгтэй..." "Хэрэгтэй" "хэрэгтэй" гэхээс яаж биелүүлэх арга зам, хэрхэн бэхлэхийг зааж сургах, хэлж зөвлөхөөсөө дарга нарын тушаал шийдвэрийг дамжуулагч болсноо гашуунаар мэдрэн, энэ бодлоо нөгөө хоёртоо ярьж сэтгэл санаагаа тэнийлгэе гэснээ унтаж байгаа байх даа. Хэдэн минут ч гэсэн унтаж цаг хороох нь дээр гэж бодон өөрөө ч гэсэн гараа дэрлэн хэвтэв. Нойр нь хүрэх янзгүй. Нэгэн бол чимээ чагначихсан, нэгэн бол биеэ чагначихсан байх учир ийнхүү чимээгүй хэвтэнэ гэдэг улам ч хэцүү ажээ. Чимээ сонсогдох болоогүйг мэдсээр атал анир чимээгүйгээс ямар нэгэн авиа олж сонсох гэдэг пад харанхуйн дунд юм олж харах гэж чармайхтай ижил бөгөөд харанхуй анир чимээгүй хоёр ганцаардалтай нийлэхээрээ хүний сэтгэлийн шөрмөсийг тас мэрэх билээ. Дэмбэрэл яагаад ч юм дээрээс шороо гоождоогоороо гоожиж байсан болоосой гэж бодон хэвтгэл хүн ёолох дуудав. Өндийн чагнавал Намхайн байгаа чигт байгаа тул Дэмбэрэл, Намхай? Юу? Яав? Хөл тасрах нээ. ёо ёо...

- Тэсч үз, Намхай минь. Ёолох тусам улам дор болно.

- Хэлэх амархан.

- Тийм ч байхаа даа.

- Танд өвдөх юм байхгүй юм чинь та юугаа мэдэх вэ.

- Чи аль болохоор мартахыг... юү яалдаа... хөл өвдөж байна гэж битгий бод. Өөр... сайн сайхан юм бодохгүй юү.

- Хн. Аврахынхан ирж явна. Хүрз жоотуу нь хангинаж байна гэж үү?

- Тэр нь ч юү юм. Орчлонд тэрнээс өөр сайн сайхан юм хаа мундах вээ дээ.

- Тэгвэл надад тэрнээс өөр бодох санах юм алга.

- Бий дээ. Чи мартаад байх шиг байна. Тэрийг ч мартаж болохгүй байх шүү гэж тэр хоёрын дундуур Түвшин орж ирэв.

- Ямар юм?

- Эрдэнэцэцэг

- Хн. Тэр хар банзлаар яадаг юм. Аан? Банзал. Тэрэн шиг банзал амьтан хаа ч байхгүй.

Түвшин дуугүй болов. Дэмбэрэл тэр хоёрын яриаг чагнаж байснаа яагаад Намхай

Эрдэнэцэцэгийг "Банзал" гэж хэлснийг гайхав. Эрдэнэцэцэг бол уурхайд агаар хэмжигч хийдэг даруухан, царайлаг охин. Эх, хоёр дүүтэйгээ дөрвүүл суудаг. Элдэв хэл аманд ер орооцолддоггүй л юмсан. Намхай оролдож, цаадах нь дургүйцэж дээ. Тэгээд л тэгж байгаа юм. Манай зарим залуус хөөцөлдөөд бүтэхгүй болохоороо өширдөг юм уу яадаг юм тэр бүсгүйгээ муу хэлэх дуртай болчихож. Энэ уг нь муу л хэрэг. Ийм юмыг ийм үед хэлэлтэй ч биш. Ер нь бол сүүлд Намхайд хэлэх хэрэгтэй юм. Эцсийн эцэст энэ бүхэн үнэхээр дурласан уу зүгээр шохоорхсон уу гэдэгтэй ч холбоотой байж мэднэ. Ер нь тэгээд мастерууд бид эдний гарт нь хүрз бариулах гэж ноцолдохоос толгой тархи, сэтгэл санаанд нь юу хийх вэ гэдгийг бодох ч үгүй юм.

Эд маань ч биднийгээ тэр талаар тоох ч үгүй болж дээ. Зүй нь бид мэтийн он удаан жил ажиллаж нэг байрнаасаа хөдлөхөө болчихсон мастерууд эртхэн учраа хэлээд мэдлэг чадвартай залуу хүмүүст байраа тавиад өгчих хэрэгтэй юм л даа. Даанч тэгж хэлээд гарчих зориг бидэнд байхгүй юм. Хэдэн төгрөгний ахиу дөхүүг ч боддог юм уу, хэд гурван хүн ахалж байх нь ч аятайхан байдаг юм уу, чадахгүй гэж хэлж чадацгаахгүй юм. Уг нь "Хоцрогдсон амьтан" гэж хэлүүлээд явж байхаас дээр л баймаар юм даа. Дарга нар ч гэсэндээ. Олон жил ажилласанд нь өрөвддөг юм уу, хар муйхраар зүтгүүлээд төлөвлөгөө нормы нь биелүүлээд байдагт нь санаа амардаг ч юм уу биднийг ингээд л байлгаад цаг алдаад байх юм. Цаг алдах тусам шинэ сэргэг юм санах сэдэхээ болчихоор барахгүй харин тийм юманд саад тээг болдон амьтан болж хувирах юм. Ухаандаа нэгдсэн бригад байгуулах тухай янз бүрийн санаачилга гарч ирээд л байгаа юм. Уг нь ашигтай, хэзээ нэг цагт үйлдвэрлэлд нэвтрэх ёстой санаачилга гэдгийг мэдсээр хэрнээ би дургүйцсэн. "Ашигтай тун хэрэгтэй сайхан санаачилга. Гэхдээ одоогийн нөхцөлд үйлдвэрлэлд нэвтрүүлэх болоогүй" гэдгээр л татгалзсан. Болоогүй эрт байна гэдэг чинь түүнийг биелүүлэхэд гарах бэрхшээлээс л айж байгаа хэрэг. Эхний удаа шинэ санаачилга мэтээр үйлдвэрлэлд нэвтрээд, нэвтэрсэн даруйдаа бусад ээлжинд туршлага болон дэлгэрээд, сүүлдээ энэ нь ээлжийн мастериин хийх ёстой бас нэг үүрэг болно гэдгээс л би айсан хэрэг. Үүгээр бодоход ажлаас бэрхшээгээд айгаад ирэхээрээ л хүн хоцрогдож эхэлдэг бололтой. Би ер нь их аймхай хүн юм даа. Заримдаа ийм тийм юм санаад сэдээд хийчихье гэж бодсоноо за яршиг хүн муу хэлэх байх. Энэ Дэмбэрэл чинь ер яасан хэнхэг болчихоо вэ? гэх ч юм болох уу, эсвэл Дэмбэрэлийн тэр нэр алдарт дуртай гэдэг үү, хардаа. Нэг юм санаачилсан болж мандах нь гэх ч юм болов уу гэж хүртэл бодно гээч. Гэтэл хүнд муу хэлүүлэхгүй төлөв томоотойгоороо юү бүтээв? Буруу юм. Хүн амьтан юү гэх бол гэж л амьтны аясаар явна гэдэг эцсийн эцэст өөрийн бодолгүй л хүний явдал. Би тийм гэжүү? Надад өөрийн гэсэн бодол байхгүй гэж үү? Одоо дөч гарлаа. Ухаан санаа, бие цогцос жигдэрч ирдэг бол ирдэг нас. Би ер нь өдий хүртэл юү бүтээв? Би энийг хийсэн юм гээд хүнд заачих юм надад юү байгаа юм. Хэдэн тонн нүүрс л газар дороос гаргаа биз. Өөр? Өөр юү ч хийсэнгүй. Гэтэл сургуульд байхдаа юү гэж хүсч мөрөөддөг байлаа. Хар нялхын хүсэн мөрөөддөг байсан баатарлаг гавьяа хаачсан бэ? Орчлон ертөнцөд нээгдээгүй гайхамшигийг нээх минь яалаа? Аль эсвэл би чинь амьдралын аар саархнаар хөөцөлдсөөр хүсэл мөрөөдлөө орхисон байх нь үү гэхчлэн элдвийг эргэцүүлэн бодно. Ингэж элдэв бодлоор ууц нурууныхаа тэсэхгүйеэ бэрх өвдөлтийг мартагнуулахыг оролдоно. Заримдаа бодлыг нь таслан, хамаг ухаан мэдрэлийг нь өвдөж янгинаж шархирч байгаа тэр газар эрхэндээ авч зөвхөн өвдөхийг мэдрүүлэхээс өөр юү ч бодуулахгүй, өөр юуг ч анхааруулахгүй байлгахын эрмэлзэх мэт. Ийм үед Дэмбэрэл өвчнөө дийлэх тэнхээгүй өчүүхэн амьтан гэж хий л өөрийгөө зэмлэх ажээ.

- Хөөе мастераа гэх нь Намхай ажээ.

- Юү гээвээ?

- Тэсэхгүй нь ээ.

- Тэсэх л хэрэгтэй.

- Хэрэгтэй гэнэ шүү. Та нар ер нь хэрэгтэйгээс өөр юу мэддэг юм. Хэрэгтэй гэдэг чинь та нарт хэрэгтэй байдаг юм бол надад ч бас хэрэгтэй байдаг.

- Чамд юу хэрэгтэй байгаа юм?

- Надад амь нас минь хэрэгтэй.

- Тэр чинь бидэнд ч хэрэгтэй.

- Хаа байна, тэгээд тэр аврахынхан чинь. Хэрэгтэй юм бол өдий болтол ирээд авчихгүй яасан бэ?

- Ирж л яваа даа.

- Энэ янзаараа бол биднийг үхсэн хойно л ирж авах байх даа. Энэ үгэнд Дэмбэрэлийн уур дүрсхийн асч,

- Чи юү ярьж байгаа юм. Чи эртэй сайндаа энд булагдаа юү. Өөрийнхөө мууд, өөрийнхөө нүд хуурсан ажлаасаа болоод өөрөө өөрийгөө булчихаад юу гэж галзуураад байгаа юм. Чиний нүр хуурсан ажлаас болоод улсын хичнээн их хөрөнгө хий үрэгдэж, хичнээн хүн хар хөлсөө шавхан чамайг амьд авах гэж хоосон шороо хүрздэж байгааг чи мэдэхгүй хэвтэж яасан их шалчигнадаг юм. Ер нь чам шиг ийм амьтныг авсан ч яадаг юм. Байсан ч чи бид хоёроор л улс дугав гэж.... Дуугүй болцгоов. "Тэнэг солиг. Ёстой над шиг ийм тэнэг амьтнаар л улс дугав гэж, чам шиг ийм амьтныг авсан ч яадаг юм, байсан ч яадаг юм гэчихсэн шүү хөөрхий. Гомдоо байгаа даа. Хн. Уурын мунхаг гэдэг үү. Ийм л юманд хүргэдэг дээ" хэмээн дэмий үг хэлж Намхайг гомдоочихлоо гэж Дэмбэрэл өөртөө уурсан, аргадыа гэтэл арга эвээ олохгүй гурвуул хэсэг чимээгүй байтал Түвшин,

- Намхай? Гэж аяархан дуудлаа. Намхай дуугарсангүйд Түвшин,

- Дуугараач өвгөөн. Чимээгүй байхаар улам хэцүү юм. Чи яаж байна?

- Гайгүй ээ хөө. Аа. чи?...

Дэмбэрэл Түвшинд баярлан, "Түвшинг ийм хүн гэж итгэж явсан юм. Хүний эвийг ингэж аятайхан олдог ийм л хүнээр ээлжийн мастер тавих хэрэгтэй" хэмээн бодож дотор нь уужирсан янзтай амьсгаагаа уртаар авлаа. Намхай, Түвшингийн асуултыг дуулаагүй юм шиг дуугүй байснаа,

- Юү ч гэх юм дээ. Яагаад ч юм надад эндээс амьд гарч чадахгүй байх гэж бодогдоод байх юм.

- Муу эр долоо үхдэг гэдэг чинь л тэр байх даа.

- Тийм л байх. Ядаж дуулганы гэрэл түрүүн унтарчихлаа.

- Миний энд та хоёрын дуунаас ондоо хань болох юм ер алга.

- Чи нээрэн битүү дарагдчихсан юм уу?

- Тийм.

- Хэцүү байна уу?

- Гайгүй ээ. Намхай юү хэлэхээ мэдэхгүй чимээгүй болоход Түвшин ч нэмж үг хэлсэнгүй. Дэмбэрэл тэр хоёртой ярьюү гэж бодсоноо хэнтэй нь эхэлж ярихаа мэдэхгүй түдгэлзэв. Түвшинтэй бол юү ч ярьж болох атал Намхай улам гомдчихоос гадна ам муруйснаасаа болоод өөртэйгөө ярихгүй байна гэж бодоход хүрнэ. Гэтэл Намхайтай ярина гэхээр юү ярихаа мэдэхгүй байлаа. Тэгтэл Түвшин дахиад л Намхайг дуудав. Юү? Мастерт битгий гомдоорой өвгөөн. Би гомдоогүй ээ.

- Аа... чи мастерийг яагаад энд байна гэж бодож байна? Мэдэхгүй.

- Цаадах чинь "цаанаас чинь" гэж хашгираад бид хоёр руу үсэрсэн юм. Тэнэг юм.

- Яагаад?

- Амьд гарч болох байж шүү дээ. Тэгсэн бол өдийд авгайгаа...

- Чи үнэхээр амьд гарч чадахгүй гэж бодож байна уу?

- Чадахгүй юм чинь.

- Тэр чинь л муу даа.

- Юү?

- Тэгж боддог чинь.

- Би ер нь хэзээ ч тэгж боддоггүй байсан юм.

- Чи "Болд хэрхэн хатаагдсан"ыг уншсан уу?

- Уншсан. Сайхан шүү. Би хоёр удаа уншсан.

- Павел чинь Тонятайгаа суудаг билүү?

- Үгүй.

- Аа тийм. Нэг баян амьгантай суучихдаг л даа. Төмөр зам тавьж байхад нь дайралддаг байхаа? Павелтай суугаагүй нь болсон юм.

- Яагаад?

- Хачин юм шүү. Би уншиж байхдаа Тоняд дуралчихаад бараг Корчагинаас харамладаг байж билээ.

- Хн. Тоня чинь орос хүүхэн билүү?

- Орос байлгүй яахав.

- Хөөний эрээ чи. Аягүй бол хар хүүхэнд дурлах байхаа.

- Яадаг юм. дурлахад.

- Худлаа л даа.

- Юү худлаа гэж?

- Чиний ярьж байгаа худлаа. Би чиний хэнд дурладгийг мэднээ. .. хоёулаа чимээгүй болчихов. Дахиад л дор дороо элдвийг бодон, ямар нэгэн чимээ олж сонсохыг эрмэлзэн, бүхий бие цогцсоороо анирдаад юү ч олж сонсолгүй мөнөө бие сэтгэлийн шаналалдаа буцаж ирнэ гэдэг тэдэнд улам хүнд болж байлаа. Тэр хоёрын яриаг бүрэн гүйцэд ойлгохгүй ч гэсэн хүний яриа чагнаж хэвтэхэд агаар ч дутагдаж байгаа нь мэдэгдэхгүй, гэрэл гэгээ ч үгүйлэгдэхгүй байх шиг Дэмбэрэлд санагдсан бөгөөд чимээгүй болмогц аюумшиг төрж өөрийн эрхгүй чимээ чагнан тэднийг аврахаар нойр хоолгүй зүтгэж яваа нөхөд нь одоо ирчихсэн яаж "хүрз амрахгүй" ажиллаж байгаа, хэний хөлс бэрзээнтэн цамцаа нэвт цохичихсон байгааг мэдэж байгаа хэрнээ яасан их удах юм. Арай буруу ухаад явчихаагүй байгаа, тэднийг ирэхэд бид гурав амар мэнд байх болов уу, үгүй болов уу хэдэн хүүхэд минь яаж шүү байгаа бол өдийд муу эхнэр маань нөгөө хэдийгээ дагуулаад ирчихсэн уурхайн ам сахин усан нүдлээд сууж байгаа даа гэхчлэнгийн аль л болохгүй бүтэхгүй бүхэн бодогдох болов. Энэ мэт сэтгэл тарчилгасан бодлыг үргээх юм яриа хөөрөө атал мөч өнгөрөх тусам ярих дургүй болж байв.

Газар дээр яваа хүн хэрхэн амьсгалж байгаагаа анзаардаггүй шигээ юм ярихад ямар их хүч тэнхээ ордгийг мөн анзаардаггүй байжээ. Гэтэл энд үг бүхэн сэтгэлийн ёроолд живчихсэн юм шиг гаргаж хэлэх бүр бие сульдаан ихээхэн ярихаар толгой эргэдэг болов. Хүчээ хямгадахын тулд тэд цөөн дуугарч жигд амьсгалах хэрэгтэй байлаа. Энийг нөгөө хоёртоо хэлье дээ гэж зэхэн үгээ эвлүүлж ядан байтал нь Намхай Хөөе Хөөе. Хэмээн сандран дуудав. Аа? Яав?

- Чимээ. Чимээ гарч байна. Тэд чих тавин чагнацгаатал Намхай, Тийм байгаа биз?

- Байз л даа. Та дуулахгүй байна гэж үү.

- Үгүй чи дуугүй байгаад өгөөч... Тэд дуугүй болцгоон чимээ чагнацгаалаа. Үгүй байнаа гэснээ Түвшин: Танд юм дуулдаж байна уу? Гэлээ.

Дэмбэрэл хэдэн агшин дуугүй байснаа:

- Үгүй юм шиг байна. Одоо дөхсөн. Гэхдээ битгий чагна, байнга чагнаад байхаар амархан цөхөрнө гээд Намхайг хариу хэлэх болов уу хэмээн чих тавин хүлээсэн боловч Намхай дуугарсангүй. Түвшин ч үг дуу цөөнтэй болжээ. Дэмбэрэл гараа дэрлээд чимээгүй жаахан хэвтэх гэснээ тэр хоёрыг дуугүй байгаа явдалд сэтгэл нь зовиурлан ямар нэг юм ярьж сэтгэл санаагий нь өөд татах хэрэгтэй гэж бодон юү ярья даа хэмээн эрэлхийлснээ "Хорыг хороор" гэсэн юм санаанд нь орж, Хөөе. Юү?

- Яав та хоёр дуугүй болчих чинь. Яацгааж байна?

- Гайгүй ээ.

- Агаар ямар байна?

- Муу муу.

- Гайгүй гэх боловч Түвшингийн дуу холдчихсон юм шиг алс бөглүү тамирдангүй сонсогдов. Дэмбэрэл,

- Та хоёр намайг юү бодож байна гэж бодож байна гэхэд хоёул чимээгүй азнаснаа Намхай,

- Эхнэр хүүхдээ л биз.

- Үгүй ээ, үхлийн тухай бодож байна гэхэд түрүүнээс хойш дуугүй байсан Түвшин, Та тийм дэмий юм битгий бод.

- Дэмий бишээ. Энэ тухай хүн заавал боддог байх хэрэгтэй. Үүдэнд нь очихоосоо өмнө очно гэдгээ бодох нь дээр,

- Үгүй ээ, дэмий байх хэзээд л үхэх юм чинь гэж бодохоор амьдрах сонирхолгүй болчихдог юм.

- Бодоход учир бий. Үхлийн тухай огт бодохгүй явсаар насны туйлд өөрийн эрхгүй өнөөхтэйгөө тулгарах шиг аюул байхгүй. Тэрний оронд үхнэ гэдгээ бодож хэзээ ч үхэхэд бэлэн байх ёстой. Тэгж гэмээн хүн хүндээ муу юм хийхгүй. За санамсаргүй хийдэг юм аа гэхэд түүнээ цайлгах, сайн үйлс хийхэд яарах болно. Хүнд сайныг хийхийг яарах болно. Тэгэхгүй бол үхэхийн цагт тэрэнд муу юм хийчихсэн юмсан. Энийг гомдоочихсон юмсан гэж харамсан сайныг хийе ч гэсэн цаг байхгүй тэнхэл ч байхгүй болчихно шүү дээ гэхэд Намхай,

- Та олон хүн гомдоосон уу.

- Гомдоосон. Түрүүхэн хүртэл чамайг... Би гомдоогүй. Миний буруу. Гэлээ ч гэсэн би эвгүй үг хэлсэн.

- Зүгээр, тэр байтугайг би дуулсан. Өдий хүртлээ орчлонгийн бараг муу үг бүгдийг сонссон байх.

- Чи үнэхээр гомдоогүй юү.

- Үгүй ээ. Харин би таныг их гомдоосон.

- Хэзээ?

- Ноднинхон хүртэл би танд агсан тавьсан.

- Тэр яахав.

- Би тэр үедээ мэдээгүй. Маргааш нь манайхан намайг зэмлэсэн. Би таныг юү гэсэн гэлээ? Та санаж байна уу?

- Мартчихаж ээ.

- Худлаа. Та сайн бод доо. Дэмбэрэл нээрэн юү гэж хэлсний нь санахыг оролдсон боловч нэлээд ярьсандаа толгой нь эргэн бие нь эвгүйрхсэндээ ч тэр үү, аль эсвэл үнэхээр мартчихсан ч юмуу санаанд нь юү ч орсонгүй.

Гагцхүү түүний сэтгэлд Намхай шал согтуу гурван давхраас цонхоор үсэрч үхнэ гэж тэмүүлэн, нөхөд нь арай чамай тогтоон барьж байсан санагдана. Ноднин уурхайд ажилд орсон залуучуудын дотроос архи дарс уучихдаг, зодоон цохион хийчихдэг хүний тоонд Намхай ордог болохоор иймэрхүү юм алийг тэр гэх билээ.

- Нээрэн та санахгүй байна уу? Гэх нь Намхайн сэтгэл хөдөлсөн шинжтэй.

- Үнэхээр мартчихаж.

- Би таныг "Үхэж далд ор" гэж хараасан шүү дээ.

- Хэцэс.

- Та тэр үедээ анзаараа ч үгүй биз одоо бодоход их муухай үг юм. Би ер нь хүнийг дандаа гэж тэгж хараадаг. Ээжийгээ хүртэл тэгж хараадаг.

- Тэр ч болохгүй шүү.

- Муухай муухай. Амьд мэнд гардаг бол ч муу ээжийгээ баярлуулнаа.

- Гарах эсэх чинь чамаас л шалтгаална.

- Үгүй ээ, та бидний амь нас хүний гарт. Тэд аварч чадвал чадна. Чадахгүй бол чадахгүй. Бид яах юм. Хэрвээ өөрсдөө ухаад төнхөөд маажиж малтсаар байгаад гарчихдагсан бол өөр хэрэг. Яах юм? Үхлээ хүлээхээс өөр яах юм? Энэний оронд усгүй цөлд хаягдсан болоосой.

Эцсийнхээ тэнхээг тасартал ус эрж яваад үхэх сэн. Ядаж гомдолгүй шүү дээ.

- Үгүй хөө. Амь нас маань бидний гарт байгаа шүү. Хүн гэдэг биеийн тэнхлээс гадна сэтгэлийн их тэнхээтэй амьтан. Сэтгэл шиг шавхагдашгүй нөөц бидэнд байх ч үгүй.

- Надад л юу ч байхгүй дэг.

- Байлгүй дээ.

- Над шиг амьтанд юу байхав дээ. Ядаж өөдтэй явсан биш.

- Хамгийн чухал нь амьд гарна гэдэгтээ бат итгэх.

- Би итгэж байсан. Гэтэл цаг мөч өнгөрөх тусам амьд гарахгүй юм шиг санагдаад байх боллоо.

- Амьд гаралгүй яахав. Энэ бол гарцаагүй амьд гарч болох тохиолдол. Биднийг дарагдчихсан гэдгийг манайхан тэр дороо мэдсэн гэдэг мэдээж. Биднийг авахаар айсуй гэдэг мэдээж байхад чинь яагаад итгэл алдах билээ.

- Уг нь тийм л дээ. Гэхдээ одоо дөхсөн гэж бодоод л чагнахаар огт чимээ гарахгүй юм. Тэгэхээр чинь л ...

- Дөхөх тусам нь итгэх. Төдийг нь давчихсан юм чинь одоо юүхэн байх вэ. Бага л хугацаа үлдэж байгаа гэж зоригоо чангалаад Түвшингийн хэлдгээр аль болохоор сайн сайхан юм бодож, аль болохоор хүч тэнхээгээ хямгадах хэрэгтэй. Чи бид хоёрын ингэж дэмий ярьдаг ч муу. Ярихаар бие улам сульдана. Жаахан ярихаар чиний толгой эргэж байгаа биз.

- Нэг их мэдэгдэхгүй байна. Таных эргэж байна уу?

- Эргэж байна.

- Тэгвэл та битгий ярь. Түвшин?

- Аа?

- Чи яаж байна?

- Гайгүй ээ.

- Ярихаар чиний толгой эргэж байна уу?

- Эргэж байна.

- За тэгвэл дуугүй байцгаая...

Дуугүй болцгоов. Тэдний амьд байгаагийн баталгаа болсон үг яриа тасармагц бүгчим,

аниргүй, харанхуй дахин тэднийг нөмрөн авч орчлонгийн гэрэл гэгээ, хүн зоноос нуун, өөрийн мөнхийн харанхуй руугаа зугууханчирэх мэт санагдах бөгөөд тэрхүү аюумшигт харанхуйтай бие цогцос нь хүртэл нийлчихээд зөвхөн зүрх нь харанхуйн бат бэх цайзны ханыг дэлдэн байх мэт санагдах ажээ. Дэмбэрэл толгойнхоо эргээг гаргаж, дотроо уужруулахын тулд духаа нойтон газар наан, чимээ чагнан хэвтэхдээ саяныхаа ярьсан яриаг бодож ядарч сульдаж байгаа ч гэсэн хүнд хэлэх юмтай байсандаа сэтгэл өег байлаа. Тэр ч бүү хэл сэтгэлийн тэнхээний тухай дахиад яримаар санагдав. Эцсийн эцэст сэтгэлдээ аль хэр их юм хурааж вэ, түүнээ хэдэн хүний зовлонг нимгэлэхэд зориулж вэ гэдгээр нь тэр хүний хэрхэн амьдарч вэ гэдгийн хэмжээ гарч ирэх ч юм шиг бодогдоно. Сэтгэл санаандаа агуу их нөөцтэй, асар ихийг хураасан хүнд энэ мэт аюул юу ч биш. Тийм хүн зөвхөн өөрийгөө бус өөр бусад өч төчнөөн амьтны амийг аварч чадах билээ хэмээн бодож өөрийнхөө сэтгэл дэхийг дэнслэн хүнд хэрэгтэй юм ер нь надад юу байна хэмээн бодоход хомсхон бөгөөд өдий дөчин гурав хүртлээ сэтгэлдээ хураасан базааснаа бодоход чамлалтгүй санагджээ. Дөчин нас гэдэг гурван биенд элбэг хүрэлцэхээр сэтгэлийн тэнхээ бүрэлдэх нас. Гэтэл цаг мөч өнгөрөх тусам аюул ихэснэ. Тэгэхэд яах вэ. Дахиад хичнээн ч хүлээх болох юм? Хэн нэг нь осолдвол яах юм? Өөрөө осолдвол яах юм? Эдэндээ юу захиж вэ? Энэ бүгдийг бодчихсон байх хэрэгтэй гэж бодож байтал түүнийг хэн нэгэн хүн дуудах шиг болсонд өндийн чагнавал Намхай байв. Яаж байна та? Яахав ээ. Түвшин ээ. Аа. Чи яаж байна? Гайгүй ээ. Чи ч нэрэлхүү амьтан даа.

- Гайгүй ээ.

- Дуугүй байх хэцүү юм. Ганцаараа үлдчихэж ч байгаа юм шиг тийм байгаа биз? Аа хаа.

- Хүн ер нь ганцаардаж үхдэг байхаа. Ялангуяа над шиг ганцаар байж чаддаггүй амьтан. Одоо л бодоход би нэг ч удаа ганцаараа байж үзсэнгүй. Дунд сургуульд байхаасаа эхлээд л нийтийн байраар явчихаж. Чи тэгсэн үү?

- Үгүй.

Намхай, Түвшинг юм ярих байх гэж хүлээсэн үү хэсэг дуугүй байснаа,

- Та хоёр битгий дуугараарай. Би ярья. Тэгэх үү?

- Аа хаа. Тэг тэг.

- За байз юу ярих вэ гээд дуугүй болсоноо, За би та хоёрт үүх түүхээ ярья. Үүх түүх ч гэж дээ. Хүнтэй адил олигтой явсан биш. Юугаа ч ярих билээ. Архи дарс, зодоон цохион ярилтай биш. Гэхдээ би хүнээс ганц төгрөг ч хулгай хийгээгүй. Хүнд зодуулж ч зодож ч явлаа. Би нэг нөхрийг мөн муухай зодож билээ. Арай хамар амыг нь муруйлгачихаагүй байгаа даа. Юм их хачин юм. Урьд би ер санаж байгаагүй. Сая гэнэт тэр нөхрийг зодсоноо санаж байгаа юм даа. Бүр нүүр царай нь харагдаад байгаа юм даа. Би бол тэр нөхрийг хаана ч явсан танина. Тэр намайг одоо танихгүй. Уг нь зодсон нь мартаж зодуулсан нь мартдаггүй сэн... амар мэнд яваад хаа нэг газар дайралдвал олигтойхон тус хүргэчихээд чимээгүй зугтчих юмсан.

- Дэмбэрэл гуай та ер хүнд муу юм хийсэн үү?

- Уг нь хийгээгүй юм шиг л явдаг байж. Гэтэл одоо энд бодоод байхад... хийжээ. - Хачин юм аа. Би таныг хүнд муу юм хийх хүн биш гэж боддог.

- Тэгж бодох чинь л хүнийг алж байгаа юм. Бид ч ер нь тиймэрхүү л улс юмдаа. Хүнийг нэг сайн гэвэл түүнд байхгүй сайн сайхныг бий болгож бодоод байдаг. Муу гэвэл орчлонгийн бүх муу нөгөөхөөсөө эрээд байдаг. Гэтэл хүн гэдэг чинь алагтай булагтай байна шүү дээ.

- Тэгэхдээ та нэг их муу юм хийгээгүйдээ.

- Магадгүй чиний хийсэн муу юмнаас ч илүү их муу юм хийсэн байж мэднэ. - Тэр худлаа. Та архи ууж, агсан согтуу тавьж хүн зодож байсан гэж үү?

- Үгүй гэхдээ чи бол нэг хүн зодчиход цаадах чинь их л сайндаа гурав хоног булуу нүдтэй юм явна биз. Гэтэл хүнийг насан туршдаа зэрэмдэг сэтгэлтэй явахаар болгочихсон байвал яана. Хүний нэг насны амьдралыг үрэн таран хийчихсэн байвал яана.

- Та арай тийм юм хийгээгүй биз дээ?

- Арай үгүй байх л гэж боддог. Гэхдээ болзолгүй. Хүнд сайн юм хийж байна гэж бодоод хийгээд байсан хэр нь муу юм хийчихийг алийг тэр гэхэв. Ер нь хүн хийж байгаагаа хэлж байгаагаа ямагт цэгнэж, буруу биш байгаа гэж ямагт эргэлзэж байх хэрэгтэй. - Сайн юм хийчихье гэж бодоод муу юм хийчихсэн байхад ч гомдолгүй. Гэтэл тэгдэггүй юм даа. Дэмбэрэл гуай минь. - Ялгаагүй дээ.

- Ялгаатай гээд Намхай түр дуугүй болсноо,

- Та яаж мэдэх вэ дээ. Над шиг муу явж үзсэн биш. Адгийн наад зах нь л хүнд нэг алгадуулчихаад л оронд нь гурав алгадах юмсан гэж бодно гээч. Тэр байтугай миний муу муухай яваагийн буруутан этгээд тэр сайн сайхан, хиргүй тунгалаг яваа хүмүүс юм шиг бодогдоно гээч.

- Тэр чинь л харин хачин бодол байна даа.

- За тэр. Хэлээгүй юү. Мэдэхгүй гэж. Хэн ч мэдэхгүй. Орчлонгийн чинь энэ олон амьтны ихэнх нь сайн хүмүүс болохоор мэдэхгүй нь ч аргагүй л дээ. - Гэхдээ л гомдолтой санагдаад байдаг юм. - Юү нь гомдолтой гэж?

- Гомдох юм байлгүй яахав дээ. Магадгүй хамгийн их гомдсон хүмүүс ч байж мэднэ муу явахад чинь үгүйдээ л чи юү бодоов? Яагаад царай алдчихаав? Бие чинь зүгээр үү гэж асуух хүн олддоггүй юм шүү дээ. Ойрынх нь чичээд л, холынх нь дөлөө л байхаас.

Дэмбэрэлд хэлэх үг олсонгүй. Намхайг болчимгүй хөнгөн, ямар ч хэрэг төвөгт орчихож мэдэх залуу гэж бодож явснаас биш. Ийм юм бодож явдаг, бодсон санаснаа ингэж илэн далангүй ярих хүн гэж огт бодоогүй явжээ. Намхай түр дуугүй байснаа хариу ч хүлээлгүй,

- Би танд гомдож явдагтаа энийг ярьж байгаа юм бишээ. Уурхайд би ямаршуухан амьтан ирснээ, одоо ямар болчихоод явж байгаагаа мэдэж л байна. Та нөхдийн ачийг хариулаад

гийгүүлэхгүй ч гэхнээ одоо муу явахгүй ээ. Нээрэн шүү. Энийг л би танд хэлье гэж бодож явдаг байсан юм. Ашгүй хэлж амарлаа гээд дуугүй болов. Намхайн яриа түүний сэтгэлийг хичнээн их хөдөлгөж, санасан бодсоноо ярихын хүсэлд хичнээн их автсан хэр нь ярих тэнхэл түүнд байсангүй. Дэмбэрэл гараа дэрлэн хэвтээд өнөө болтол түүний өмнө буруутай гэж бодож яваагүй нэгэн танилынхаа тухай бодов. Хамт суралцаж, үерхэж нөхөрлөж явснаа хэдийд яагаад хөндийрч хэн нь ямар яваагаа хэн хэн нь тоохгүй болчихсоноо, архинд орчихсон гэдгийг нь аль эрт дуулснаа, одоо хаа яваагий нь ч мэдэхгүй байгаадаа харамсан "энэ хоёрын бодож байдаг, миний байж байгаа хоёр ч ёстой таарч дээ. Хүний санасанд хүрэхээр сайн явна гэдэг юутай бэрх" хэмээн өөртөө хэлж хэвтгэл: Дэмбэрэл гуай? Гэх Түвшингийн дуу тэр хоёрын яриаг таслав. Түвшингийн дуу түрүү түрүүчийнхээсээ хол алс бөглүү сонсогдоно.

- Яаж байна чи? яав? Түвшин. яаж байна?

- Би тэсэхгүй нь. Дотор бүгчимдээд. Би би... гэснээ чимээгүй болов. Намхай Дэмбэрэл хоёр сандран "Түвшин, Түвшин" хэмээн хойно урдаа орон бахиралдсан боловч Түвшин хариу дуугарсангүй. Намхай уйлагнан:

- Түвшин, найзаа тэс л дээ... Түвшин... Чи Эрдэнэцэцэгт хайртай шүү дээ... Би тэрий чинь мэднэ... намайг уучил... миний буруу... Би та хоёрын дундуур орсон... Эрдэнэцэцэг ч гэсэн чамд сайн юм байна лээ... Надад хэлсэн... Би чамд хэлж зүрхлээгүй... Уучил... Түвшин, Түвшин... хэмээн эхэр татан гиншлээ. Түвшингийн байгаа тэр чигээс ямар ч чимээ үл гарна. Дэмбэрэлийн хоёр нүдийг нулимс бүрхэн хоолой нь цахиртан зангирч,

- Түвшин. Хүү минь юу болов? Түвшин. Сэргэ хүү минь хэмээн цөхрөлтгүй дуудах авч хариу үл гарах ажээ. Намхай:

- Дэмбэрэл гуай, одоо яанаа? Үхчихлээ гэж үү дээ? Арай үгүй биз дээ? Хэмээн эрүүл солиотой нь үл мэдэгдэх дуугаар үглэн гиншинэ. Дэмбэрэл ч гэсэн ингээд үхчихнэ гэдэгт яагаад ч юм нэг л итгэж өгөхгүй дахиад л:

- Түвшин, Түвшин хэмээн хашгирч ихэд хүчлэн хашгирсандаа дотор нь балартан толгойгоо даалгүй духаараа газар мөргөн ойчоод толгойгоо өндийлгөө гэсэн боловч хэвтсэн тэр газар нь дайвалзан эргэлдэж, хаа нэгтэйгээс дуудах Намхайн дуу нэг балартан, нэг тодрон хариу хэлье гэвч чадалгүй хэсэг хэвтсэнээ сая хамаг биеийн тэнхээг хөвчлөн: - Аан гэж арай ядан дуугарав.

- Та яав? Яагаад дуугүй болчихов оо?

- Тэснээ гээд үгээ таслав. Тэгээд цааш нь тэсэх ёстойн тухай, нэг нь үрэгдсэн ч нөгөө нь түүнийхээ дутууг гүйцэхийн тухай ярих гэсэн боловч чадсангүй.

- Аан? Гэж арай ядан дуугарав.

- Та яав? яаж байна?

- Тааруу. Гэхдээ гайгүй гээд дуугүй болов. Дэмбэрэл цааш нь үг хэлэх гэсэн боловч бас л чадсангүй. Үхэл амьдралын заагт хань болж байсан нэг сайн нөхрөө үхчихсэн гэж бодохоос гол нь харлан ямар ч тус дэмжлэг болж чадаагүйгээ, нөхрөө аврах ямар ч чадал тэнхэлгүй хүчин мөхөс байгаадаа гутрав. Ээлжийнхээ ажилчдын дотроос Түвшинд илүү итгэж Түвшинг илүү хайрлаж байсан нь санагдан, юу юуны өмнө дэлгүүрийн манаач хөшин эцэг нь сэтгэлд нь буун яаж царай зүсий нь харна гэж санахаас халширна. "Яав даа даанч, муу Түвшингээ амьд аваатгаж чадсангүй юу. Муу Түвшинтэйгээ гурвуул амьд гараад ирж болсонгүй юу, хүү минь" гэвэл яана гэж бодохоос амьд гараад ч яах юм билээ гэсэн бодол гэнэт орж ирэв. Амьд гарсандаа ичиж зовж явсанд орвол эндээ үхчихсэн нь дээрч юм шиг санагдан, аврахынхан удаасай, саатаасай гэж анх удаа бодов. Энэ бодол нь амьд гарах гэж хамаг бие цогцос, сэтгэл санаагаа хөвчлөн байгаад гэнэт сулруулсан мэт байнга чимээ чагнан тарчилж байсан ой ухаан нь хүлээхийн зовлонгоос ангижирч, гайхалтай тайван болов. Түүний амьдрал мууг дуусахыг хүлээх, сайхныг ирэхийг хүлээх хүлээлт нэгээс нөгөөд залган огтхон ч амьсхийлгэлгүй хүлээхийн зовлон ирсний баяраар дүүрэн байсан мэт санагдлаа. Тэгтэл Намхайн цөхөрч гиншсэн дуу гарч нэгэн нөхрөө алдсаны гуниг, амь гарахын хүслэн, чимээ чагнахын зовлон хамаг биеийн шаналал энэ бүгдийг нь эргүүлэн авчрав. Одоо дахиад амьд гарахын тулд тэсэх, дуу чимээ өгөн, Намхайн голыг зогоох, завсарт нь газар элэглэн хэвтээд алсын чимээ анирдах хэрэгтэй болжээ. Амьд гарахын хүслэн эргэж ирснээс ч тэрүү. Түвшингийн чулуу мэт цэв хүйтэн болчихсон бие дэргэд нь бүр ойрхон, толгой гараа хөдөлгөхөд л хүрчих юм шиг санагдан айдас төрж өөрийн эрхгүй Намхайг дуудав.

Дуугарахаа болчихсонд нь мууг бодон, айж яах ч учраа болохгүй байсан Намхайн сэтгэл тайвширч,

- Ашгүй та, гайгүй юу гэж сандран асуув.

- Гайгүй дээ.

- Одоо яах вэ хоёулаа?

- Яах юу байх вэ. Амьд л гарахыг бодно доо гэхэд Намхай санаа алдан:

- За гэв.

- Айлын том нь байсан юм даа.

- Тийм ээ. Чи эцгийг нь таних уу?

- Танинаа. Ижийгээ нас барчихсан гэдэг байсан.

- Тиймээ зайлуул. Олон дүүтэй юм билээ.

- Чи бид хоёр амьд гарч дүү нарыг нь хоолонд хүртэл эцгийг нь өргөж тээх ёстой улс. Би таныг ч гэсэн ядарвал чинь тэжээнээ.

- Тэгээрэй. Хүн жаргал даадаггүй, зовлон даадаг гэдэг үнэн юм.

- Гэхдээ энэ бол зовлон бишээ хүү минь. Энэ бол амьд гарахын төлөөх л тэмцэл. Зовлон гэдэг өөрөө. Шал өөр... Гэтэл түүний үгийг Намхай тасдан:

- Байз. чимээ гарч байна уу даа...

- Тийм байна... чимээ гарч байна. Хөөе хүүе. Би энд байна хэмээн галзуурсан мэт хамаг хүчээрээ сөөнгөтөн бахирав. Дэмбэрэл чихээ газар наан чагнавал шавар байшингийн хананд хулгана торжигнож байгаа юм шиг чимээ сонсогдсонд Намхай шиг бахирмаар санагдсан авч хоолой дээр нь бөөн юм тээглээд дуугарч ч чадсангүй. Гагцхүү түүний зүрх энэ харанхуй хатуу хар чулуун цайзны ханыг дэлдэх мэт оволзон цохилж байлаа.